



# МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2006



Монголбанкны ерөнхийлөгч А. Батсүх

# Монголбанкны Ерөнхийлөгчийн УГ

## Эрхэмсэг ноёд хатагтай нараа,

Монголбанкны 2006 оны бодлогын хэрэгжилт, үйл ажиллагааг тусгасан жилийн тайланг та бүхэнд толилуулж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд 2006 оны мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хэрэглээний бараа, үйлчилгээний үнээр илэрхийлэгдсэн инфляцийн түвшинг 7.0 хувиас хэтрүүлэхгүй байна хэмээн тодорхойлсон байна. Үндэсний Статистикийн газраас гаргасан үнийн мэдээллээс үзэхэд инфляцийн түвшин 2006 онд 6 хувьтай гарсан нь мөнгөний бодлогын үндсэн чиглэлд заасан зорилтод түвшнээс 1.0 нэгжээр бага байна.

Өнгөрсөн онд эдийн засгийн гадаад орчин таатай хэвээр байсан бөгөөд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) өсөлт жилийн 8.4 хувьд хүрэв. Дэлхийн зах зээл дээрх нефть бүтээгдэхүүний үнэ өндөр хэвээр байсан боловч Засгийн газраас бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хазаарлах чиглэлээр тодорхой арга хэмжээ авсны үр дүнд жилийн инфляци харьцангуй доогуур түвшинд байлаа.

Тайлант онд улсын нэгдсэн төсөв 123.4 тэрбум төгрөг, урсгал тэнцэл 371.7 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Нэгдсэн төсвийн ашиг ДНБ-ий 3.9 хувь болсон байна. Төсөв ашигтай гарсан нь татварын орлого нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Монгол улсын гадаад валютын цэвэр нөөц 687.3 сая ам. долларт хүрч манай улсын импортын 24 долоо хоногийн хэрэгцээг хангахаар байна. Гадаад валютын цэвэр нөөц өмнөх оныхоос 2.3 дахин их байна. 2006 оны урьдчилсан гүйцэтгэлээр манай орны нийт экспорт 1528.8 сая ам. доллар, нийт импорт 1489.2 сая ам. доллар болж, гадаад худалдааны тэнцэл 39.6 сая ам. долларын ашигтай гарав.

Банкны системийн нийт актив өмнөх оныхоос 46.0 хувиар, нийт зээлийн хэмжээ 42.3 хувиар, нийт хадгаламжийн хэмжээ 48.2 хувиар, өөрийн хөрөнгө 42.4 хувиар өссөн бол банкны салбарын зээлийн чанарын үзүүлэлт болох чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэл эзлэх хувь 0.9 нэгжээр буурсан байна. Үүний дунд 2006 онд мөнгө, санхүүгийн салбарын гол үзүүлэлтүүд сайжирч, санхүүгийн зуучлалын гүнзгийрэлт үргэлжилсээр байна.

Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн чухал асуудал болоод байгаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд өөрийн хувь нэмрээ оруулах зорилгоор энэ төрлийн олон улсын байгууллагын гишүүнээр элсэх, энэ талаархи олон улсын конвенц, гэрээнд нэгдэх, үндэснийхээ хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлэх алхамыг хийлээ.

Цаашид “Инфляцийг онилох” мөнгөний бодлогын тогтолцооны суурийг тавих, санхүүгийн салбарыг хөгжүүлж, үйл ажиллагааг нь тогтвортой байлгахын тулд санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулах, санхүүгийн мэдээллийн алба болон эрсдэлийн удирдлагын албаны үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилтууд бидний өмнө тулгарч байна.

А. Батсүх  
Монголбанкны ерөнхийлөгч





# МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БУТЭЦ





# Монголбанкны захирлуудын зөвлөл



Ерөнхийлөгч  
А.Батсүх



Тэргүүн Дэд Ерөнхийлөгч  
Б.Энххуяг



Мөнгөний бодлого,  
судалгааны газрын захирал  
Д.Болдбаатар



Тамгын газрын захирал  
Б.Шатар



Хяналт шалгалтын газрын  
захирал  
Ж.Ганбаатар



Дотоод аудитын газрын  
захирал  
Г.Тогтохбаатар



Валютын газрын  
захирал  
Ц.Одонуга



Бүртгэл тооцоо,  
мэдээллийн технологийн  
газрын захирал  
М.Амгалан



Хуулийн хэлтсийн  
захирал  
Г.Эрдэнэбаяр



Ерөнхийлөгчийн зөвлөх,  
Лондон дахь суурин төлөөлөгч  
Д.Энхжаргал





## 1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

1.1 Ерөнхий мэдээлэл	1
1.2 Үнэ, цалин хөлс	8
1.3 Ажиллах хүчний болон хөрөнгийн зах зээл	14
1.4 Монгол улс, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази-Номхон далайн бүлгэмээс хийсэн хамтын үнэлгээний талаар	17

## 2. МӨНГӨ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

2.1 Мөнгөний нийлүүлэлт	20
2.2 Мөнгөний бодлогын хэрэгжилт	28
2.3 Улсын валютын нөөцийн удирдлага	40

## 3. ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮ

45

## 4. БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ

4.1 Банкны салбарын хөгжил	49
4.2 Банкны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт	54

## 5. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

5.1 Гадаад орчин	63
5.2 Гадаад худалдааны индекс	65
5.3 Ургал данс	66
5.4 Хөрөнгө ба Санхүүгийн данс	72

## 6. БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1 Удирдлага, зохион байгуулалт	77
6.2 Бэлэн мөнгөний хангалт	78
6.3 Гадаад хамтын ажиллагаа	78
6.4 Дотоод аудит	82
6.5 Нягтлан бодох бүртгэл	82
6.6 Мэдээллийн технологийн талаар	86
6.7 Банкны сургалтын төвийн үйл ажиллагаа	90

## 7. БОДЛОГО ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

93

## 8. АУДИТОРЫН ТАЙЛАН

95

## 9. ХАВСРАЛТУУД

129



# Монгол улсын эдийн засгийн тойм

## 1.1 Ерөнхий мэдээлэл

Өнгөрсөн онд эдийн засгийн гадаад орчин таатай хэвээр байсан бөгөөд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт жилийн 8.4 хувьд хүрэв. Дэлхийн зах зээл дээрх нефть бүтээгдэхүүний үнэ өндөр хэвээр байсан боловч Засгийн газраас бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хазаарлах чиглэлээр тодорхой арга хэмжээ авсны үр дүнд жилийн инфляци 6.0 хувь боллоо. Төлбөрийн тэнцлийн урсгал данс болон төсвийн тэнцэл сайжирсан, гадаад валютын цэвэр албан нөөц эрчимтэй нэмэгдэж импортын 24 долоо хоногийн хэрэгцээг хангахуйц хэмжээнд хүрсэн зэрэг нь эдийн засгийн хөгжлийг тогтвортжуулах чухал хүчин зүйлс болж байна.

2000 оноос хойш өнөөг хүртэлх эдийн засгийн дундаж өсөлт 5.5 хувь байсан бөгөөд тайлант онд 8.4 хувь болж өмнөх жилийнхээс 1.3 нэгжээр өндөр байна. Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ, тээвэр, агуулахын аж ахуй зэрэг салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ өргөжсөн нь голлох нөлөө үзүүлжээ. Мөн уул уурхай, олборлох үйлдвэр өссөн, барилгын ажил эрчимжсэн, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ сайжирсан нь эдийн засгийн өсөлтөд зохих хувь нэмэр оруулсан байна.

Тайлант онд зочид буудал, зоогийн газар 29.6 хувь, боловсруулах үйлдвэрлэл 21.3 хувь, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо 14.3 хувь, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй 9.7 хувь, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үл ажиллагаа 9.1 хувиар тус тус өсч, өсөлтийн хурдаараа тэргүүлж байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд цаг агаарын байдал тааламжтай байсан нь хөдөө аж ахуйн салбарын хөгжилд эерэгээр нөлөөлсөн бөгөөд өнгөрсөн онд малын хорогдол багасч, бойжуулсан төлийн тоо болон нийт малын тоо өсчээ. Малын тоо толгой 4.4 сая толгой буюу 14.5 хувиар нэмэгдэж 34.8 сая болжээ. Хураасан үр тариа 63.4 мянган тонн буюу 84.3 хувь, хүнсний ногоо 6.4 мянган тонн буюу 10.0 хувиар тус тус нэмэгдсэн байна. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл ДНБ-ий 21.5 хувийг бүрдүүлсэн бөгөөд тус салбарын эзлэх хувийн жин 0.8 нэгжээр өсч 7.3 хувь болсон бөгөөд тус салбар нь 2005 онд 17.9 хувиар буурч байсан бол тайлант хугацаанд 21.3 хувиар өсч, ДНБ өсөхөд нөлөөлжээ. Мөн бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ (ДНБ-ий 25.9 хувийг бүрдүүлдэг) 6.9 хувь, тээвэр, агуулахын аж ахуй (ДНБ-ий 16.9 хувийг бүрдүүлдэг) 14.3 хувиар тус тус нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлт эрчимжихэд хүргэсэн байна.

Уул уурхай, олборлох үйлдвэр 2005 онд 10.9 хувиар өсч ДНБ-ий өсөлтийг хангах гол суваг болж байсан бол 2006 онд өсөлт нь саарч 2.7 хувьд хүрчээ. 2005 онд зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ 13.1 хувиар буурсан бол 2006 онд 29.6 хувиар өсчээ. Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн үл ажиллагаатай холбоотойгоор манай улсад ирсэн жуулчдын тоо олширсон нь зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ өргөжихөд нөлөөлсөн байна.

## Хүснэгт 1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

(2000 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг)

	2001	2002	2003	2004	2005	2006
<b>Дотоодын нийт бүтээгдэхүүн</b>	1,029,542.4	1,070,681.0	1,134,519.0	1,256,758.7	1,346,101.9	1,459,029.5
өсөлт (%)	1.0	4.0	6.1	10.8	7.1	8.4
Хөдөө аж ахуй, ан агуур, ойн аж ахуй, загасны аж ахуй	242,085.5	211,961.6	222,299.0	261,666.2	286,711.8	314,409.6
өсөлт (%)	-18.3	-12.4	4.9	17.7	9.6	9.7
Уул уурхай, опборлох үйлдвэр	126,625.3	116,183.0	113,506.9	152,485.5	169,152.1	173,793.4
өсөлт (%)	9.0	-8.2	-2.3	34.3	10.9	2.7
Боловсруулах үйлдвэр	84,597.6	100,507.3	104,829.1	105,789.4	87,433.2	106,022.3
өсөлт (%)	33.2	18.8	4.3	0.9	-17.4	21.3
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	25,284.9	26,103.2	26,393.1	28,049.8	28,283.6	28,971.9
өсөлт (%)	2.7	3.2	1.1	6.3	0.8	2.4
Барилга	21,701.1	26,647.1	40,663.5	40,023.3	46,198.2	48,530.8
өсөлт (%)	12.4	22.8	52.6	-1.6	15.4	5.0
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	265,555.5	291,534.4	312,233.3	333,473.4	354,134.5	378,589.6
өсөлт (%)	8.6	9.8	7.1	6.8	6.2	6.9
Зочид буудал, зоогийн газар	12,651.5	10,094.4	10,013.6	11,466.9	13,445.4	17,428.7
өсөлт (%)	-6.9	-20.2	-0.8	14.5	17.3	29.6
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	126,663.5	146,781.1	163,121.1	180,442.5	215,994.2	246,934.3
өсөлт (%)	12.9	15.9	11.1	10.6	19.7	14.3
Санхүүгийн зуучал	30,765.5	34,564.4	45,797.8	55,754.9	63,710.4	63,881.6
өсөлт (%)	21.1	12.3	32.5	21.7	14.3	0.3
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	10,967.7	14,228.3	16,974.4	19,785.5	20,534.7	22,397.5
өсөлт (%)	6.0	29.7	19.3	16.6	3.8	9.1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	44,381.4	44,026.0	42,913.0	44,648.7	46,165.1	46,374.8
өсөлт (%)	-5.7	-0.8	-2.5	4.0	3.4	0.5
Боловсролын салбарын үйл ажиллагаа	47,464.0	49,679.4	47,538.3	44,404.4	43,081.3	44,191.3
өсөлт (%)	1.1	4.7	-4.3	-6.6	-3.0	2.6
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	19,967.8	20,211.7	19,791.1	20,847.0	21,025.2	21,245.3
өсөлт (%)	3.8	1.2	-2.1	5.3	0.9	1.0
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	4,646.7	12,304.5	12,599.8	13,765.8	14,483.1	15,680.0
өсөлт (%)	9.5	164.8	2.4	9.3	5.2	8.3
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	-33,815.6	-35,649.3	-44,155.0	-55,844.6	-64,250.9	-69,421.6
өсөлт (%)	36.1	5.4	23.9	26.5	15.1	8.0

Эх сурвалж: Үндэсний Статистикийн газар (YCI)

Тайлант онд жилийн инфляци 6 хувь болсон нь сүүлийн зургаан жилийн дундаж буюу 7.1 хувиас бага байна. Дэлхийн зах зээл дээр нефть бүтээгдэхүүний үнэ өндөр хэвээр байсан бөгөөд Орос улсаас нийлүүлдэг шатахууны гаалийн татвар нэмэгдсэнээс тус бүтээгдэхүүний дотоодын үнэ даган өсөв. 2006 онд А-80 бензиний дундаж үнэ өмнөх жилийн дундаж үнээс 15.4 хувь, А-93 бензинийх 15.8 хувиар тус тус нэмэгджээ. Харин 2005 онд А-80 бензиний дундаж үнийн өсөлт 27.9 хувь, А-93 бензинийх 30.2 хувь байсан байна. Хэдийгээр бензиний дундаж үнийн өсөлт өмнөх оныхтой харьцуулснаар бага боловч шатахууны үнийн өсөлт суурь үнэ бодлгийн хувьд бусад бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлсөн хэвээр байв. Тайлант оны 5, 6, 8, 9 дүгээр саруудад А-80 бензиний үнэ 2.6-5.6 хувь, А-93 бензинийх 2.4-9.1 хувиар тус тус нэмэгдэж байсан боловч оны эцэс буюу 12 дугаар сард А-80 бензиний үнэ 8.2 хувь, А-93 бензинийх 4.2 хувиар тус бүр буурсан байна. Шатахууны дотоодын үнийн энэхүү хэлбэлзэл нь зах зээлийн хүчин зүйлсээс гадна нефть бүтээгдэхүүн импортлогч байгууллагуудын үнийн бодлогын хэрэгжилтээс хамаарч байв.

Засгийн газар махны хомдол, үнийн хөөрөгдөл гаргахгүй байх асуудалд анхаарлаа хандуулан зохих арга хэмжээ авч байлаа. 2005 оны 9 дүгээр сард Засгийн газраас махны нөөц бүрдүүлж, борлуулсан аж ахуйн нэгжид урамшуулал олгох тухай журам гаргасан билээ. Үүний дагуу 12 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж 3500 тонн мах бэлтгэж, нөөцлөн борлуулахаар шийдвэрлэжээ. Үүнээс гадна үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махыг НӨАТ-аас чөлөөлөхөөр болсон байна. Махны үнийг барьж, ариун цэврийн зохих орчинд мах бэлтгэсэн аж ахуйн нэгжид Засгийн газраас мөнгөн урамшуулал үзүүлж, НӨАТ-өөс чөлөөлөх арга хэмжээ авсны үр дүнд тайлант онд махны үнэ огцом өсөөгүй бөгөөд инфляцийг хөөрөгдүүлэх эх сурвалж болоогүй гэж үзэж болохоор байна. Тайлант онд өргөн хэрэглээний барааны үнийн индексийн тооцоонд өөрчлөлт оруулж сагсанд байгаа бараа, үйлчилгээний нэр төрлийг олшруулан 287 болгож, 2005 оны 12 дугаар сарын үнийг суурь болгосон. Max, махан бүтээгдэхүүний нийт сагсанд эзлэх хувийн жин төдийлөн өөрчлөгдөөгүй. Max, ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүнийг сагснаас хасч тооцсон суурь инфляци жилийн 7.3 хувьд хүрсэн байна. Харин тайлант хугацаанд хүнсний зарим бүтээгдэхүүний үнээс гадна орон сууц, ус, цахилгаан, түлш, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээ болон боловсролын үйлчилгээний үнэ өссөн нь хэрэглээний барааны үнийн өсөлтөд нөлөөлжээ.

Тайлант онд улсын нэгдсэн төсөв 123.4 тэрбум төгрөг, урсгал тэнцэл 371.7 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Нэгдсэн төсвийн ашиг ДНБ-ий 3.9 хувь болсон байна. Төсөв ашигтай гарсан нь татварын орлого нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ. Үүнд зарим барааны үнийн өсөлтийн татвар буюу алт, зэсийн үнийн өсөлтөөс хамаарсан 68.0 хувийн татварын орлогоор 177.5 тэрбум төгрөг төсөвт төвлөрсөн байна. Тус хөрөнгийн 97.2 хувь буюу 172.6 тэрбум төгрөгийг Эрдэнэт УҮГазар зэсийн үнийн өсөлтөөс оруулжээ. Төсвийн нийт зардал ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дунгийн өсөлтөд Монгол Улсыг хөгжүүлэх санд хуваарилсан хөрөнгийн зардал гол нөлөө үзүүлжээ. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг тодорхой журмын дагуу давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн төсвийн орлогын дутагдлыг нөхөх, хүүхэд, гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах таатай орчинг бүрдүүлэх, улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхдээ чиглэгдсэн хөрөнгө оруулалтад зарцуулах юм.


2006 онд манай орны нийт экспорт 1542.8 сая ам. доллар, нийт импорт 1485.6 сая ам. доллар болж, гадаад худалдааны тэнцэл 57.2 сая ам. долларын ашигтай гарлаа. Нийт экспортын талаас илүү хэсэг буюу 58.0 хувийг бүрдүүлдэг эрдэс бүтээгдэхүүний экспорт өмнөх оныхтой харьцуулснаар 439.3 сая ам. доллар буюу 96.6 хувь, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүний экспорт (нийт экспортын 16.0 хувь) 55.3 сая ам. доллар буюу 28.9 хувиар тус тус нэмэгдсэн нь нийт экспортын өсөлтийг тодорхойлжээ. Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнийн өндөр түвшин манай орны зэсийн экспортын үнийн дунд шууд нөлөөлсөн бөгөөд зэсийн экспорт жилийн хугацаанд 309.0 сая ам. доллар буюу 94.7 хувиар өссөн байна (зэсийн экспорт биет хэмжээгээр тайлант онд 12.2 мянган тонн буюу 2.1 хувиар өсчээ). Харин алтны экспорт үнийн дүнгээр 61.3 сая ам. доллар буюу 18.5 хувь, биет хэмжээгээр 8.4 тонн буюу 35.3 хувиар буурсан байна. Алт олборлолт 1.5 тонноор буурсан байхад алтны экспорт илүү хэмжээгээр багассан нь алтны үнийн өсөлтөөс төлөх татвартай холбоотой. Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх гол эх үүсвэр болсон алтыг өөрийн орны банк, санхүүгийн байгууллагад тушаах, хууль бусаар хил давуулах явдлыг зогсоо зорилгоор тухайн үеийн нөхцөл байдалд дүгнэлт хийж Монголбанк Сангийн яамтай хамтран 7 дугаар сард тодорхой арга хэмжээ авчээ. Үүнд Монголбанкинд тушаасан алтны 68 хувийн татварын тооцоог алт тушаах үед нь хийхгүй харин дараа тооцох боломжийг аж ахуйн нэгж, байгууллагад олгов. Нефть бүтээгдэхүүний импорт 2005 онд нийт импортын 25.5 хувийг эзэлж байсан бол 2006 онд 28.4 хувь болж 2.9 нэгжээр нэмэгджээ. ОХУ-аас импортоор оруулсан нефть бүтээгдэхүүний эзлэх хувь 84.7 хувиас 89.6 хувь хүртэл өссөн байна. Харин Казахстанаас импортолсон нефть бүтээгдэхүүний эзлэх хувь 8.2 хувиас 7.4 хувь, Хятадаас импортолсон нь 5.7 хувиас 2.3 хувь болж тус тус буурчээ. Нефть бүтээгдэхүүний импортын хэрэгцээг ОХУ дангаар хангасан хэвээр байна.

Тайлант онд гадаад валютын цэвэр нөөц 687.3 сая ам. долларт хүрч манай орны импортын 24 долоо хоногийн хэрэгцээг хангахаар байна. Гадаад валютын цэвэр нөөц өмнөх оныхоос 2.3 дахин, их өр төлж барагдуулсан 2003 оныхоос 5.3 дахин их байна.

Төгрөгийн америк доллартай харьцах нэрлэсэн ханш оны эцэст өмнөх оныхоос 4.6 хувиар чангарсан байна.

Тайлант онд нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хэд хэдэн арга хэмжээ авсан байна. 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс төр, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон гэрээгээр ажиллагсдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 53 мянган төгрөгөөр тогтоов. Мөн төрийн албан хаагчдын цалинг 30 хувь, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийг 32.3 хувиар тус тус нэмэгдүүлээ. Ерөнхий боловсролын сургуульд үйийн хоолны хөтөлбөр хэрэгжүүлж эхлэв. Шинээр гэр бүл боловсродод 500 мянган төгрөг, төрсөн хүүхдэд 100 мянган төгрөг, 0-18 насны хүүхдэд сар бүр 3000 төгрөг олгож, гэр бүлийн хөгжлийг дэмжих, хүүхдийн халамжийг сайжруулах арга хэмжээ авч байна. Энэ нь нэг талаар нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам болсон боловч нөгөө талаар төсвийн түр зуурын нэмэгдэл орлогыг үр дүн багатай зарцуулахад хүргэж байна. Гадаад орчны тааламжтай нөхцөлд орж ирж буй хөрөнгийг төвлөрүүлж, Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ирээдүйн хөгжил, тухайлбал урт хугацааны үр өгөөжтэй хөрөнгө оруулалтын чиглэлд зарцуулах, хөдөлмөрийн бүтээмжийг өсгөхөд зориулах хэрэгтэй юм.

**Зураг 1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт**



**Зураг 1.2 ДНБ-ний өсөлт (салбаруудаар)**



## Аж үйлдвэр

Тайлант онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 68.4 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэр, 22.3 хувийг боловсруулах аж үйлдвэр, 9.2 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж тус бүр бүрдүүлжээ. Ул уурхай, олборлох аж үйлдвэрт хамгийн өндөр хувь буюу 89.9 хувийг металлын худэр олборлолт, боловсруулах аж үйлдвэрт 28.8 хувийг хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл, 31.8 хувийг нэхмэлийн үйлдвэрлэл, 16.5 хувийг төмрийн үйлдвэрлэл, харин цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжид 88.1 хувийг цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл тус тус эзэлж байв.

2006 онд аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оныхоос 2000 оны зэрэгцүүлэх үнээр 9.1 хувиар өссөнөөс уул уурхай, олборлох аж үйлдвэр 1.9 хувь, боловсруулах аж үйлдвэр 26.2 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж 2.5 хувиар тус бүр нэмэгджээ. Тус салбаруудын өсөлтийг тодорхойлсон дэд салбарыг авч үзвэл, металлын худэр олборлолт 3.7 тэрбум төгрөг буюу 0.9 хувь, хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл 15.5 тэрбум төгрөг буюу 16.6 хувь, нэхмэлийн үйлдвэрлэл 35.5 тэрбум төгрөг буюу 55.6 хувь, төмрийн үйлдвэрлэл 13.8 тэрбум төгрөг буюу 54.8 хувь, цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл 2.6 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар тус тус өсчээ.

Тайлант онд дотоод дахь аж үйлдвэрийн борлуулалт оны үнээр 2093.0 тэрбум төгрөгт хүрсэн бол гадаадын зах зээлд 1346.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлжээ. Ул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалтын 79.2 хувь, боловсруулах аж үйлдвэрийн 34.5 хувь нь гадаадын зах зээлд ногдож байна. Үүнд металлын худэр олборлолтын бүтээгдэхүүний 81.2 хувь, нэхмэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 65.9 хувь, төмрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 50.0 хувийг тус бүр гадаадын зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 46.3 хувийг Улаанбаатар хотод, 39.5 хувийг Орхон аймагт борлуулсан байна. Өмнөх онтой харьцуулснаар Улаанбаатар хотод борлуулсан нийт бүтээгдэхүүн 22.4 хувь, харин Орхон аймагт 72.3 хувиар тус тус нэмэгджээ. Улмаар Улаанбаатар хотын борлуулалтын хувийн жин 7.8 нэгжээр багасч, харин Орхон аймгийнх 6.7 нэгжээр өсчээ.

## Хөдөө аж ахуй

2006 онд 34.8 сая мал, үүнд 15.4 сая ямаа, 14.8 сая хонь, 2.2 сая үхэр, 2.1 сая адuu, 253.5 мянган тэмээ тоологдов. Малын тоо 2005 оныхоос 4.4 сая буюу 14.5 хувиар өсөв. Тус өсөлтийг малын төрлөөр нь авч үзвэл ямаа 2.2 сая, хонь 1.9 сая, үхэр 204.3 мянга, адuu 85.7 мянган толгойгоор тус тус өсч, харин тэмээ 0.7 мянган толгойгоор багасчээ. Малын тоо толгойн өсөлт үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан хэвээр байна.

Дорноговь аймгаас бусад бүх аймаг болон Улаанбаатар хот малаа 2005 оныхоос 14.4-469.2 мянган толгой буюу 3.1-30.3 хувиар өсгөсөн байна. Хөвсгөл (2973.5 мянга), Өвөрхангай (2623.3 мянга), Завхан (2550.8 мянга), Архангай (2530.5 мянга), Увс (2400.9 мянга) зэрэг аймгууд малын тоогоороо тэргүүлж байна.

2006 онд 11.2 сая эх мал буюу эх малын 87.2 хувь төллөжээ. Төллөлтийн хувь өмнөх оныхоос 2.2 нэгжээр сайжирчээ. Нийт 10.8 сая төл бойжсон бөгөөд бойжилтын хувь 1.2 нэгжээр өсч, 95.3 хувь болжээ.

Тайлант онд 138.6 мянган тонн үр тариа, 127.8 мянган тонн буудай, 70.4 мянган тонн хүнсний ногоо, 109.1 мянган тонн төмс тариалж, 983.3 мянган тонн өвс хадлан болон 34.0 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь 2005 оныхоос үр тариа 63.4 мянган тонн буюу 84.3 хувь, буудай 54.3 мянган тонн буюу 74.0 хувь, хүнсний ногоо 6.4 мянган тонн буюу 10.0 хувь, төмс 26.3 мянган тонн буюу 31.8 хувь, өвс хадлан 138.2 мянган тонн буюу 16.3 хувиар тус тус өсч, харин гар тэжээл 1.3 мянган тонн буюу 3.6 хувиар багасчээ.

Нэг га талбайгаас хураасан үр тариа дунджаар 11.0 центнер болсон нь өмнөх оныхоос 6.3 центнер буюу 2.3 дахин өсөв. Нэг га талбайгаас авсан төмс 16.9 центнер буюу 19.9 хувиар нэмэгдэж, 101.7 центнер болжээ.

Тариалсан нийт талбай 27.5 мянган га буюу 14.5 хувиар багассанаас үр тарианы талбай 32.9 мянган га буюу 20.7 хувь, буудайны талбай 35.8 мянган га буюу 23.3 хувь, тэжээлийн ургамал тариалсан талбай 1.3 мянган га буюу 25.4 хувиар буурчээ. Харин хүнсний ногооны талбайн хэмжээ өөрчлөгдөөгүй бөгөөд төмс тариалсан талбай 1.0 мянган га буюу 9.9 хувиар нэмэгджээ.

Тариалсан талбай багассан боловч нэг га талбайгаас хураасан болон нийт хураасан үр тарианы хэмжээ өссөн нь цаг агаарын таalamжтай байдал болон сайн чанаарын буудайн үрийг хөнгөлөлттэй нөхцлөөр газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд нийлүүлсэн, агротехник болон технологи шинэчлэх арга хэмжээ авсны үр дүн боллоо.

### *Барилга*

Урьдчилсан гүйцэтгэлээр барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2006 онд 197.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 12.3 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар их байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 84.3 хувийг дотоодын барилгын байгууллага хийж гүйцэтгэв. Дотоодын барилгын байгууллагууд орон сууцны 113 барилга, бусад зориулалтын 104 барилга ашиглалтад оруулжээ.

Нийт барилга угсралт, их засварын ажлын 34.7 хувийг орон сууцны барилга, 18.5 хувийг их засварын ажил, 14.7 хувийг эрчим хүчний барилга байгууламж эзэлж байна.

## Тээвэр, холбоо

Тайлант онд тээврийн бүх төрлийн хэрэгслээр 24.0 сая тонн ачаа, давхардсан тоогоор 195.4 сая зорчигч тээвэрлэсэн бөгөөд 2005 оныхоос ачаа тээвэрлэлт 300.9 мянган тонн буюу 1.3 хувь, зорчигч тээвэрлэлт 2.6 сая хүн буюу 1.3 хувиар өссөн байна.

Тээврийн салбарын нийт орлого 306.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 3.4 тэрбум төгрөг буюу 1.1 хувиар буурчээ. Энэхүү бууралтад төмөр замын тээврийн орлого 11.0 тэрбум төгрөг буюу 5.7 хувиар багассан явдал голлон нөлөөлжээ. Тус хугацаанд авто тээврийн орлого 1.8 тэрбум төгрөг буюу 4.0 хувь, агаарын тээврийнх 6.1 тэрбум төгрөг буюу 8.5 хувиар нэмэгдэж, усан замын тээврийн орлого 14.5 сая төгрөг буюу 76.3 хувиар багаслаа. Авто тээврээр тээсэн ачаа өмнөх оныхтой харьцуулснаар 1.1 сая тонн буюу 13.7 хувиар өсч 9.2 сая тонн болжээ. Зорчигч тээвэрлэлт 2.5 сая хүн буюу 1.3 хувиар өсч 190.7 сая зорчигч болов.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 14.8 сая тонн болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 806.5 мянган тонн буюу 5.2 хувиар багассанд дотоодын болон дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлт буурсан нь нөлөөлжээ. Харин зорчигч тээвэрлэлт 0.1 сая хүн буюу 2.4 хувиар нэмэгджээ.

Агаарын тээврийн ачаа тээвэрлэлт 0.1 мянган тонн буюу 5.0 хувь, зорчигч тээвэрлэлт 0.1 сая хүн буюу 33.3 хувиар нэмэгджээ.

Шуудан холбооны нийт орлого 173.5 тэрбум төгрөгт хүрч жилийн хугацаанд 45.1 тэрбум төгрөг буюу 35.1 хувиар өсөв. Хүн амаас орсон орлогын тус орлогод эзлэх хувийн жин 3.7 нэгжээр өсч 2006 онд нийт орлогын 79.4 хувийг бүрдүүлжээ. Үүрэн телефоны орлого 39.3 тэрбум төгрөг буюу 47.0 хувь, телефон утас, телеграф, телекоммуникацийн холбооны орлого 3.7 тэрбум төгрөг буюу 10.1 хувиар тус тус өсч нийт орлогын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлжээ.


Тайлант онд үүрэн телефон эзэмшигчдийн тоо 199.2 мянган хүн буюу 34.9 хувиар өсч 770.1 мянга, суурин телефоны цэг 4.4 мянган цэг буюу 2.8 хувиар өсч 163.7 мянга, утасгүй телефоны тоо 21.3 мянга буюу 92.4 хувиар нэмэгдэж 44.3 мянган ширхэг болжээ.

2006 онд үүрэн телефон холбооны гуравдагч оператор үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Мөн тайлант онд интернэтийн урсгалын импортын үнийг бууруулах, технологийг шинэчлэх арга хэмжээ авсны үр дунд интернэт хэрэглэгчдийн тоо олширч, ашиглалтын нэг цагийн үнэ нь буурсан байна. Интернэт кафэд интернэт ашиглах нэг цагийн дундаж үнэ 23 төгрөгөөр буурчээ.


## 1.2 Үнэ, цалин хөлс

Бараабүтээгдэхүүний хэрэглээ нь нийгмийн сонирхлын чиг хандлага, технологийн хөгжил дэвшил, цаг хугацааны хувьслаас хамаарч тухай бүр өөрчлөгдөж байдаг. Иймд үнийн түвшин тооцдог хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийн сагс дахь бараабүтээгдэхүүний нэр төрөл, түүний эзлэх хувийн жинг цаг тухай бүрт зөв тодорхойлж өөрчилж байх нь чухал ач холбогдолтой юм. Үндэсний статистикийн

Зураг 1.3 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт (2000 оны үнээр)



Зураг 1.4 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний бүтэц



газар нь ХҮИ аргачлалыг дахин шинэчлэн боловсруулж, 2006 оны 2 дугаар улирлаас эхлэн тус шинэчилсэн аргачлалаар инфляцийн түвшинг тооцдог болов. ХҮИ-ийн сагсанд 46 нэр төрлийн бүтээгдэхүүн шинээр нэмж, өргөжүүлснээр нийтдээ 287 нэр төрлийн бүтээгдэхүүнтэй болсон бөгөөд бүтээгдэхүүн тус бүрийн сагсанд эзлэх хувийн жинг шинэчлэн тогтоожээ. Түүнчлэн ХҮИ-ийн суурь үнийг 2005 оны 12 дугаар сарын үнээр сонгож авсан байна.

ХҮИ-ээр тооцсон үнийн түвшин 2006 онд хэлбэлзэл өндөртэй байв. Хүнсний бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлт, улирлын чанартай хомсдол нь үнэ хэлбэлзэх үндсэн шалтгаан юм. Суурь инфляцийг тооцож үзсэнээр хүнсний бүтээгдэхүүн нь хэрхэн үнийн түвшинг хэлбэлзүүлсэн нь харагдаж байна.

Бензин шатахууны үнийн өсөлт, түүний бараа бүтээгдэхүүний суурь үнэ болдог онцлог байдлаас үүдэн сүүлийн 2 жилд үнийн түвшин өндөр инфляцитай гарч байсан. Түүнээс гадна улирлын чанартай бараа бүтээгдэхүүний хомсдолд дөрөөлж бүтээгдэхүүн нийлүүлэгч (худалдаалагч) нар зохиомлоор үнэ хөөрөгдөх явдал инфляцийг дэврээж байв. Тус сөрөг үзэгдлүүд 2006 оны эхний хагас жилд дахин ажиглагдсан бөгөөд энэ нь эхний хагас жилийн байдлаар инфляцийн түвшин 6.0 хувьд хүрснээр батлагдаж байна. Харин инфляцийн өндөр өсөлт 6 дугаар сараас тогтвортеж сарын өөрчлөлт нь таслалаас хойшхи оронтой тоогоор илэрхийлэгдэж эхэлсэн байна. Зуны улиралд эдийн засагт дефляци ажиглагдсан бөгөөд 9 дүгээр сарын эцэс гэхэд хагас жилийн байдлаар 6.0 хувиар өсчихсөн байсан инфляци 1.0 нэгжээр буурч 5.0 хувьд хүрчээ. Өвлийн улиралд үнийн түвшин аажмаар өсч инфляци ажиглагдсан бөгөөд жилийн эцсийн байдлаар инфляци 6.0 хувьд эргэн хүрчээ.


### Хүнсэгт 1.2 Хэрэглээний үнийн индекс

	Суурь индекс	2006 оны эцэс	2006-12/2005-12
Хүнсий бараа, согтууруулах бус ундаа	42.21	43.61	103.3
Согтууруулах ундаа, тамхи	2.94	3.04	103.3
Хувцас, бөс бараа, гутал	10.14	10.90	107.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.51	11.44	108.7
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	3.31	3.55	107.4
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.79	2.22	123.6
Тээвэр	9.53	10.67	112.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	3.13	2.71	86.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.70	3.93	106.3
Боловсролын үйлчилгээ	5.44	6.01	110.3
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.70	2.98	110.1
Бусад бараа үйлчилгээ	4.58	4.89	107.7
Ерөнхий индекс	100.0	106.0	


Эх сурвалж: УСГ

Тайлант онд хэрэглээний 287 нэр төрлийн бараа, үйлчилгээний 62.7 хувийнх нь үнэ өсч, 19.2 хувийнх нь үнэ буурч, 18.1 хувийнх нь үнэ тогтвортой байв. ХҮИ-ийг бараа бүтээгдэхүүний ангилал буюу бүлгээр авч үзвэл холбоо мэдээллийн

Зураг 1.5 Инфляци



Зураг 1.6 Инфляци ба суурь инфляци (оны эхнээс, өссөн дүнгээр)



хэрэгслээс бусад бүх дэд бүлгүүдийн үнэ өссөн байна. Тухайлбал хүнсний бүтээгдэхүүний үнэ 3.3 хувиар өссөн нь ерөнхий индексийг 1.45 нэгжээр нэмэгдүүлжээ.

Хүнсний бүтээгдэхүүн дотроо гурил, чихэр жимсний төрлийн бүтээгдэхүүнүүд хамгийн өндөр үнийн өсөлттэй байв. Хэдийгээр улирлын чанартай хомсдолоос хамаарч махны үнэ 2006 онд хэлбэлзэл өндөртэй байсан ч оны эцэст махны үнэ 2005 оны эцсийн үнэтэй ижил түвшинд эргэн хүрчээ.

Бензин шатахууны үнийн өсөлтийн шууд нөлөөгөөр тээврийн үйлчилгээ дэд бүлгийн индекс 2006 онд 12.1 хувиар өссөн нь ерөнхий индексийг 1.15 орчим нэгжээр нэмэгдүүлжээ. Түүнчлэн орон сууц, ус, цахилгаан, түлш бүлгийн үнийн түвшин 8.7 хувиар нэмэгдсэн нь ерөнхий индексийн 0.93 нэгжээр өсгөсөн байна.

Үндэсний статистикийн газраас 2006 оны 4 дүгээр улиралд явуулсан түүвэр судалгаагаар аж ахуйн нэгж байгууллагад ажиллагдын сарын дундаж цалин 137.7 мянган төгрөг байна. Дундаж цалингийн жилийн өсөлт нь 34.0 хувь буюу өмнөх онуудын жилийн өсөлтөөс харьцангуй өндөр байна. Тухайлбал 2004 онд 5.5, 2005 онд 9.8 хувиар цалингийн түвшин тус бүр өсч байжээ.

### Хүснэгт 1.3 Дундаж цалин, салбараар

(мянган төгрөгөөр)

	2004	2005	2006	Оны өсөлт
Санхүүгийн зохицуулалт	49.80	56.70	69.80	23.10
Төрийн захиргаа, батлан хамгаалах, нийгмийн даатгал	92.40	137.20	152.20	10.90
Үул уурхайн олборлох аж үйлдвэр	97.10	104.90	136.30	29.90
Зочид буудал, зоогийн газар	112.60	118.10	142.80	20.90
Цахилгаан эрчим хүч, шатдаг хий, усан хангамж	109.10	111.00	141.70	27.70
Барилга	72.60	75.40	89.60	18.80
Тээвэр холбоо агуулахын аж ахуй	106.80	123.40	143.00	15.90
Боловсрол	121.30	114.30	139.30	21.90
Боловсруулах аж үйлдвэр	125.10	201.20	260.40	29.40
Эрүүл мэнд нийгмийн хангамж	68.60	71.40	99.00	38.70
Үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа	96.50	110.00	156.70	42.50
Нийгэм хамт олон, хувь хүний үйлчилгээ	87.00	98.40	138.70	41.00
Худалдаа, засвар	80.80	90.10	128.40	42.50
Хөдөө аж ахуй, Ойн аж ахуй	62.70	76.30	98.50	29.10
Бүгд	96.00	105.40	137.70	30.60

Эх сурвалж: УСГ

Эдийн засгийн салбар бүтээгдэхүүний үр өгөөжөөс хамаарч ажиллагдын цалин өөр хоорондоо харилцан адилгүй байна. Дундаж түвшнээс их буюу өндөр цалинтай салбарт банк санхүү, төрийн захиргаа, уул уурхай орж байгаа

бол бага цалинтайд хөдөө аж ахуй, худалдаа, засвар, нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны салбар харьяалагдаж байна.

#### Хүснэгт 1.4 Дундаж цалин, ажил мэргэжил

(мянган төгрөгөөр)

Ажил мэргэжилийн ангилал	2004	2005	2006	Жилийн өөрчлөлт %	
				2005	2006
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер	140.5	156.8	210.0	11.6	33.9
Мэргэжилтэн	103.1	116.9	161.0	13.4	37.7
Инженер техникийн ажилтан	110.9	114.7	145.8	3.4	27.1
Бичиг хэргийн туслах ажилтан	78.7	77.4	119.6	-1.7	54.5
Үйлчилгээний ажилтан	79.9	91.0	112.9	13.9	24.1
ХАА, загас аж ахуйн мэргэшсэн ажилтан	56.0	57.0	76.4	1.8	34.0
Үйлдвэр худалдааны ажилчид	100.4	105.4	135.4	5.0	28.5
Машин тоног төхөөрөмжийн операторч, угсралч	110.8	138.3	151.8	24.8	9.8
Энгийн ажил мэргэжил	73.8	77.1	92.6	4.5	20.1
Улсын дундаж	96.0	105.4	137.7	9.8	30.6

Эх сурвалжс: УСГ

Макро эдийн засгийн онол нь хөдөлмөрийн бүтээмж нэмэгдээгүй үеийн цалингийн өсөлтийг сайшаадаггүй. Харин цалинг бууруулах эсвэл тогтвортой түвшинд барихыг санал болгодог. Гэвч дээр дурьдсанчлан цалингийн дундаж түвшин 2006 онд 34.0 хувиар өссөн, түүнчлэн төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар, тэтгэврийг 25.0 хувиар Засгийн газар нэмэгдүүлсэн зэрэг ажиллах хүчиний салбарт томоохон өөрчлөлтүүд 2006 онд гарлаа. Хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн үеийн цалингийн өсөлт нь инфляцийг хөөрөгдөх шалтгаан болдоггүй. Гэвч тайлант онд инфляци нь суурь инфляциас бага түвшинд гарсан. Өөрөөр хэлбэл, Монголын инфляцийн өсөлтед голлох нөлөө үзүүлдэг бараа бүтээгдэхүүний үнэ өсөөгүй харин хувцас, бөс бараа, орон сууц, ус цахилгаан зэрэг бусад барааны үнэ өсчээ. Цалин нэмэгдсний улмаас иргэдийн хэрэглээ өргөжиж, худалдан авалт нэмэгдсэн гэх таамаглал гарч байна.

Өмнөх жилүүдэд, махны үнийн өсөлт нь инфляцийг хөөрөгдөх үндсэн хүчин зүйл байсан бол 2006 онд Засгийн газар нь махны үнийг тогтвортой түвшинд барих зорилт тавин ажиллалаа. Тус зорилтыг засгийн газар нь амжилттай хэрэгжүүлж оны эцсийн байдлаар махны дундаж үнэ нь өнгөрсөн оныхтой ижил түвшинд байна. Түүнчлэн Монголбанк нь 2006 онд инфляцийг 7.0 хувьд барих зорилтоо хэрэгжүүлж чадлаа.

## 1.3 Ажиллах хүчний болон хөрөнгийн зах зээл

### *Ажиллах хүчний зах зээл*

Монгол улсын нийт хүн ам 2006 оны эцсийн байдлаар 2594.8 мянгад хүрснээс хөдөлмөрийн насны хүн ам 1619.6 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүч 1042.8 мянга, ажиллагсад 1009.9 мянга болов.

2006 оны жилийн эцсийн байдлаар эдгээрээс 32.9 мянга нь аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн албанад ажил идэвхтэй эрж, хайж байгаа ажилгүйчүүд гэж бүртгүүлсэн нь өнгөрсөн оныхтой ижилхэн байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 22.8 хувийг 16-24 насны, 34.1 хувийг 25-34 насны, 27.8 хувийг 35-44 насны, 15.3 хувийг 45-59 насны хүн эзэлж байна. Харин боловсролоор нь авч үзвэл, ажилгүйчүүдийн 12.7 хувь нь дээд, 7.3 хувь нь тусгай дунд, 8.4 хувь нь мэргэжлийн анхан шатны, 66.3 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд, 4.4 хувь нь бага боловсролтой, 0.7 хувь нь боловсролгүй хүн байна.

Тайлант онд улсын хэмжээгээр 60.1 мянган хүн шинээр ажил хайж бүртгүүлсэн бол бүртгүүлсэн ажилгүй хүмүүсээс 43.1 мянга нь ажилд оржээ.


### *Хөрөнгийн зах зээл*

Өмнөх онуудтай харьцуулахад хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдах үнэт цаасны арилжаа идэвхжиж, хөрөнгийн зах зээл сэргэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, хөрөнгийн зах дээрх нийт үнэлгээний дүн тайлант онд эрс өсч, сүүлийн жилүүдэд байгаагүй хамгийн өндөр түвшиндээ хүрчээ. Мөн үнэт цаасны ханш өсч Топ-20 индексийн зах зээлийн үнэлгээ нэмэгдэж байна.


Тайлант оны эцсийн байдлаар Монголын хөрөнгийн биржид 387 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас 100 хувь төрийн өмчтэй 21, төрийн өмчийн оролцоотой 39, хувийн өмчийн 327 хувьцаат компани байна. Эдгээр хувьцаат компанийн 2.3 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байв. Үнэт цаасны арилжаанд сард дунджаар 64-126 компани оролцож байв.

Тайлант онд Монголын хөрөнгийн биржид нийт 253 удаагийн арилжаагаар 264 компанийн 74.5 сая ширхэг хувьцаа, 99.3 мянган ширхэг компанийн бонд, 47.0 мянган ширхэг Засгийн газрын бонд арилжигдаж, 18.3 сая төгрөгийн гүйлгээ хийгджээ. Нийт гүйлгээний үнийн дунгийн 69.9 хувь нь компанийн хувьцаа, 24.8 хувь нь Засгийн газрын бонд, 5.3 хувь нь компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна. Арилжааны хэмжээг өмнөх онтой харьцуулбал, хувьцааны арилжаа 10.1 тэрбум төгрөг буюу 5.0 дахин өссөн бол Засгийн газрын бондын арилжаа 2.3 тэрбум төгрөг буюу 34.1 хувиар, компанийн бонд 1.7 тэрбум төгрөг буюу 63.9 хувиар тус тус буурсан байна. Засгийн газрын бондын арилжаа буурсан нь манай улсын экспортын гол бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ өсч, улсын төсвийн орлого давж биелсэнтэй холбоотой байна. Харин компаниудын хувьцааны үнэ ханш өссөн, шинээр хувьцаа гаргасан зэргээс хувьцааны арилжааны дүн нэмэгдэв.

Зураг 1.7 Хөрөнгийн зах зээлийн хувьцааны нийт үнэлгээ



Зураг 1.8 Хөрөнгийн захын Топ-20 индекс



### Хүснэгт 1.5 Арилжааны гүйлгээний дүн

/сая төгрөгөөр/

	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2005	2006	Үнийн дүнгээр	Хувиар
Засгийн газрын бонд	6,767.70	4,461.50	-2,306.20	-34.1
Компанийн бонд	2,663.70	960.9	-1,702.80	-63.9
Хувьцаа	2,547.30	12,604.30	10,057.00	5 дахин

Эх үүсвэр: Монголын хөрөнгийн бирж

### Бондын арилжсаа

Засгийн газрын бондын арилжаа 2 удаа явагдсан бөгөөд арилжаанд зөвхөн банкууд оролцжээ. Эхний арилжаагаар (2006 оны 3 сард) 288 хоногийн хугацаатай 37.0 мянган ширхэг бондыг 3.5 тэрбум төгрөгөөр, хоёрдахь арилжаагаар (2007 оны 12 сард) 274 хоногийн хугацаатай 10.0 мянган ширхэг бондыг 952.9 сая төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

Тайлант жилд компанийн бондын арилжаа 84 удаа явагдаж, 99.3 мянган ширхэг бонд арилжигдан 960.9 сая төгрөгийн гүйлгээ хийгджээ. Арилжааны гүйлгээний дүнгийн 57.9 хувь буюу 556.3 сая төгрөгийг Пума бонд, 24.4 хувь буюу 234.5 сая төгрөгийг Бүтээн байгуулалт бонд, 13.9 хувь буюу 134.0 сая төгрөгийг Анод бонд, 3.7 хувь буюу 35.5 сая төгрөгийг Нийслэл өргөө бонд, 0.1 хувь буюу 0.5 сая төгрөгийг Шинэ зуун бонд тус тус эзэлж байна.

### Хувьцааны арилжсаа

Тайлант онд өдөрт дунджаар 294.6 мянган хувьцаа арилжаалагдаж, 48.9 сая төгрөгийн гүйлгээ хийгджээ. Үүнийг өмнөх онтой харьцуулбал, хувьцааны тоо 192-оор, гүйлгээний дүн 39.7 сая төгрөгөөр өссөн байна. Хувьцааны ханш 2005 оны дунджаас 71 төгрөгөөр өсч 169 төгрөгт хүрчээ. Үнэт цаас нь арилжигдсан 163 компанийн үнэт цаасны ханш өсч, 17 компанийх буурч, 84 компанийнх тогтмол байв. Тайлант онд Женко тур бюро, БиДиСек, Бэрх уул, Зоос банк, Монгол Шилтгээн зэрэг хувьцаат компаниудын хувьцаа тоо ширхэгээр болон үнийн дүнгээр хамгийн идэвхтэй арилжаалагдсан байна. Харин Монголын цахилгаан холбоо, Говь, Монгол шилтгээн хувьцаат компаниуд зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компаниудад орж байна.

Үнэт цаасны үнийн Топ-20 индексийн жилийн дундаж 1291.9 нэгжид хүрсэн нь өмнөх оноос 495.8 нэгж буюу 62.3 хувиар өсчээ. Энэ нь индексийн сагсийг бүрдүүлж буй ихэнх хувьцаат компаниудын үнэт цаасны ханш өссөнтэй холбоотой байна.

## 1.4 Монгол улс, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази-Номхон далайн бүлгэмээс хийсэн хамтын үнэлгээний талаар

Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн чухал асуудал болоод байгаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд өөрийн хувь нэмрээ оруулах зорилгоор энэ төрлийн олон улсын байгууллагын гишүүнээр элсэх, энэ талаархи олон улсын конвенц, гэрээнд нэгдэх, үндэснийхээ хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлэх алхамыг хийж байна.

Монгол улс “Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай” Монгол улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 60 дугаар зарлиг, Засгийн газрын мөн оны 226 дугаар тогтоол гарч, Улсын Их Хурлаас Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын конвенцийг 2004 онд, Авиалгалын эсрэг НҮБ-ын конвенцийг 2005 онд тус тус соёрхон баталжээ.

Түүнчлэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг /2006.7.8/ баталснаар мөнгө угаах, терроризмын санхүүжилттэй тэмцэх дэглэмийг бий болгоход чухал алхам боллоо.

Монгол улс 2004 онд FATF (Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилго бүхий олон улсын байгууллага)-ын бүс нутгийн байгууллага болох мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази-Номхон далайн бүлгэмд гишүүнээр элсэн орсон бөгөөд тус байгууллагын өмнө хүлээсэн үргийнхээ дагуу мөнгө угаах, терроризмтэй тэмцэх асуудалд онцгой анхаарал хандуулж байна.

Тайлант онд тус бүлгэмээс Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэгийн хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг шалгах хамтын үнэлгээний баг Монгол улсад анх удаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг хэрхэн зохион байгуулж байгаа талаархи хэрэгжилтийг шалгав.

Ийм шалгалт нь Гишүүн орнууд FATF-ын “40+9 зөвлөмж”-ийн хэрэгжилтийг хэрхэн биелүүлж буйг хянан шалгах гол зорилготой байдаг бөгөөд тус шалгалтаар Монгол улс, түүний санхүүгийн тогтолцооны талаархи ерөнхий мэдээлэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратеги, үндэсний хууль зүйн систем, санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагуудын урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хуулийн этгээд, ашгийн бус байгууллагын зохион байгуулалт, дотоод, гадаад хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр шалгав. Монгол улс Хамтын үнэлгээний шалгалтанд бэлтгэн FATF-ын стандартуудыг багтаасан хамтын үнэлгээний асуулгыг бүрэн хариулж 2006/10/09-ний өдөр хүргүүлсэн бөгөөд Бүлгэмийн хамтын үнэлгээний баг Монгол улсад 2006/12/4-14-ний хооронд ажиллаж дүгнэлтэй гаргаад 2007 онд тус Бүлгэмийн жилийн хурлаар Монгол улс мөнгө угаах, терроризмыг санхүүжилттэй хэрхэн тэмцэж буй талаархи илтгэлийг хэлэлцүүлэх юм.



## Мөнгө, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

Сүүлийн жилүүдэд эдийн засаг хурдацтай өсөж, Монгол улсын экспортын гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ өсөн, бизнес эрхлэгчдийн ашиг орлого нэмэгдэхийн хэрээр эдийн засаг дахь мөнгөжих үйл явц эрчимтэй үргэлжилж байна. 2006 онд энэ байдал улам сайжирч хадгаламж, зээлийн хэмжээ хурдацтай өсөн нэмэгдсэн нь санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлж, эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр орууллаа.

Банкны системийн нийт актив өмнөх оныхоос 46.0 хувиар, нийт зээлийн хэмжээ 42.3 хувиар, нийт хадгаламжийн хэмжээ 48.2 хувиар, өөрийн хөрөнгө 42.4 хувиар өссөн бол банкны салбарын зээлийн чанарын үзүүлэлт болох чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь 0.9 нэгжээр буурсан байна. Үүний дунд 2006 онд мөнгө, санхүүгийн салбарын гол үзүүлэлтүүд сайжирч, санхүүгийн зуучлалын гүнзгийрэлт үргэлжилж байна. Тухайлбал, өмнөх оноос зээл ДНБ-ий харьцаа 4.5 нэгжээр, хадгаламж ДНБ-ий харьцаа 4.8 нэгжээр тус тус өсчээ. Мөн тайлант оны турш инфляцийн тувшин өмнөх оноос харьцангуй тогтвортой байж оны эцэст 6.0 хувьтай, эдийн засгийн бодит өсөлт 8.4 хувьтай гарсан нь санхүүгийн салбарын тогтвожилт, гүнзгийрэлтийн бодит үр нөлөө байв.

Хүснэгт 2.1 Мөнгө санхүүгийн салбарын гол үзүүлэлтүүд

(хувиар)

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
М2/ДНБ	25.4	29.7	37.9	47.5	43.5	45.2	48.4
Зээл/ДНБ	6.6	12.1	18.7	29.9	31.2	34.1	38.6
Хадгаламж/ДНБ	9.1	12.1	17.6	24.6	26.6	27.5	31.4
Банкнаас гадуурхи мөнгө/М2	39.0	33.0	25.7	18.7	16.9	13.4	12.1
Зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	66.8	135.1	231.4	442.1	606.8	859.9	1223.3

Тайлант оны турш төгрөгийн америк доллартай харьцах ханш чангасан нь хадгаламж эзэмшигчдийн ханшийн хүлээлтэнд өөрчлөлт оруулж, улмаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг төгрөгийн хадгаламжийн өсөлтөөр хангахад нөлөөлөв. Энэ нь нэг талаас сүүлийн жилүүдэд иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдэн мөнгөн хөрөнгө банкны салбараар дамжин эдийн засгийн эргэлтэд орж, улс орны хөгжилд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байгааг илэрхийлж байна. Нөгөө талаас, банкууд төгрөг болон валютын хадгаламжийн хүүний зөрүүг ханшийн хүлээгдэж буй өөрчлөлттэй уялдуулан тогтоохгүй байгаатай холбоотой юм.

## 2.1 Мөнгөний нийлүүлэлт


Тайлант онд эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт оны эхнээс 34.8 хувь буюу 396.4 тэрбум төгрөгөөр өсч 1.54 их наяд төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх буюу 84.2 хувийг бараг мөнгөний өсөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оныхоос 0.5 нэгжээр өссөн байна. Харин М1 мөнгө (банкнаас гадуурхи мөнгө болон төгрөгийн харилцах)-ний өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд 15.8 хувийг эзэлж, өмнөх оныхоос 0.5 нэгжээр буурчээ.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг өмнөх оны өсөлттэй харьцуулахад 103.3 тэрбум төгрөг буюу 0.2 нэгжээр хурдасчээ. Харин энэ үзүүлэлт 2005 онд 149.4 тэрбум төгрөг буюу 14.2 нэгжээр хурдасч байжээ.


Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлтийн хандлагаас харахад М1 мөнгөний жилийн өсөлтийн хурдац тайлант оны эхний хагаст буурч сүүлийн хагаст өссөн байна. Харин төгрөгийн ханшийн өөрчлөлт, түүний хүлээлтээс хамааран төгрөгийн хадгаламж болон валютын харилцах, хадгаламжийн өсөлтийн хурдац оны турш харилцан адилгүй өөрчлөгдж байв. Төгрөгийн ханш хамгийн ихээр чангартаг байсан 3 дугаар сараас бусад саруудад төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт 40-өөс дээш хувиар өссөн бол өмнөх онуудын адилаар төгрөгийн ханш сударна гэсэн хүлээлт үүссэнээс валютын харилцах, хадгаламжийн өсөлт 5-7 дугаар саруудад хамгийн ихээр буюу 50-аас дээш хувиар хурдасчээ. Төгрөгийн ханш 8-11 дүгээр саруудад харьцангуй тогтвортой байсан нь төгрөгийн болон валютын харилцах, хадгаламжийн өсөлтийг харьцангуй тогтвортой байхад нөлөөллөө. Харин оны сүүлийн сард валютын хадгаламж төгрөгийн хадгаламж руу шилжилт хийснээр жилийн өсөлтийн хурдац нь огцом буурсан нь төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт зах зээлд бий болсонтой холбоотой юм. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн хурдац оны турш ерөнхийдөө үргэлжлэн өссөн хэдий ч оны эцэст дээрх харилцан эсрэг чиглэлтэй өөрчлөлтийн үр дүнд буурч өмнөх оны түвшинд очсон байна. Үүнээс үзэхэд тайлант оны мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд бараг мөнгө түүний дотор иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх жилийн адилаар зонхилох хувь эзэллээ. Энэ нь сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт тогтвортой өндөр байгаагас иргэд, байгууллагуудын мөнгөн хөрөнгийн хуримтлал нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Мөнгөний гол агрегатууд сүүлийн жил гаруй хугацаанд тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа нь эдийн засаг дахь дахин мөнгөжих үйл явц хурдтай явагдаж байгаагаас шууд хамааралтай юм. Эдийн засаг дахь мөнгөжилт нь мөнгөний эрэлтийг ихээхэн нэмэгдүүлж, нөгөө талаас банкуудын хүүний бууралт, төгрөгийн ханшийн чангартал болон төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр мөнгөний эрэлт мөн нэмэгдсээр байна. Энэ байдал нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг хурдасгах хүчин зүйлс болсоор байна. Сүүлийн жилүүдэд мөнгөний нийлүүлэлт хурдтай өсч буй хэдий ч мөнгөний эрэлтээ гүйцэхгүй даган өсч байгааг Монголбанкны судалгааны үр дүн харуулсан билээ. Энэ нь мөнгөний нийлүүлэлтийн хурдтай өсөлт эдийн засагт мөнгөний гарал үүсэлтэй инфляцийг бий болгохгүй байгааг илэрхийлж байгаа юм.

Зураг 2.1 Мөнгөний үзүүлэлтүүд (жилийн өөрчлөлт)



Зураг 2.2 M2 мөнгөний бүтцийн задаргаа (M2-д эзлэх хувиар)



Мөнгөний нийлүүлэлтийн дийлэнхийг 2 болон 3 дугаар улиралд валютын харилцах, хадгаламж эзэлж байсан бол 1 болон 4 дүгээр улиралд төгрөгийн хадгаламж эзлэх болсон байна. 2006 оны эхний улирлаас хэрэгжиж эхэлсэн төсөвт байгууллагын ажиллагдын цалин, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хalamжийн зардлын өсөлтийн нөлөө болон ХАА, уул уурхайн салбаруудын үйлдвэрлэлийн идэвхжилт банкнаас гадуурхи мөнгөний нийт мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувийг 2, 3 дугаар улиралд өсөхөд хүргэсэн байна. Харин дээрх салбаруудын улирлын шинжтэй үйл ажиллагаа зогсдогоос оны эцэст банкнаас гадуурхи мөнгөний нийт мөнгөнд эзлэх хувь 1 дүгээр улиралд өсч, 2 дугаар улирлаас бууран оны сүүлийн хагаст тогтвортой байв.

Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийг гадаад болон дотоод цэвэр активын өөрчлөлтөөр авч үзвэл, өмнөх оны адилаар гадаад цэвэр активын өсөлт дангаараа хангасан байна. Энэхүү гадаад цэвэр активын хурдацтай өсөлт нь гадаад валютын цэвэр нөөц (бүх банкуудын дүнгээр), түүний дотор дэлхийн зах зээл дээрх алтны үнийн өсөлттэй холбоотойгоор улсын гадаад цэвэр албан нөөцийн өсөлтөөр хангагджээ. Харин дотоод цэвэр активын жилийн өсөлт оны эхнээс ихээхэн буурсан нь Засгийн газрын цэвэр зээл буурснаас<sup>1</sup> шалтгаалсан байна.


Засгийн газрын цэвэр зээл ийнхүү буурах болсон нь тайлант оны турш дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнийн өсөлттэй холбоотойгоор экспортын барааны татварын орлого өсч, улсын төсвийн орлого нэмэгдсэнээс болжээ. Тухайлбал, гадаад цэвэр активын жилийн өсөлт өмнөх оныхоос 15.1 нэгжээр нэмэгдэж 98.5 хувьд хүрсэн бол дотоод цэвэр активынх 35.3 нэгжээр буурч-29.0 хувь болжээ.

Банкны салбараас дотоодод олгосон цэвэр зээл оны эхнээс 3.1 хувь буюу 23.6 тэрбум, бусад цэвэр зүйлс 71.1 хувь буюу 141.5 тэрбум төгрөгөөр буурснаас дотоод цэвэр актив 29.0 хувь буюу 165.1 тэрбум төгрөгөөр багаслаа. Тайлант онд улсын секторт олгосон зээл 2.6 тэрбум төгрөг буюу 7.5 хувиар, хувийн секторт олгосон зээл 169.9 тэрбум төгрөг буюу 34.7 хувиар өсчээ. Харин хугацаа хэтэрсэн зээл 12.4 тэрбум төгрөг буюу 59.3 хувиар, чанаргүй зээл 10.5 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар тус тус өсчээ.


Гадаад валютын цэвэр нөөц (бүх банкуудын дүнгээр) 115.3 хувь буюу 495.7 сая ам. доллараар, үүний дотор гадаад цэвэр албан нөөц 130.6 хувь буюу 389.3 сая ам. доллараар өсчээ. Энэ нь гадаад цэвэр актив өмнөх оноос 98.5 хувь буюу 561.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэх шалтгаан болсон байна. Гадаад цэвэр албан нөөцийн энэхүү өөрчлөлтөнд гадаадын банк дахь хугацаат хадгаламжийн хэмжээ 73.1 хувь буюу 181.4 сая ам. доллараар, гадаадын засгийн газрын үнэт цаас 64.3 хувь буюу 46.5 сая ам. доллараар, гадаадын банк дахь харилцах 14.4 сая ам. доллараар, мөнгөжсөн алт 134.6 сая ам. доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

\* 2006 оны турши Засгийн газрын харилцах, хадгаламжийн хэмжээ өссөнөөр засгийн газрын дотоод цэвэр зээл буурсан буюу засгийн газрын хадгаламжийн хэмжээ нь зээлээсээ шлуу хурдтай нэмэгдсэн.

**Зураг 2.3 Мөнгө, гадаад болон дотоод цэвэр актив  
(жилийн өөрчлөлт)**



**Зураг 2.4 Бага мөнгө, түүний бүтэц (жилийн өөрчлөлт)**



## Бага мөнгө M1

Тайлант оны эцэст бага мөнгө (M1) 23.3 хувь буюу 62.8 тэрбум төгрөгөөр өсч 331.9 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 21.6 хувийг эзэлж байна. 2006 онд засгийн газрын нийгмийн шинж чанартай зардлууд өссөнтэй холбоотойгоор хүмүүсийн гар дээрх бэлэн мөнгөний хэмжээ нэмэгдсэн нь банкнаас гадуурхи мөнгөний өсөлт бага мөнгө (M1)-ний өсөлтийн дийлэнх хэсгийг эзлэхэд нөлөөлжээ. Тухайлбал, мөнгө M1-ийн өсөлтийн 52.2 хувь нь банкнаас гадуурхи мөнгөний өсөлт, 47.8 хувь нь банкуудын төгрөгийн харилцахын өсөлт байв. Сүүлийн 6 жилд бараг мөнгөний өсөлтийн хурд M1 мөнгөний өсөлтөөс байнга өндөр байснаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд M1 мөнгөний эзлэх хувь буурсаар ирсэн. Энэ байдал тайлант онд мөн үргэлжилж, төгрөгийн харилцахын өсөлтийн хурд өмнөх онтой харьцуулахад саарч, банкнаас гадуурхи мөнгө ихээхэн өссөн нь бага мөнгөний өсөлтийг 1.7 нэгжээр нэмэгдүүлсэн хэдий ч M1 мөнгөний нийт мөнгөнд эзлэх жин нь 2.0 нэгжээр буурчээ. Энэ нь бараг мөнгөний хурдтай өсөлтөөс шалтгаалсан юм.

Тайлант онд банкнаас гадуурхи мөнгө 32.8 тэрбум төгрөг буюу 21.5 хувь, банкуудын касс 20.6 тэрбум төгрөг буюу 52.4 хувь, төгрөгийн харилцах 30.0 тэрбум төгрөг буюу 25.7 хувиар тус тус өсчээ. 1 дүгээр улиралд хурдтай өссөн төгрөгийн харилцахын жилийн өсөлт 2 дугаар улирлаас буурсан бол банкнаас гадуурхи мөнгөний өсөлт оны эхний хагаст харьцангуй өндөр хэлбэлзэлтэй байв. Харин оны сүүлийн хагаст буюу 7 дугаар сараас эхлэн банкнаас гадуурхи мөнгөний өсөлт тогтвортожиж, хэлбэлзэл нь буурчээ.


M1 мөнгө улирлын тогтвортой хэлбэлзэлтэй бөгөөд эдийн засаг дахь бэлэн мөнгөний эрэлттэй холбоотойгоор 1, 4 дүгээр улирлуудад тренд утгаасаа буурах, харин 2, 3 дугаар улирлуудад өсөх хандлага хүчтэй ажиглагддаг ба 2006 онд ч энэ хандлага ажиглагдлаа. 2006 оны 2 дугаар сараас төсвийн байгууллагын цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээс M1 мөнгө 1 дүгээр улиралд өсөж, харин бусад улирлуудад түүний тогтвортой улирлын хэлбэлзэл өрөнхийдөө хадгалагдлаа. M1 мөнгөний улирлын хэлбэлзэл M2 мөнгөнд нөлөөлдөг боловч сүүлийн жилүүдэд гарч буй бараг мөнгөний өндөр өсөлтөөс шалтгаалан M2 мөнгөний улирлын хэлбэлзлийн нөлөө илрхий суларч байна.

## Бараг мөнгө


Тайлант онд бараг мөнгө 333.6 тэрбум төгрөг буюу 38.3 хувиар өсч 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 78.4 хувийг эзэлж байна. Энэ нь сүүлийн жилүүдэд дотоод хуримтлал болон гадаадын мөнгөн гүйвуулгаар бараг мөнгө тасралтгүй өсч буйг илтгэж байна. Бараг мөнгөний бүтцээс харахад төгрөгийн хадгаламж оны эхнээс 266.5 тэрбум төгрөг буюу 62.5 хувиар нэмэгдсэн бол гадаад валютын харилцах, хадгаламж 67.1 тэрбум төгрөгөөр буюу 15.1 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, тайлант оны турш төгрөгийн америк доллартай харьцах ханш чангарттай байсан хэдий ч бараг мөнгөний өсөлт төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн аль алиных нь өсөлтөөр хангагджээ.

Тайлант онд төгрөгийн ханшийн өөрчлөлт иргэдийн санхүүгийн шийдвэр гаргалтад, тухайлбал хадгаламжийн шийдвэрт ихээхэн нөлөөлөв. Оны эхний улиралд төгрөгийн ханш өмнөх оноос илүү чангарсан нь иргэдийн төгрөгийн

Зураг 2.5 Улирлын хэлбэлзлийн индексүүд



Зураг 2.6 Бараг мөнгө, түүний бүтэц (жилийн өөрчлөлт)



хадгаламжид мөнгөн хөрөнгөө байршуулах сонирхлыг нэмэгдүүлсэн. Иймээс энэ хугацаанд төгрөгийн хадгаламжийн өсөлт валютын харилцах, хадгаламжийн өсөлтөөс байнга өндөр байв. Гэхдээ өмнөх онуудын адил ханш суларна гэсэн хүлээлт үссэнээс 3 дугаар сард төгрөгийн хадгаламжийн өсөлтийн хурд саарч, валютын харилцах, хадгаламжийнх нэмэгдсэн хэдий ч ханш чангартсан хэвээр байв. Харин 4 дүгээр сард ханш бага хэмжээтэй суларсан боловч төгрөгийн хадгаламжийн өсөлт өндөр хэвээр байсаар байлаа. Валютын харилцах, хадгаламжийн өсөлт 5, 6 дугаар саруудад өмнөх саруудаас дунджаар 26 орчим нэгжээр нэмэгдэн төгрөгийн хадгаламжийн өсөлтөөс хурдассан нь иргэдэд ханш суларна гэсэн хүлээлт байсантай холбоотой юм. Эндээс хараад манай зах зээл дээр ханшийн ирээдүйгээ бус арагшaa харсан хүлээлт зонхицж байна гэж дүгнэж болохоор байна. Харин оны эцэст ханшийн өөрчлөлт өмнөх онуудаас өөрчлөгдж буйг мэдэрч, харьцангуй ирээдүйгээ харсан хүлээлт үссэндийг валютын хадгаламж ихээхэн буурч, төгрөгийн хадгаламж өссөн хандлагаас харж болох юм.

Ийнхүү 2006 онд төгрөгийн америк доллартай харьцах ханш чангартсан нь оны эцэст төгрөгийн хадгаламжийн хэмжээг эрс нэмэгдүүлж, бараг мөнгөний өсөлтийн дийлэнх хэсгийг төгрөгийн хадгаламжийн өсөлт хангахад хүргэсэн. Тухайлбал, бараг мөнгөний өсөлтийн 79.9 хувийг төгрөгийн хадгаламжийн өсөлт, 20.1 хувийг банкуудын валютын харилцах, хадгаламжийн өсөлт тус тус эзэлж байна.


Өмнөх оны турш тасралтгүй өссөн төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт 2006 онд ч үргэлжилж өмнөх оноос 21.0 нэгжээр өссөн бол гадаад валютын харилцах, хадгаламж оны эхний хагаст өсч, сүүлийн хагаст буурч, өмнөх оноос 21.9 нэгжээр буурсан байна. Эдгээрийн дунд бараг мөнгөний жилийн өсөлт өмнөх оноос 1.0 нэгжээр буурсан байна.

### *Мөнгөний эргэлтийн хурд, үржүүлэгч*


Мөнгөний эргэлтийн хурд өндөр байх нь эдийн засаг дахь мөнгөний гарал үүсэлтэй инфляци бий болохгүйгээр бага хэмжээний санхүүгийн эх үүсвэр оновчтой хуваарилагдан эдийн засгийн өндөр өсөлтийг бий болгож байгааг илэрхийлдэг. Тайлант оны эцсийн байдлаар мөнгөний эргэлтийн хурд 2.1 болсон нь мөнгөний нийлүүлэлт жилд 2.1 удаа эргэлдэж эдийн засагт үйлдвэрлэгдэж буй шинэ өртөг болох ДНБ-ийг бий болгож байна гэсэн үг юм. 2006 онд инфляци 6.0 хувьтай гарч, эдийн засаг 8.4 хувь өссөн нь мөнгөний эргэлтийн хурд өссөний бодит эерэг илэрхийлэл юм.

Харин мөнгөний үржүүлэгч өндөр байх нь банк, санхүүгийн салбар бага хэмжээний нөөц мөнгөөр эдийн засагт их хэмжээний мөнгөний нийлүүлэлтийг бий болгож чадаж байгааг илэрхийлдэг. Тайлант онд мөнгөний үржүүлэгч өмнөх оноос 0.03 нэгжээр буурч 4.02-д хүрчээ. Энэ нь нөөц мөнгө 4.02 дахин үржигдэж эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт болсон буюу 8.31 дахин эргэлдэж нэрлэсэн ДНБ-ийг бий болгосныг илэрхийлнэ. Мөнгөний үржүүлэгч ийнхүү буурсан нь банкуудын нөөц, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа өссөнөөс бий болсон мөнгөний үржүүлэгчийн бууралт нь банкаас гадуурхи мөнгө, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа буурснаас бий болсон мөнгөний үржүүлэгчийн өсөлтөөс илүү их байснаас шалтгаалсан байна.

Зураг 2.7 Банк хоорондын захын арилжааны бүтэц



Зураг 2.8 Банк хоорондын захын арилжааны хэмжээ, жигнэсэн дундаж хүү



## Банк хоорондын зах

Тайлант онд банк хоорондын зах дээр нийт 708.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд үүний 131.1 тэрбум төгрөг нь ТБҮЦ-ны репо нөхцлөөр, 7.5 тэрбум төгрөг нь ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаагаар, 565.0 тэрбум төгрөг нь овернайт зээлээр, 5.1 тэрбум төгрөг нь банк хоорондын зээлээр хийгджээ. Дээрх арилжааны нийт жигнэсэн дундаж хүү нь 6.0 хувь байв.

Тайлант онд банк хоорондын захын арилжааны бүтцээс хараад нийт арилжааны 80 хувийг банк хоорондын овернайт зээл, 18 хувийг банк хоорондын репо хэлцэл, тус бүр 1 хувийг ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа болон банк хоорондын бусад зээл эзэлж байна.

2006 оны банк хоорондын захын хөдөлгөөнийг ажиглавал, 5 дугаар сар хүртэл банк хоорондын захын арилжаа огцом өсч 129.0 тэрбум төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлт нь тухайн үед Хас, Хөдөө аж ахуй, Худалдаа хөгжил, Зоос, Голомт банкуудын хооронд хийгдсэн овернайт зээлийн өсөлтөөс шалтгаалсан байна.

2006 онд банк хоорондын зах дээр хийгдсэн нийт арилжаа урд оныхоос 5.4 хувь буюу 41.1 тэрбум төгрөгөөр буурчээ. Тухайлбал, банк хоорондын зээл 60.1 хувь буюу 7.7 тэрбум төгрөгөөр, ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа 21.1 дахин буюу 150.8 тэрбум төгрөгөөр, банк хоорондын репо хэлцэл 32.4 хувь буюу 42.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан бол банк хоорондын овернайт зээл 15.3 хувь буюу 74.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2006 оны байдлаар банк хоорондын зах дээрх нийт жигнэсэн дундаж хүү 6.0 хувь байгаа нь өмнөх оноос 3.25 хувиар бага байна. 2006 оны 5 дугаар сард банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү хамгийн их буюу 8.77 хувь болж, нийт арилжаа 129 тэрбум төгрөгт хүрсэн нь сүүлийн 4 жилийн хамгийн өндөр нь байв.

## 2.2 Мөнгөний бодлогын хэрэгжилт

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд 2006 оны мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хэрэглээний бараа, үйлчилгээний үнээр илэрхийлэгдсэн инфляцийн түвшинг 7.0 хувиас хэтрүүлэхгүй байна хэмээн тодорхойлсон байна.

Өмнөх оны адилаар эдийн засгийн мэдэгдэхүйц өсөлт, банкны салбарын зээлийн эрчимтэй өсөлт болон дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ харьцангуй өндөр байсан, Засгийн газар төсвийн тэлэх бодлогыг хэрэгжүүлсэн зэрэг нь 2006 онд дотоодын нийт эрэлтийг ихээхэн нэмэгдүүлж улмаар инфляцийг хөөрөгдөх макро гол хүчин зүйлс болж байв. Харин экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалан гадаад худалдааны нөхцөл болон эдийн засгийн бизнесийн орчин сайжирснаас гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн нь төгрөгийн америк долларын эсрэг ханш чангарах нөхцлийг бүрдүүлэв. Ханшийн чангаралт нь дээрх инфляцийг хөөрөгдөж байсан макро хүчин зүйлсийн эсрэг нөлөөг үзүүлж улмаар инфляци харьцангуй тогтворжих суурийг бүрдүүллээ.

Үндэсний Статистикийн газраас гаргасан үнийн мэдээллээс үзэхэд инфляцийн түвшин 2006 онд 6 хувьтай гарсан нь мөнгөний бодлогын үндсэн чиглэлд заасан зорилтод түвшнээс 1 нэгжээр бага байна.

Хэрэглээний барааны үнийн индексийн жилийн өөрчлөлт өмнөх оны 6 дугаар сараас эхлэн тасралтгүй 13 сарын туршид буурч 2006 оны 7 дугаар сард 1.8 хувьд хүрсэн нь сүүлийн дөрвөн жилийн хамгийн бага түвшин нь байв. Ийнхүү үнийн түвшин буурахад дараах 2 хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Оны эхнээс төгрөгийн ханш өмнөх онуудаас хүчтэй, удаан хугацаанд чангартсан нь импортын хэрэглээний бараа, бүтээгдэхүүн болон шатахууны үнийг тогтвортой байх нөхцлийг бүрдүүлсэн. Хоёрдугаарт, жил бүрийн хаврын саруудад гардаг махны нийлүүлэлтийн хомсдолыг Засгийн газраас зохицуулснаар махны үнэ 1990-ээд оноос хойш анх удаа хавар өсөлгүй, тогтвортой байлаа. Энэ хугацаанд банкууд сард дунджаар 30.2 тэрбум төгрөгийн илүүдэл нөөцтэй байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.8 хувиар илүү, нөгөө талаас инфляцийн дарамт байсаар байсан тул мөнгөний бодлогын хэрэгслүүдийг өөрчлөх нөхцлийг бүрдүүлжээ. Энэ зорилгоор 91 хоногийн ТБҮЦ-ны зарласан хүүг нэмэгдүүлж, бусад ТБҮЦ-уудын хэмжээг нэмэгдүүлсэн болно.

Харин 8-11 дүгээр саруудад үнийн түвшин харьцангуй нэмэгдэж 6.8 хувьд хүрсэн нь иргэдийн дунд төгрөгийн ханш оны сүүлийн хагаст сularна гэсэн хүлээлттэй байсан нь үнэ өсөх хүлээлтийг нэмэгдүүлэв. Нөгөө талаас иргэдийн энэхүү хүлээлт нь оны эхнээс өссөөр ирсэн нийт эрэлтийн үнэ хөөрөгдөх дарамтыг хүчтэй болгосон болон шатахууны үнэ нэмэгдсэнтэй хавсран үнэ өсгөх хүчин зүйлс болсон юм. Харин оны сүүлийн сард төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт үүссэнээс инфляци тогтвортажин буурах хандлагыг бий болгосон байна.

### *Нөөц мөнгө*

2006 онд нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүд болох банкуудын нөөц, банкнаас гадуурхи мөнгө сүүлийн жилүүдтэй харьцуулахад нэлээд өндөр хувиар өсчээ.

2006 онд нөөц мөнгөний жилийн өсөлт 35.8 хувьд хүрч өмнөх онтой харьцуулахад 16.1 нэгжээр өссөн байна. Энэхүү өсөлтийн дийлэнх буюу 46.9 хувиig банкуудын нөөцийн өсөлт, 32.6 хувиig банкнаас гадуурхи мөнгөний өсөлт, 20.5 хувиig банкуудын кассын өсөлт тус тус эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад банкуудын нөөц болон банкуудын кассын нөөц мөнгөний өсөлтөд эзлэх хувь харгалзан 3.1 болон 10.4 нэгжээр тус тус буурсан бол банкнаас гадуурхи мөнгөний хувьд 13.5 нэгжээр өссөн байна.

Тайлант онд нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсгүүдийн эзлэх хувийн жин сүүлийн жилүүдийн хандлагыг даган харьцангуй тогтвортой байв. Банкнаас гадуурхи мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувь 1996 оноос тасралтгүй буурч буй хандлага 2006 онд ч мөн адил үргэлжилж 48.5 хувь болж өмнөх оноос 5.7 нэгжээр, 1996 оноос 32.9 нэгжээр буурсан байна. Харин банкуудын нөөцийн нөөц мөнгөнд эзлэх хувь нэмэгдэх хандлага тайлант онд үргэлжилж 35.8 хувьд хүрсэн нь өмнөх оноос 4.0 нэгжээр өндөр байна. Бизнесийн үйл ажиллагааны идэвхжилттэй холбоотойгоор 2 дугаар сараас нөөц мөнгөнд арилжааны банкуудын нөөцийн эзлэх хувь багасч, банкнаас гадуурхи мөнгөний эзлэх хувь нэмэгдэх хандлага

8 дугаар сар хүртэл үргэлжилсэн байна. Өөрөөр хэлбэл 8 дугаар сард банкнаас гадуурхи мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувь тайлант жилийн хамгийн өндөр түвшинд буюу 55.3 хувьд, харин банкуудын нөөцийн нөөц мөнгөнд эзлэх хувь хамгийн бага түвшиндээ буюу 31.6 хувьд хүрсэн байна. Банкуудын кассын нөөц мөнгөнд эзлэх хувь 2000 оноос тасралтгүй өсч байгаа бөгөөд тайлант онд 15.7 хувьд хүрч 1.7 нэгжээр нэмэгдсэн байна.

Тайлант оны эхний 2 сард банкуудын нөөц огцом өссөн боловч 3 дугаар сараас 8 дугаар сар хүртэлх хугацаанд харьцангуй тогтвортой байв. Энэ хугацаанд нөөц мөнгөний хөдөлгөөн банкнаас гадуурхи мөнгөний өөрчлөлтийг дагаж байсан байна. Энэ хандлага өмнөх жилүүдийн хувьд ч ажиглагдаж байсан нь улирлын хэлбэлзлийн индексээс харагдаж байна. Харин энэ хандлага 8 дугаар сараас эхлэн өөрчлөгдж 11 дүгээр сар хүртэл банкнаас гадуурхи мөнгөний хэмжээ тасралтгүй буурсан боловч нөөц мөнгөний хэмжээ өсч байсан нь банкуудын нөөцийн өсөлтөөс шалтгаалсан байна.



Банкнаас гадуурхи мөнгөний улирлын хэлбэлзлийн хандлага тайлант онд хүчтэй байгааг зургаас харж болно. Гэхдээ өмнөх жилүүдээс ялгаатай нь банкнаас гадуурхи мөнгө 7 дугаар сард бага хэмжээгээр буурсныг тэмдэглэх нь зүйтэй юм.

Сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч байсан нөөц мөнгөний улирлын хэлбэлзэл 2006 онд тогтвожих хандлагатай байв. Энэ нь нөөц мөнгөний томоохон бүрэлдэхүүн хэсгүүд болох банкнаас гадуурхи мөнгө болон банкуудын нөөцийн улирлын хэлбэлзлийн хандлага нэмэгдээгүй, мөн улирлын хэлбэлзэл өндөртэй байдаг банкнаас гадуурхи мөнгөний нөөц мөнгөнд эзлэх хувь багассан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлснөөс болжээ. Үүнийг нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн 1997-2005 оны түүврээс тооцсон сарын нөлөөллийн индекс ба 1997-2006 оны түүврээс тооцсон сарын нөлөөллийн индексийн графикаас тодорхой харж болох байна.


Мөнгөний бодлогын эцсийн зорилтыг хангахын тулд Монголбанк нөөц мөнгөний төлөвлөлтийг хийн, улмаар банкны системийн илүүдэл нөөцийг төлөвлөн тэдгээрийг мөнгөний бодлогын хэрэгслүүдээ өөрчлөх гол мэдээлэл болгон ашигладаг. Энэ утгаараа банкны системийн илүүдэл нөөцийн төлөвлөлт нь төрийн мөнгөний бодлогыг оновчтой хэрэгжүүлэхэд гол мэдээллийн эх үүсвэр болдог тул уг төлөвлөлтийг сайжруулах, түүний мэдээллийн эх үүсвэр болон мэдээллийн чанарыг сайжруулах, төлөвлөлтийн арга зүйг боловсронгуй болгох чиглэлд тайлант онд голлон анхаарлаа. Нөөц мөнгөний төлөвлөлттэй уялдуулан Төв банк өөрийн үнэт цаасны зарласан хэмжээ болон хүүг хэрхэн өөрчилж байсныг дараах зургаас харж болно.

Төв банкны 7 хоногийн үнэт цаас нь бусад төрлүүдтэй харьцуулахад зарласан хүү болон хэмжээний хувьд хамгийн хэлбэлзэмтгий байсан бол 91 хоногийн үнэт цаасны зарласан хүү болон хэмжээ хамгийн хэлбэлзэл багатай байжээ.


Зураг 2.9 Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсгүүд ба тэдгээрийн нөөц мөнгөнд эзлэх хувь



Зураг 2.10 Нөөц мөнгөний улирлын хэлбэлзлийн хандлага ба индекс



Зураг 2.11 Банкнаас гадуурхи мөнгөний улирлын хэлбэлзлийн хандлага ба индекс



## Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)

Тайлант онд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг сааруулах үүднээс Монголбанк ТБҮЦ-ны арилжаанаас гадна Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны репо арилжааг зохион байгуулж ажилладаа. ТБҮЦ-ыг 7, 14, 28, 91 хоногийн хугацаатайгаар гаргадаг байсан бол тайлант онд 180 хоногийн ТБҮЦ-ыг шинээр гаргалаа.

ЗГҮЦ-ны репо арилжааг зохион байгуулахдаа ТБҮЦ-тай адил зарчмаар банкуудын худалдан авах захиалга өгсөн үнэт цаасны хамгийн бага хүүний саналаас эхлэн нийт гаргасан хэмжээ хүртэл хуваарилах замаар явуулж банк тус бүрт өөр өөрсдийн захиалсан үнийн дүнгээр үнэт цаасыг худалдав.

Монголбанк оны туршид өдөрт дунджаар 74.0 тэрбум төгрөгийн ТБҮЦ болон ЗГҮЦ-ны репог банкуудад байршуулж байсан нь өнгөрсөн оны ТБҮЦ-ны өдрийн дундаж үлдэгдлээс 3.9 хувиар буурчээ.

2006 онд нийт 90 удаа ТБҮЦ-ны арилжаа, 6 удаа ЗГҮЦ-ны репо арилжаа явуулж 1403.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг борлуулсан байна. Оны эцэст Монголбанкнаас худалдсан үнэт цаасны хэмжээ 83.2 тэрбум төгрөгт хүрлээ.

Монголбанкнаас гаргаж буй үнэт цаасны хүүний түвшин ямар байхаас шалтгаалж мөнгөний зах зээлд оролцогчид санхүүгийн шийдвэрээ гаргадаг тул уг хүү нь мөнгөний зах зээл дээр чухал үүрэг гүйцэтгэдэг. 2006 онд Монголбанкнаас гаргасан үнэт цаас болон репогийн нийт жигнэсэн дундаж хүү 6.34 хувь байсан нь өмнөх онтой харьцуулахад 2.24 нэгж хувиар бага байна. 2006 оны эцсийн байдлаар ТБҮЦ болон ЗГҮЦ-ны репо арилжааны жигнэсэн дундаж хүү 6.42 хувь байсан нь 2005 оныхийн харьцуулахад 1.67 нэгж хувиар өссөн байна. Тайлант онд Монголбанк нийт 4.6 тэрбум төгрөгийг ТБҮЦ-ны хүү болон ЗГҮЦ-ны репо арилжааны хүүд төлжээ.


## Заавал байлгах нөөц

Монголбанк нь төрөөс явуулж буй мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, мөнгөний нийлүүлэлт болон нөөц мөнгийг зохицуулах зорилгоор банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 14 хувийг заавал байлгах нөөц хэлбэрээр байршуулах шаардлагыг тавьж биелэлтэд нь хяналт тавин ажилладаа.


Тайлант онд заавал байлгах нөөцийг тооцож хяналт тавих, нөөц дутагдуулсанд ногдуулах торгуулийг 2001 онд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журмын дагуу явуулж байв.

Энэхүү журмын дагуу банкуудын заавал байлгах нөөцийн тооцоог сард хоёр удаа хийн, нөөцийн шаардлагыг хангаагүй банкуудад торгууль ногдуулж байв. Банкны системийн хэмжээгээр банкуудын заавал байлгах нөөц 2006 оны сар бүр хангажд байсан бөгөөд 2006 онд банкууд Монголбанк дахь харилцах дансандaa өдөр бүр дунджаар 62.6 тэрбум төгрөг байлгахаас 89.3 тэрбум төгрөг байлгаснаар системийн хэмжээнд өдөр бүр дунджаар 26.7 тэрбум төгрөгийн илүүдэл нөөцтэй байв. Энэ нь урд оныхоос 11.1 тэрбум төгрөгөөр илүү байгаа юм. 2006 оны байдлаар заавал байлгах нөөцийг дутагдуулсан банкинд нийт 2.0 сая төгрөгийн торгууль ногдуулав.

Зураг 2.12 Төв банкны үнэт цаасны зарласан хэмжээ ба зарласан хүү



Зураг 2.13 Богино болон урт хугацаатай үнэт цаасны жигнэсэн дундаж хүү\*



\* Богино хугацаатай үнэт цаасны хүү нь 7, 14, 28 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны арилжаа болон ЗГҮЦ-ны репо арилжааны жигнэсэн дундаж хүү болно. Харин урт хугацаатай үнэт цаасны хүү нь 91, 180 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны арилжаа болон ЗГҮЦ-ны репо арилжааны жигнэсэн дундаж хүү болно.

2006 онд заавал байлгах нөөцийн хэмжээ 2005 оны дундажтай харьцуулахад 44.6 хувиар, банкуудын байгаа нөөц 51.6 хувиар харин илүүдэл нөөц 71.1 хувиар өсчээ. Энэ нь банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд нөгөө талаар илүүдэл нөөц их хэмжээтэй байгаа нь банкууд нөөцөө үр ашигтай байршуулж чадахгүй байгааг харуулж байна.

### *Төв банкны санхүүжилт*

Богино хугацаанд түр зуурын нөөцийн дутагдалд орсон банкинд банк хоорондын мөнгөний захаас эх үүсвэр олдохгүй тохиолдолд Монголбанкаас санхүүжилт олгодог.

Төв банкны санхүүжилтэд хямдруулалтын санхүүжилт, репо санхүүжилт, овернайт зээл ордог. Хямдруулалтын санхүүжилт нь тухайн банкны эзэмшиж буй ТБҮЦ, ЗГҮЦ болон Монголбанкаас хүлээн зөвшөөрсөн бусад активыг хямдруулан худалдан авч тухайн банкийг санхүүжүүлэхийг хэлнэ. Монголбанкны репо санхүүжилт тохиролцсон хугацааны эцэст зээлдэгч банк нь өмнө худалдсан байсан өөрийн эзэмшлийн ТБҮЦ, ЗГҮЦ болон Монголбанкаас хүлээн зөвшөөрсөн бусад активаа урьдчилж тохиролцсон үнээр буцаан худалдан авах, Монголбанк нь буцаан худалдах хэлбэрээр хийгддэг. Монголбанкаас олгох овернайт зээлийг тухайн өдрийн хамгийн сүүлийн гүйлгээгээр олгож дараа өдрийн хамгийн эхний гүйлгээгээр буцаадаг.

2006 онд Монголбанкаас банкуудад 41.0 тэрбум төгрөгийн овернайт зээлийг 16.9 хувийн дундаж хүүтэйгээр, 25.1 тэрбум төгрөгийн хямдруулалтын санхүүжилтийг үнэт цаасанд төлөх байсан хүнээс дунджаар 4.0 хувиар хямдруулан, 17.5 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг 12.0 хувийн хүүтэй тус тус олгосон байна.

### *Банкны салбар дахь Засгийн газрын цэвэр зээл*


Тайлант оны эцэст банкны салбарын нэгдсэн дүнгээр Засгийн газраас авлагын 39.5 тэрбум төгрөг, Засгийн газрын хадгаламж 517.2 тэрбум төгрөг болж, цэвэр зээлийн хэмжээ сөрөг 477.7 тэрбум төгрөгт хүрэв. Өнгөрсөн оныхоос Засгийн газрын хадгаламж 323.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, харин Засгийн газраас авлагын авлагын 63.0 тэрбум төгрөг, цэвэр зээл 386.8 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

### *Засгийн газраас авах авлага*


Засгийн газраас авах авлагын 87.6 хувь буюу 34.6 тэрбум төгрөгийг Монголбанкны авлагын үлдэх 12.4 хувь буюу 4.9 тэрбум төгрөгийг банкуудын авлагын эзэлж байна.

Бүтцийн хувьд 85.2 хувь нь Оросын Холбооны Улсад төлөх их өртэй холбогдон үүссэн дунд хугацаатай үнэт цаас, 11.6 хувь нь банкуудын худалдан авсан засгийн газрын богино хугацаатай үнэт цаас, 1.2 хувь нь банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн татвар, 1.1 хувь нь банкуудын Засгийн газраас авах авлагад хурийтлуулж тооцсон хүч, 0.9 хувь нь Худалдаа хөгжлийн банкинд байршиж буй банкны бүтцийн өөрчлөлтийн засгийн газрын энгийн өрийн бичиг байна.

Зураг 2.14 Заавал байлгах нөөцийн хангалт (сараар)



Зураг 2.15 Заавал байлгах нөөцийн хангалт (жилээр)



- *Их өрийг барагдуулахад зориулан олгосон зээлийн тооцоогоор Засгийн газраас авах Монголбанкны авлага*

Монгол улс Зөвлөлт Холбоот улс (одоогийн ОХУ)-аас авсан шилжих рублийн зээлийн өрийг нэн хөнгөлөлттэй нөхцлөөр барагдуулах үйл ажиллагаатай холбогдуулан түүний эх үүсвэрийг бүрдүүлэхэд Монголбанкнаас Засгийн газарт 2003 оны 12 дугаар сард 117.0 тэрбум төгрөгийн зээлийг олгосон билээ. 2006 оны эцсийн байдлаар энэхүү зээлийн өрийн үлдэгдэл 33.7 тэрбум төгрөг болж буурал Монголбанкны эзэмшиж буй үнэт цаас хэлбэрээр байршиж байна.

Энэхүү үнэт цаас нь 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр, 2008 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдөр тус бүр 11.2 тэрбум төгрөгөөр тэнцүү хэмжээгээр төлөгдөж дуусах хуваарътай байна.

- *Банкуудын худалдан авсан Засгийн газрын богино хугацаатай хямдруулсан үнэт цаас*

Тайлант онд Засгийн газар Хөрөнгийн биржээр дамжуулан хоёр удаа богино хугацаатай хямдруулсан үнэт цаасны арилжаа хийв. Үүнд 2006 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 288 хоногийн хугацаатай, жилийн 6.95 хувийн хүүтэй, 3.7 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 37.0 мянган ширхэг хямдруулсан үнэт цаас, “40000 орон сууц” хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 2006 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 274 хоногийн хугацаатай, жилийн 6.5 хувийн хүүтэй, 1.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 10.0 мянган ширхэг хямдруулсан үнэт цаасыг тус тус арилжаалав. Орон сууцны санхүүжилтэд зориулан гаргасан үнэт цаасыг ХААН банк 952.9 сая төгрөгөөр худалдан авсан байна. Уг үнэт цаасны жилийн хүү 6.5 хувь байгаа нь 2006 оны 12 дугаар сар буюу Засгийн газар үнэт цаас гаргасан сар дахь 7-180 хоногийн хугацаатай ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүүнээс 0.07 нэгжээр дээгүүр байна.

2006 оны эцсийн байдлаар 5 банк нийт 3.8 тэрбум төгрөгийн засгийн газрын богино хугацаатай хямдруулсан үнэт цаасыг эзэмшиж байна. Үүний 45.9 хувийг ХААН банк, 19.9 хувийг Худалдаа хөгжлийн банк, 18.6 хувийг Анод банк, 10.4 хувийг Хадгаламжийн банк, 5.2 хувийг Капитрон банк тус тус эзэмшиж байна.

- *Банкны бүтцийн өөрчлөлтийн Засгийн газрын энгийн өрийн бичиг (ББӨЗГЭӨБ)*

Банкны хуучин системээс шилжсэн болон зах зээлийн өмнөх тогтолцооны үед Засгийн газрын шийдвэрээр олгосон 1.7 тэрбум төгрөгийн зээлийг ББӨЗГЭӨБ-ээр сольж Худалдаа хөгжлийн банкинд байршуулсан өрийн үлдэгдэл 2006 оны жилийн эцсийн байдлаар 372.8 сая төгрөг байна.

- *Банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн татвар, Засгийн газраас авах авлагад хурийтлуулж тооцсон хүү*

Улсын төсөвт урьдчилж төлсөн татварын дүн 2006 оны жилийн эцсийн байдлаар 5 банкинд 462.8 сая төгрөг, Засгийн газраас авах авлагад хурийтлуулж тооцсон хүүний авлагын хэмжээ 3 банкинд 233.7 сая төгрөг байна.

Урьдчилж төлсөн татварын авлагын ихэнх хэсэг (95.1 хувь) нь Хадгаламжийн банкинд, хуримтлуулж тооцсон хүүний авлагын ихэнх хэсэг (78.2 хувь) нь Худалдаа хөгжлийн банкинд тус тус ногдож байна.

### *Засгийн газрын хадгаламж*

Засгийн газрын хадгаламж тайлант оны эцэст 517.2 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оныхоос 2.7 дахин өсчээ. Үүний 78.3 хувь нь Монголбанкинд, 21.7 хувь нь банкуудад байршиж байна. Монголбанк дахь улсын төсвийн нөөц, валютын хадгаламж, банкууд дахь засгийн газрын хадгаламж эрчимтэй нэмэгдсэн, зарим банк засгийн газрын дансдын бүртгэлд залруулга хийсэн зэрэг нь энэ үзүүлэлт өндөр гарахад нөлөөлсөн байна.

Нийт хадгаламжийн дийлэнх хэсэг буюу 54.9 хувь нь төрийн сангийн нэгдсэн данс болон Засгийн газрын харилцах дансны хөрөнгө, 40.0 хувь нь хугацаатай болон хугацаагүй хадгаламж, 3.6 хувь нь засгийн газрын санхүүжилтийн хөрөнгө байна.

### *Дамжуулан олгосон зээл*

#### *1. Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх (ХААСХ) төсөл*

Азийн хөгжлийн банкны ХААСХ 1822-МОН төслийн хүрээнд 2006 онд Монголбанк 6.1 тэрбум төгрөгийн зээлийг банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байгаа, баруун аймгуудад салбартай ХААН, Монгол Шуудан, Зоос, Анод, ХАС банкуудад дамжуулан олгож, оны эцэст 4.8 тэрбум төгрөгийн зээлийн авлагатай гарлаа.

Тайлант онд Монголбанк дамжуулан олгосон зээлийн эх үүсвэрт Сангийн яамнаас 5.9 сая ам. долларыг хүлээн авсан бөгөөд оны эцэст авлагагүй гарав. Монголбанк Сангийн яаманд 89.4 сая төгрөгийн хүү төлсөн байна.

Төсөлд оролцогч банкууд хуваарийн дагуу 6.5 тэрбум төгрөгийн зээлийг Монголбанкинд буцаан төлсөн ба ашигласан зээлийнхээ хүд 254.0 сая төгрөгийг төлжээ.

2006 онд банкууд энэ төслийн хүрэнд 7.4 мянган зээлдэгчид 9.6 тэрбум төгрөгийн зээл олгон, 9.3 тэрбум төгрөгийн зээлийг эргүүлэн төлүүлж, оны эцэст 6.9 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй гарчээ. Банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 117.8 сая төгрөг буюу 1.7 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Монголбанкаас авсан эх үүсвэрийг банкууд 100 хувь ашигласан бөгөөд эцсийн зээлдэгчдэд олгосон зээлийн хүү сарын 1.5-3.8 хувь байв. Төсөлд чөлөөт өрсөлдөөний зарчмаар банкуудыг жигд оролцуулах, Монгол орны бүх сумдад өөрийн салбар нэгжтэй болон хөдөө аж ахуйн салбарыг илүү хамарч ажилладаг банкуудыг оролцуулах, мөн баруун бус нутгийн хөгжлийг дэмжих бодлогыг баримтлан ажиллалаа.

## 2. Ажлын байр нэмэгдүүлэх төсөл

Тайлант онд Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН төсөл”-д Голомт, Зоос, Эрэл, Анод, ХАС, Улаанбаатар хотын банкууд оролцлоо.

2006 оны жилийн эцсийн байдлаар ажлын байр нэмэгдүүлэх төслийн эх үүсвэр 3.4 тэрбум төгрөг байна. Үүний 85.8 хувь буюу 2.9 тэрбум төгрөгийг банкуудад дамжуулан байршуулаад байна. Тухайлбал, Голомт банкинд 978.4 сая, Зоос банкинд 977.4 сая, Эрэл банкинд 560.0 сая, Анод банкинд 266.4 сая, ХАС банкинд 70.3 сая, Улаанбаатар хотын банкинд 45.0 сая төгрөг тус тус байршиж байв.

Тайлант онд Зоос банк 342, Голомт банк 295, Анод банк 275, Эрэл банк 187, ХАС банк 103, Улаанбаатар хотын банк 28 нийт 1230 ажлын байрыг шинээр бий болгох төслийг санхүүгүүлсэн байна.

Уг төслөөр Монгол Улс 2.2 сая зээлжих тусгай эрх (ЗТЭ)-тэй тэнцэх валютыг АХБ-нд буцаан төлөх ёстой. Үүнээс 2004, 2005, 2006 онуудад тус бүр 43 мянган ЗТЭ-тэй тэнцэх валют төлж, 2006 оны жилийн эцэст 2.0 сая ЗТЭ-тэй тэнцэх валютын өрийн үлдэгдэлтэй гарлаа.

Тайлант онд хуваарийн дагуу Азийн хөгжлийн банкинд Монголбанкнаас 27.7 мянган ам. долларын, банкуудаас Монголбанкинд 302.1 сая төгрөгийн хүү төлөв.

## 3. КфВ (KfW) төслийн зээл

Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу экспортын чиглэлийн жижиг, дунд үлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүгийн салбарыг дэмжих зорилго бүхий хоёр хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна.


Эхний хөтөлбөрийн хувьд Монгол улсаас ХБНГУ-д эргүүлэн төлөх зээлийн төлбөр хуваарийн дагуу 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс хийгдэж эхэллээ. Харин 2 дахь хөтөлбөрийн эргэн төлөлт 2012 оноос эхлэх юм.

2006 оны эцсийн байдлаар Худалдаа хөгжил, Монгол шуудан, Капитрон банкуудад олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2 хөтөлбөрийн хувьд нийлээд 6.9 сая евро байна. Үүний 44.6 хувь буюу 3.1 сая евро нь Капитрон банкинд, 39.3 хувь буюу 2.7 сая евро нь Монгол шуудан банкинд, 16.2 хувь буюу 1.1 сая евро нь Худалдаа хөгжлийн банкинд тус тус байршиж байна.


Тайлант онд банкуудын буцаан төлсөн болон урьдчилан төлсөн зээлээр бүрдүүлсэн эргэлтийн сангаас 2.9 сая еврог төсөлд оролцогч Монгол шуудан, Капитрон банкуудаар дамжуулан дахин зээлдүүлээд байна. Тайлант оны эцсийн байдлаар уг төслийн зээлийн ашиглаагүй эргэлтийн сангийн үлдэгдэл 1.9 сая евро байгаа бөгөөд Монголбанк нийт эх үүсвэрийн 66 хувийг дамжуулан олгосон байна.

Монголбанк 2006 онд 1 дүгээр хөтөлбөрийн үндсэн төлбөрт 166.7 мянган евро, зээлийн хүд 37.4 мянган евро, 2 дугаар хөтөлбөрийн зээлийн хүд 26.8 мянган еврог КфВ банкинд тус тус төлсөн байна.

Зураг 2.16 Гадаад валютын цэвэр нөөц



Зураг 2.17 Төгрөгийн бодит ба нэрлэсэн үйлчилж буй ханшийн хөдөлгөөн



Тайлант онд КФВ төслийн зээлийн нөхцөл өөрчлөгдлөө. Монголбанк 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн КФВ төслийн хүрээнд 5 хуртэл жилийн хугацаатай, нэг зээлдэгчид 250.0 мянга хүртэл еврог жилийн 1.25 хувийн хүүтэйгээр дамжуулан зээлдүүлж байна. Түүнчлэн, банкуудын эцсийн зээлдэгчдээс авах хүүний дээд хэмжээг жилийн 7.75 хувь байсныг 10 хувь болгон нэмэгдүүлсэн, Монголбанк хүүгээ бууруулсан зэрэг нь банкуудыг энэ төслийн хүрээнд зээл олгох үйл ажиллагааг идэвхтэй явуулахыг дэмжиж байгаа юм.

## 2.3 Улсын валютын нөөцийн удирдлага

Тайлант онд Монгол улсын гадаад валютын албан нөөцийн хэмжээг нэмэгдүүлж, гадаад валютын нөөцийн үр өгөөжийг нэмэгдүүлж оновчтой байршуулах, санхүүгийн хөрөнгө оруулалтын шинэ хэрэгслийг нэвтрүүлэх чиглэлээр идэвхтэй анхаарч ажиллалаа.

2006 онд манай улс руу чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэн, дэлхийн зах зээл дээр манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнэ өндөр хэвээр байсан болон гадаад худалдааны цар хүрээ өргөжиж байгаа зэрэг нь валютын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж гадаад валютын нөөцийн удирдлагыг улам боловронгуй болгох үндсэн нөхцлийг бүрдүүллээ.

Тайланд онд Монгол улсын гадаад валютын цэвэр албан нөөц өмнөх оноос 2.3 дахин буюу 389.2 сая ам. доллараар өсч 687.3 сая ам. долларт хүрсэн нь манай улсын импортын 24 долоо хоног буюу 5 сарын хэрэгцээг хангахуйц хэмжээнд хүрлээ. Энэ нь Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан зорилтот хэмжээг (17 долоо хоног) бүрэн хангасан байна.

2006 онд улсын валютын нөөц 527.3 сая ам. доллараар нэмэгдэн, нөөцөөс 138.1 сая ам. долларыг гадагш шилжүүлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад гадаад валютын орлого 108.7 хувиар, зарлага 16.5 хувиар өсч, цэвэр өсөлт 255.3 сая ам. доллараар нэмэгдсэн байна.

Тайлант онд алт олборлогчдоос Монголбанкинд тушаасан алтын хэмжээ буурсан боловч алтны дэлхийн зах зээлийн үнэ өндөр байсан нь нөөцийг нэмэгдүүлэхэд ихээхэн нөлөөллөө. 2006 оны эцсийн дүнгээр Монголбанк 131 алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, 175 гаруй иргэдээс (давхардсан тоогоор) бохир жингээр 12.1 тонн, цэвэрт шилжүүлснээр 10.8 тонн алт хүлээн авч 251.9 тэрбум төгрөг төлсөн байна. 2006 онд иргэд, аж ахуйн нэгжүүдийн тушаасан алт нь 2005 оноос даруй 3.1 тонноор буурсан байна. Тайлант онд Монголбанк 9.9 тонн алтыг гадаадад цэвэршүүлж мөнгөжүүлснээр гадаад валютын нөөцийг 197.1 сая ам. доллараар нэмэгдүүлсэн байна.

2006 онд улсын гадаад валютын нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, мөн нөөцийн бүтцэд ордог гадаад валютуудын хүүний түвшин зэх зээлд нэмэгдэх хандлагатай байсан зэргээс гадаад валютын нөөцийн голлох хэсгийг богино хугацаат хадгаламжид байршуулав. Дэлхийн зах зээлд голлох валютууд болон алтны ханшийн хэлбэлзэл өндөр байсан бөгөөд алт болон валютын арилжааг багасгах чиглэлийг баримтлан ажилласан байна. Мөн цөөн тохиолдолд гадаад орны засгийн газрын бондод хөрөнгө оруулж зах зээлд үнэ болон хүүний хувьд ашигтай тохиолдолд эргүүлэн худалдсан байна.

Тайлант оны туршид нийт гадаад активыг хөрөнгө оруулалтад байршуулж нийт 14.8 сая ам долларын хүүний орлого, алт ба валютын арилжаанаас 2.27 сая ам. долларын ашиг олжээ. Нийт гадаад активын дундаж үр өгөөж бэлэн валютыг оруулаагүйгээр 3.26 хувь, бэлэн валютыг оруулснаар 3.18 хувьтай тус тус байна.

Тайлант оны туршид нийт гадаад активын голлох хувийг эзэлж байсан ам. доллар, мөнгөжсөн алт, еврогийн хөрөнгө оруулалтын жилийн дундаж үр өгөөжийг харьцуулбал дараах байдалтай байна.

## Хүснэгт 2.2 Гадаад активын дундаж өгөөж, валютаар

Активын төрөл	Ам. доллар	евро	мөнгөжсөн алт	нийт
Хадгаламж	4.86	2.80	0.40	3.54
Харилцах	4.91	2.65	-	3.16
Үнэт цаас	5.27	4.45	-	5.00
Дундаж үр өгөөж (бэлэн валют ороогүй)	4.87	2.81	0.24	3.26

Зах зээлд өндөр хүү бүхий хөгжиж байгаа орнуудын валютуудыг гадаад валютын нөөцийн багцад оруулав. Энэ хүрээнд шинэ зеланд долларыг нөөцийн багцын бага хэмжээнд (оны эцэст нийт албан нөөцийн 1.9 хувь) барьж, жилийн дунджаар 7.57 хувийн үр өгөөжийг авав.

Гадаад валютын нөөцийн хөрөнгө оруулалтын хүүний орлогын 84 хувийг хадгаламж, 15 хувийг харилцах, 1 хүрэхгүй хувийг үнэт цаасны хүүний орлого тус тус бүрдүүлж байна.

## Төгрөгийн нэрлэсэн ханш

Тайлант оны эхэнд 1 америк доллар 1221 төгрөгтэй тэнцэж байсан бол 2006 оны эцсийн байдлаар 1165 төгрөгтэй тэнцэж жилийн хугацаанд 4.6 хувиар чангартсан нь сүүлийн жилүүдэд гарч байгаагүй тохиолдол байв.

2006 онд төгрөгийн америк доллартай харьцах Монголбанкнаас зарласан жилийн дундаж ханш 1179.55 төгрөг, банк хоорондын захын жилийн дундаж ханш 1181.85 төгрөг, валют солих цэгүүдийн арилжааны дундаж ханш 1182.10 төгрөг байлаа.

Сүүлийн 5 жилийн америк доллартай харьцах төгрөгийн ханшийн хөдөлгөөнийг авч үзэхэд 1 дүгээр сарын явцад төгрөгийн ханш Цагаан сарын бэлтгэл ажил, баярын холбогдолтой өргөн хэрэгцээний барааны импорт нэмэгддэгээс валютын зах дээр америк долларын эрэлт хэрэгцээ нэмэгдэж, төгрөг ам. долларын эсрэг суларч, баярын дараа эргээд чангартаг байсан бол 2006 оны нэгдүгээр улиралд төгрөгийн ханш сулаагүй, харин чангартч байв.

2006 оны 2 дугаар улирлын эхний сард төгрөг америк долларын эсрэг суларч, 5 дугаар сараас эхлэн он дуустал чангартсан хэвээр байлаа.

2006 онд улирлын чанартай ханшийн хэлбэлзэл арилсан нь манай экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ олон улсын зах зээл дээр өндөр хэвээр байгаа, дотоодын аж ахуйн нэгжүүдийн гадаадаас авсан зээл, хөрөнгө оруулалт, мөн аялал жуулчлалын орлого өмнөх жилүүдийнхээс тогтмол нэмэгдсэн, гадаадад хөдөлмөр эрхлэгч Монгол иргэдийн эх орон руугаа гүйвулах мөнгөний дүн өндөр хэвээр /ДНБ-ний 10 хувь хүртэл өссөн/ байгаа зэрэг манай улс руу чиглэсэн валютын урсгал эрчимтэй нэмэгдэж байгаатай холбоотой юм.

2006 оны эцсийн байдлаар банкууд дахь нийт хадгаламжийн хэмжээ 995.4 тэрбум төгрөгт хүрч 2005 онтой харьцуулбал 323.7 тэрбум төгрөг буюу 48.2 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс төгрөгийн хадгаламж 692.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 266.4 тэрбум төгрөг буюу 62.5 хувь, валютын хадгаламж 302.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 57.2 тэрбум төгрөг буюу 23.3 хувиар тус тус өссөн байна.

Банкуудад байршуулсан валютын хадгаламжийн хэмжээ 260.0 сая ам. доллар болж, нийт хадгаламжийн 30.4 хувьтай тэнцсэн байна. Үүнээс хугацаатай хадгаламжийн хэмжээ 168 сая ам. доллар буюу нийт валютын хадгаламжийн 64.8 хувь, хугацаагүй хадгаламжийн хэмжээ 91.3 сая ам. доллар буюу нийт валютын хадгаламжийн 35.2 хувийг тус тус бүрдүүлж байна.

Валютын хадгаламжийн 35.1 хувийг бүрдүүлдэг иргэдийн хугацаагүй валютын хадгаламж 17.5 сая ам. доллар буюу 23.8 хувиар, иргэдийн хугацаатай хадгаламж 23.5 сая ам. доллар буюу 19.3 хувиар тус тус өссөэ. 2006 онд валютын хадгаламжийн хэмжээ ийнхүү нэмэгдсэн боловч иргэдийн төгрөгийн хугацаагүй хадгаламж 90.5 хувиар, иргэдийн төгрөгийн хугацаатай хадгаламж 54.9 хувиар тус тус өссөн нь ханшийн чангараалтын улмаас иргэд төгрөгөөр хадгаламж байршуулах илүү сонирхолтой байгааг харуулж байна. Банкууд дахь валютын хадгаламжийн өсөлт банкуудын валютын зах дээрх валютын нийлуулэлтийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн болно.

### *Төгрөгийн бодит хани*

Тайлант оны эцэст төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 86.8, бодит үйлчилж буй ханшийн индекс 89.39 болж, суурь 2000 оноос төгрөг худалдааны түнш орнуудын валютын эсрэг нэрлэсэн үнээр 13.2 хувь, бодит үнээр 10.61 хувиар тус тус сулрав.

2006 оны төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 86.8 гарсан нь өнгөрсөн оныхоос 0.29 хувиар чангарсан байна. Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш дунджаар 2006 онд америк долларын эсрэг 2.1 хувиар, европийн эсрэг 1.23 хувиар, швейцарийн франкийн эсрэг 0.1 хувиар, английн паундын эсрэг 1 хувиар, БНХАУ-ын юаний эсрэг 0.6 хувиар, японы иений эсрэг 7.6 хувиар тус тус чангарч, ОХУ-ын рублийн эсрэг 1.7 хувиар, БНСУ-ын воны эсрэг 4.3 хувиар, Сингапур долларын эсрэг 2 хувиар тус тус суларсан байна.

### Хүснэгт 2.3 Төгрөгийн гадаадын валютуудын эсрэг хөдөлгөөн

(хувиар)

	Төгрөгийн нэрлэсэн дундаж ханш			
	2006/2000	2006/2005		
Ам. доллар	↑	9.60	↓	2.10
Евро	↑	49.10	↓	1.23
ОХУ-ын рубль	↑	11.50	↓	1.70
Швейцарын франк	↑	26.70	↓	0.10
Английн паунд	↑	16.70	↓	1.00
БНХАУ-ын юань	↑	11.70	↓	0.60
Японы йен	↑	1.40	↓	7.60
БНСҮ-ын вон	↑	22.10	↓	4.30
Сингапурын доллар	↑	13.30	↓	2.00

\* ↑ - суларсан

↓ - чангарсан

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийг ийнхүү чангараход манай улсын худалдааны түвш орнуудын валютын ханш тайлант онд америк долларын эсрэг ихээр чангарсан нь нөлөөлжээ.

Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн 2006 оны индекс 89.39 гарсан нь төгрөгийн худалдан авах чадвар 2000 оныхоос 10.61 хувиар суларсныг харуулж байна. Тус индекс нь өмнөх оныхоос 2.91 хувиар суларчээ. 2006 онд дотоодын үнийн өсөлт өмнөх оныхоос харьцангуй буурч худалдааны түвш орнуудын үнийн индекстэй харьцуулсан харьцаа өссөнөөс төгрөгийн бодит ханш ийнхүү суларчээ.

### Хүснэгт 2.4 Нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш, инфляци

(хувиар)

	2005	2006	Өөрчлөлт
Нэрлэсэн үйлчилж буй ханш	86.51	86.80	0.29
Бодит үйлчилж буй ханш	92.30	89.39	-2.91
Инфляци /жилээр/	9.50	6.00	-3.50



# ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮ

Тайлант онд зэс, алтны үнэ дэлхийн зах зээл дээр өндөр хэвээр байсан, төсвийн удирдлагыг боловсронгуй болгох талаар дэс дараатай арга хэмжээ авсны үр дүнд улсын төсвийн бүрдүүлэлт сайжирч, нийт тэнцэл болон урсгал тэнцэл ашигтай гарлаа.

Монгол улсын нэгдсэн төсвийн орлого 1360.4 тэрбум төгрөг (ДНБ-ий 42.9 хувь), зарлага 1237.0 тэрбум төгрөг (ДНБ-ий 39.0 хувь) болж, нийт тэнцэл 123.4 тэрбум төгрөг (ДНБ-ий 3.9 хувь) болон урсгал тэнцэл 371.7 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 11.7 хувь) ашигтай гарчээ.

## Хүснэгт 3.1 2006 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

(тэрбум төгрөгөөр)

	2005		2006			Хувь	
	Гүйцэтгэл	Хувийн жин	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Жин	Ө/о мөн үетэй	Оны төл
<b>Нийт орлого ба тусламж</b>	<b>837.85</b>	<b>100</b>	<b>1097.60</b>	<b>1360.41</b>	<b>100</b>	<b>162.37</b>	<b>123.94</b>
Урсгал орлого	832.58	99.37	1092.61	1354.10	99.54	162.64	123.93
Татварын орлого	692.20	83.14	880.07	1128.14	83.31	162.98	128.19
Орлогын албан татвар	178.54	25.79	315.87	476.83	42.27	267.07	150.96
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	95.60	13.81	104.37	111.93	9.92	117.09	107.25
Өмчийн татвар	6.33	0.91	6.39	6.91	0.61	109.20	108.19
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	271.00	39.15	310.44	352.72	31.27	130.16	113.62
Гадаад худалдааны орлого	56.97	8.23	55.36	72.07	6.39	126.50	130.19
Бусад татвар	83.77	12.10	87.65	107.67	9.54	128.53	122.84
Татварын бус орлого	140.38	16.86	212.54	225.96	16.69	160.96	106.31
Хөрөнгийн орлого	0.98	0.12	0.88	1.63	0.12	165.58	184.14
Тусламжийн орлого	4.29	0.51	4.10	4.69	0.34	109.21	114.27
<b>Нийт зарлага ба цэвэр зээл</b>	<b>764.60</b>	<b>100</b>	<b>1209.24</b>	<b>1237.01</b>	<b>100</b>	<b>161.79</b>	<b>102.30</b>
Урсгал зардал	600.29	78.51	876.97	982.35	79.41	163.65	112.02
Бараа ба үйлчилгээний зардал	386.72	64.42	583.03	692.49	70.49	179.07	118.78
Зээлийн үйлчилгээний төлбөр	20.68	3.45	26.75	18.08	1.84	87.42	67.58
Татаас ба урсгал шилжүүлэг	192.89	32.13	267.19	271.78	27.67	140.90	101.72
Хөрөнгийн зардал	89.82	11.75	209.69	175.67	14.20	195.59	83.78
Эргэж төлөгдөх цэвэр зээл	74.49	9.74	122.58	78.99	6.39	106.04	64.44
Урсгал тэнцэл	232.29		215.64	371.75		160.03	172.39
<b>Нийт тэнцэл</b>	<b>73.26</b>		<b>-111.64</b>	<b>123.40</b>		<b>168.45</b>	<b>-110.53</b>
Алдагдлыгсанхүүжүүлсэн эх үүсвэр	-73.26		111.64	-123.40		168.44	-110.54
Гадаад, цэвэр	89.98		148.84	74.30		82.58	49.92
Дотоод, цэвэр	-163.24		-37.20	-197.71		121.11	531.42

Эх сурвалж: СЯ

## Төсвийн орлого

Төсвийн нийт орлого ба тусlamжийн дүн төлөвлөсөн хэмжээнээс 262.8 тэрбум төгрөг буюу 23.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 522.6 тэрбум төгрөг буюу 62.4 хувиар өсч 1360.4 тэрбум төгрөгт хүрчээ.

Төсвийн нийт орлогын 99.5 хувийг бүрдүүлсэн урсгал орлого 2005 оныхоос 521.5 тэрбум төгрөг буюу 62.6 хувиар өсч, нийт орлого ба тусlamжийн дүнгийн өсөлтийг тодорхойлжээ. Урсгал орлогын 83.3 хувийг бүрдүүлсэн татварын орлого 435.9 тэрбум төгрөг буюу 63.0 хувиар нэмэгджээ. Орлогын албан татвар (татварын орлогын 42.3 хувийг бүрдүүлсэн) жилийн хугацаанд 298.3 тэрбум төгрөг буюу 2.7 дахин, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого (татварын орлогын 31.3 хувийг бүрдүүлсэн) 81.7 тэрбум төгрөг буюу 30.2 хувь, нийгмийн даатгалын шимтгэл ба хураамжийн орлого (татварын орлогын 9.9 хувийг бүрдүүлсэн) 16.3 тэрбум төгрөг буюу 17.1 хувиар өссөн байна.

Орлогын албан татвараар төсөвт орсон орлого бараг 3 дахин нэмэгдсэн нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар 177.5 тэрбум төгрөг төсөвт төвлөрсөнтэй холбоотой. Мөн аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар орсон орлого 101.8 тэрбум төгрөг буюу 84.4 хувиар өссөн нь зэсийн дэлхийн зах зээл дээрх үнэ өндөр байсан болон татварын суурь өргөжсөнтэй холбоотой. Эрдэнэт УУГазар, банкны салбар, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг зарим байгууллага, тухайлбал Мобиком ХХК, МЦХК төсөвт төлөх татварын төлөвлөгөөг давуулан биелүүлжээ. Ажиллагчдын цалин хөлс нэмэгдсэн, татвар хураалтын үйл ажиллагаа сайжирснаас нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлого өссөн байна.


Дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 68.4 хувийг бүрдүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 60.2 тэрбум төгрөг буюу 33.3 хувь, онцгой албан татварын орлого (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 28.4 хувь) 21.2 тэрбум төгрөг буюу 26.8 хувиар нэмэгджээ. Тайлант онд дотоодын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, импорт өссөн нь нэмэгдсэн өртгийн албан татварын орлого өсөхөд хүргэв. Харин онцгой албан татварын орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг дотоодын архины онцгой албан татвар 30.9 хувь, автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 4.1 хувь, суудлын автомашины онцгой албан татвар 56.5 хувиар тус тус өссөн нь онцгой албан татварын нийт орлогыг нэмэгдүүлжээ.

Гадаад худалдааны орлого 15.1 тэрбум төгрөг буюу 26.5 хувиар өссөнөөс импортын барааны гаалийн албан татварын орлого (гадаад худалдааны орлогын 90.5 хувийг бүрдүүлсэн) 12.1 тэрбум төгрөг буюу 22.7 хувиар нэмэгджээ. Харин бусад татварын орлогод ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (41.2 хувийн жинтэй) 12.6 тэрбум төгрөг буюу 39.9 хувиар өсчээ.


## Төсвийн зарлага

Тайлант онд төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оныхоос 472.4 тэрбум төгрөг буюу 61.8 хувь, төлөвлөсөн хэмжээнээс 27.8 тэрбум төгрөг буюу 2.3 хувиар тус бүр их байна.


**Зураг 3.1 Төсвийн ашиг, алдагдал (ДНБ-д эзлэх хувиар)**



**Зураг 3.2 Нийт орлого ба тусlamж**



**Зураг 3.3 Нийт зардал ба цэвэр зээл**



Урсгал зардал жилийн хугацаанд 382.1 тэрбум төгрөг буюу 63.6 хувь, хөрөнгийн зардал 85.9 тэрбум төгрөг буюу 95.6 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 4.5 тэрбум төгрөг буюу 6.0 хувиар тус тус өсчээ.

Урсгал зардлыг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзвэл, бараа үйлчилгээний зардал (70.5 хувь) 2005 оны гүйцэтгэлтэй харьцуулснаар 305.8 тэрбум төгрөг буюу 79.1 хувь, татаас ба шилжүүлэг (27.7 хувь) 78.9 тэрбум төгрөг буюу 40.9 хувиар тус тус нэмэгдэж, харин зээлийн үйлчилгээний төлбөр (1.8 хувь) 2.6 тэрбум төгрөг буюу 12.6 хувиар буурчээ. Тайлант онд Монгол улсыг хөгжүүлэх санд 177.5 тэрбум төгрөг (бараа, үйлчилгээний зардлын 25.6 хувь) төвлөрүүлсэн нь энэ хэмжээгээр бараа үйлчилгээний зардлыг өсгөлөө. Мөн цалин хөлс (бараа үйлчилгээний зардлын 28.4 хувь) өмнөх оныхоос 53.9 тэрбум төгрөг буюу 37.7 хувиар нэмэгджээ.

Урсгал зардлын 27.7 хувийг эзэлдэг татаас ба шилжүүлгийн өсөлтөд бусад урсгал шилжүүлэг 64.6 тэрбум төгрөг буюу 35.1 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Бусад урсгал шилжүүлэгт нийгмийн даатгалын зардал 40.9 тэрбум төгрөг буюу 31.0 хувь болон халамжийн сангийн зардал 33.1 тэрбум төгрөг буюу 79.2 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь Засгийн газраас цалин хөлс болон нийгмийн халамж, үйлчилгээний нөхөн олговрыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Тайлант онд хөрөнгө оруулалт (хөрөнгө оруулалтын нийт зардлын 83.0 хувь) 2005 оноос 78.8 тэрбум төгрөг буюу бараг 2 дахин их байна.

### *Орон нутгийн төсөөв*

2006 онд орон нутгийн төсвийн нийт орлого 96.2 тэрбум төгрөг, нийт зардал 95.6 тэрбум төгрөг болж, төсвийн ашиг 0.6 тэрбум төгрөгт хүрлээ.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 7.2 тэрбум төгрөгийн татаас шилжүүлсэн нь төлөвлөгөөт хэмжээнд байгаа бөгөөд өмнөх оныхоос 0.8 тэрбум төгрөг буюу 13.0 хувиар өсчээ.

## БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ

### 4.1 Банкны салбарын хөгжил

#### 1. Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүрд

Сүүлийн жилүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас банкинд байршуулсан эх үүсвэрийн дүн тогтмол нэмэгдэж байна. Тухайлбал, 2006 онд банкны салбарын харилцахын дүн 12.6 хувь буюу 39.9 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн дүн 48.2 хувь буюу 323.7 тэрбум төгрөгөөр тус тус өсч харгалзан 356.0 болон 955.4 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Энэ нь иргэд, байгууллагын банкинд итгэх итгэл дээшилж байгаагийн илрэл юм.

Харилцах, хадгаламжийн энэхүү өсөлтийн зэрэгцээ 2006 онд банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ 42.4 хувь буюу 87.7 тэрбум төгрөгөөр дээшилсэн нь нэг талаас банкууд дүрмийн сангaa Монголбанкнаас тавьсан шаардлагын дагуу 8.0 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлсэн, нөгөө талаас банкны салбарын өнгөрсөн оны ашиг түүхэнд анх удаа 30 гаруй тэрбум төгрөг болсон зэрэгтэй холбоотой юм. Үүнд банкны ашигт ажиллагааг илэрхийлсэн цэвэр ашиг болон нийт активын (“ROA”) харьцаа нь системийн дунджаар 2.7 хувьтай гарсан нь аж үйлдвэржсэн буюу өндөр хөгжилтэй зарим нэг орны үзүүлэлтээс өндөр байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Өөрийн хөрөнгө болон бусад эх үүсвэрийн өсөлт нь банкны салбарын нийт активыг 2006 онд 46.0 хувь буюу 729.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд нөлөөлжээ. Үүний үр дүнд банкны салбарын нийт актив 2.3 их наяд төгрөгт хүрч, ДНБ-ий 73.0 хувьтай тэнцүү болсон байна. Энэ нь банкны салбарын хямралт 1996-1998 оны үзүүлэлтээс 3 дахин өндөр байна.

Банкны салбарын актив өсөхийн хэрээр хувийн хэвшилд олгох зээл, санхүүжилтийн хэмжээ тогтвортой нэмэгдэж байна. Тухайлбал, 2000 онд банкууд 1700 хүрэхгүй тооны зээлдэгчдэд 60.0 орчим тэрбум төгрөгийн зээл олгож байсан бол 2006 оны эцэс гэхэд банкуудын зээлдэгчдийн тоо 409.7 мянга болж, зээлийн өрийн үлдэгдэл 1.2 их наяд төгрөгт хүрч 2000 оны үзүүлэлтээс бараг 20 дахин нэмэгджээ.

Өнгөрсөн он жилүүдэд банкууд зээлийн өрийн үлдэгдлээ эрчимтэйгээр нэмэгдүүлээд зогсохгүй, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, хөдөө орон нутаг буюу алслагдсан сум, багт санхүүгийн үйлчилгээг хүргэх, жижиг дунд үйлдвэрлэл болон орлого багатай иргэдийг зээлжүүлэх талаар тодорхой үр дүнд хүрсэн болно.

Нийт зээлийн 48 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 41 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт, 11 хувь нь хөдөө аж ахуйн салбарт олгогдсон байна. Тайлант үед барилга угсралтын чиглэлээр олгосон зээлийн хувийн жин 5 хувиар нэмэгдэж,

худалдаа, хөдөө аж ахуй болон уул уурхайн чиглэлээр олгосон зээлийн хувийн жин харгалзан 6, 3, 2 хувиар тус тус буурч, харин бусад салбарт олгосон зээлийн хувийн жин харьцангуй тогтвортой байв.

Тайлант онд чанаргүй зээл 21.3 хувиар өссөн боловч оны эцэст банкуудаас авсан арга хэмжээний дунд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин 0.8 нэгжээр буурч 4.9 хувьтай гарлаа. Сүүлийн жилүүдэд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин тогтвортой буурч байв.

Зарим нэг банкууд үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх талаар эрчимтэй бодлого явуулж байгаа бөгөөд үүний үр дүнд 2006 онд банкуудын салбар нэгжийн тоо 13.8 хувь буюу 101-ээр дээшиллээ. Үүнд Монгол шуудан банкны салбар нэгжийн тоо 54, ХААН банкных 26, Голомт банкных 10-аар тус тус нэмэгдсэн нь салбарын хэмжээгээр ийнхүү томоохон өөрчлөлт гарахад нөлөөлөв.

#### Хүснэгт 4.1 Банкуудын салбар нэгжийн тоо

		2006	2005	2004	2006/2005	2006/2004
1	ХААН банк	423	397	390	26	33
2	Худалдаа хөгжлийн банк	18	17	15	1	3
3	Хадгаламж банк	54	45	45	9	9
4	Голомт банк	33	23	16	10	17
5	Монгол шуудан банк	140	86	83	54	57
6	Эрэл банк	5	5	3	0	2
7	Улаанбаатар хотын банк	9	9	10	0	-1
8	Капитал банк	25	18	10	7	15
9	Тээвэр хөгжлийн банк	3	4	5	-1	-2
10	Кредит банк	10	9	8	1	2
11	Зоос банк	32	33	27	-1	5
12	Анод банк	21	23	23	-2	-2
13	Капитрон банк	18	20	11	-2	7
14	ХАС банк	39	40	34	-1	5
15	Менатеп банк	1	1	1	0	0
16	Чингис хаан банк	1	1	1	0	0
	Нийт	832	731	682	101	150

Шинээр байгуулсан салбар нэгжийн дийлэнх хэсэг нь хөдөө орон нутагт ногдож байгаа бөгөөд санхүүгийн салбар дахь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, хөдөө орон нутагт олгогдож байгаа зээлийн хүүг бууруулахад зохих хувь нэмэр үзүүлж байна.

## 2. Банкны салбарын хөрөнгө болон эх үүсвэрийн бүтэц

Сүүлийн үед зээлийн өрийн үлдэгдлийн жилийн дундаж өсөлт 40-46 хувийн хооронд хэлбэлзэж байсан боловч зээлийн нийт активт эзлэх хувийн жин тогтмол 57 хувьтай байв. Харин 2005-2006 онд улсын нэгдсэн төсөв ашигтай гарч, Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл багассан, Монголбанкнаас гаргасан үнэт цаасны хэмжээ хумигдсан зэргээс шалтгаалж банкуудын богино хугацааны хөрөнгө оруулалтын нийт активд эзлэх хувийн жин тогтвортойгоор буурч 4.4 хувьтай тэнцүү болсон байна. Хөрөнгө оруулалтын бололцоо хумигдахын хэрээр банкуудын мөнгөн хөрөнгө нэмэгдэж нийт активт эзлэх хувь хэмжээ нь 2006 оны эцэс гэхэд 32.0 хувьтай болов.

Банкны салбарын эх үүсвэрийн дийлэнх буюу 60-аас дээш хувийг харилцах, хадгаламж эзэлж байна. Сүүлийн жилүүдэд харилцах тодорхой хэмжээгээр нэмэгдсэн хэдий ч өсөлтийн хурд нь хадгаламжийн өсөлтийн хурдаас харьцангуй бага байсан тул нийт хөрөнгөд эзлэх хувийн жин нь буурсан байна. Бусад пассивын хувийн жин 6-9 хүртэл хувиар нэмэгдсэн нь банкууд хадгаламжийн сертификат болон бусад төрлийн санхүүгийн хэрэгслээр эх үүсвэр татах болсонтой холбоотой. Харин өөрийн хөрөнгийн хувьд Монголбанкнаас банкны дүрмийн сангийн доод хэмжээг 8 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэх арга хэмжээг авсаны үр дүнд нийт активт эзлэх хувийн жинг нь 10-аас дээш хувьтай байлаа.

Банкны салбарын актив, пассивын задаргааг үндэслэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Засгийн газраас гаргасан үнэт цаасны хэмжээ буурсан, хөрөнгийн зах зээлийн хөгжил банкуудын хөрөнгө оруулалтын хэрэгцээг хангах түвшинд хараахан хүрээгүй зэргээс шалтгаалж банкуудын багцын эрсдэлд диверсификаци хийх бололцоо хумигдаж байна
- Банкуудын хувьд харьцангуй өндөр зардалтай эх үүсвэр болох хадгаламжийн хувийн жин нэмэгдэж, харин хямд эх үүсвэр болох харилцахын хувийн жин буурч байна.

## 3. Банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд

### Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Банкны эрсдэлээ даах чадварыг нь илэрхийлдэг үндсэн үзүүлэлтүүдийн нэг бол өөрийн хөрөнгийн зохистой харьцаа юм. Энэхүү үзүүлэлт нь банкны системийн дунджаар сүүлийн жилүүдэд 17-20 хувийн хооронд хэлбэлзэж байсан нь Швейцарь дахь Базелийн хорооноос тогтоосон олон улсын стандартаас бараг 2-3 дахин өндөр байв.

Тайлант жилд зээл болон бусад эрсдэлтэй активын өсөлт харьцангуй өндөр байсан боловч Монголбанкнаас дүрмийн сангийн доод хэмжээг 8 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэх арга хэмжээ авсан, мөн банкууд харьцангуй өндөр хэмжээний ашигтай ажилласан зэрэг нь банкны салбарын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг бараг өөрчлөлтгүй буюу 18 хувьд барих бололцоог бүрдүүлжээ. Гэхдээ зарим банкны хувьд журмын доод шаардлага болох 10 хувьд ойрхон байгааг анхаарах нь зүйтэй.

## Хөрвөх чадвар

Монголбанк нь 2004 оноос эхлэн банкуудын актив пассивын эргэн төлөгдөх хугацааны талаар мэдээ цуглуулж эхэлсэн бөгөөд энэхүү мэдээнээс үзэхэд 2004-2006 онд банкуудын нийт активын 10 хүрэхгүй хувь нь 1 жилээс дээш хугацаатай байсан байна. Үүнд активын дийлэнх хэсгийг эзэлдэг зээлийн 30 хүрэхгүй хувь нь дунд болон урт хугацаагаар олгогдож байв. Харин банкуудын эх үүсвэрийн дийлэнх хэсэг буюу 95 орчим хувь нь 1 жил хүрэхгүй хугацаатай байсан бөгөөд хадгаламжийн дундаж хугацаа нь 3-4 сар байгаа болно. Үүнээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

- Ихэнх банкууд харьцангуй богино хугацааны эх үүсвэр татан төвлөрүүлж, түүнийхээ дийлэнх хэсгийг 1 жил буюу түүнээс доош хугацаатай активд байршуулж байна,
- Эх үүсвэр нэн ялангуяа хадгаламжийн жигнэсэн дундаж хугацаа 4 сараас хэтрэхгүй байгаа нь банкны бодлого гэхээсээ илүү иргэдийн эрсдэлээс сэргийлсэн үйлдэлтэй шууд холбоотой болов уу.
- Эцэст нь хэлэхэд банкны салбарын актив пассив эргэн төлөгдөх хугацааны хувьд харьцангуй тэнцвэртэй байгаа нь нэг талаас хөрвөх чадварын эрсдэлийг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байгаа боловч, нөгөө талаас банкуудаас хувийн хэвшилд хийж байгаа санхүүжилт нь дунд болон урт хугацааны төслийг хэрэгжүүлэхэд тэр болгон хангалтгүй байгааг харуулж байна.

## Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт

Монголбанкнаас баталсан журмын дагуу арилжааны банк нь гадаад валютын нээлттэй позицийг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байхыг шаарддаг. Банкны салбарын дундаж үзүүлэлтээр 2006 онд нийт нээлттэй позицийн зохистой харьцаа нь 27.4 хувиас 30.8 хувь хүртэл нэмэгдсэн байгаа нь Монголбанкнаас тогтоосон хязгаарт байна.


Тайлант онд гадаад валютын актив 38 хувь буюу 250 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 954 тэрбум төгрөгт хүрсэн (чанаргүй зээлийг цэвэршүүлсний дараа) бол гадаад валютын пассив 10 орчим хувь буюу 60 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 616 тэрбум төгрөг болов. Үүнд, гадаад валютын активын нийт активт эзлэх хувийн жин харьцангуй тогтвортой буюу 40 орчим хувьтай байсан бол, гадаад пассивын хувийн жин 6 хувиар буурч 29 хувь боллоо. Эдгээр өөрчлөлт нь нэг талаас төгрөг валютын хүүний зөрүү, нөгөө талаас төгрөгийн америк доллартай харьцах ханш жилийн хугацаанд 4.7 хувиар чангарсантай тодорхой хэмжээгээр холбоотой юм. Өөрөөр хэлбэл, ханшийн өөрчлөлт болон хүүний зөрүүгээс шалтгаалж, зээлийг гадаад валютаар авч, харин хадгаламжийг төгрөгөөр байршуулах нь ашигтай байсан байна.

Банкууд эх үүсвэрийнхээ өсөлт дээр тулгуурлан нийт актив болон зээлийн хэмжээг нэмэгдүүлж, улмаар эдийн засагт гүйцэтгэж буй санхүүгийн зуучлалын цар хүрээгээ өргөжүүлсээр байна. Банкуудын үйл ажиллагааны өргөжилт нь ашигт ажиллагааг харьцангуй өндөр түвшинд барих бололцоог бүрдүүлээд зогсохгүй, Монголбанкнаас тогтоосон үйл ажиллагааны зохистой хэмжээний хүрээнд явагдсан байна.

**Зураг 4.1 Банкуудын харилцах, хадгаламж, түүний ДНБ-д эзлэх хувь**



**Зураг 4.2 Банкны ашигт ажиллагаа  
(цэвэр ашиг болон нийт активын харьцаагаар)**



*Тайлбар: Монголоос бусад орны мэдээллийг Олон улсын валютын сангаас хагас жил бүр гаргадаг “Global Financial Stability Report” эмхэтгэлээс авав. Үүнд Австралийн үзүүлэлт 2005 оны байдлаар, бусад орны үзүүлэлт 2006 оны байдлаар байгааг анхаарна уу.*

## 4.2. Банкны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

Тайлант онд санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд, ялангуяа банкуудын үйл ажиллагаа эрчимжиж ирлээ. Манай улсын санхүүгийн салбарыг бүрдүүлж байгаа үндсэн байгууллагууд нь банкууд бөгөөд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд Монголбанкнаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавин ажиллалаа.

Банкуудын үйл ажиллагааны хүрээ өргөжихийн хэрээр тэдгээрт тавих хяналт шалгалтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох асуудал тулгарч байгаа бөгөөд банкууд өөрсдийн үйл ажиллагаанд учирч болзошгүй гол эрсдэлүүдийг сүүлийн үеийн аргуудаар тооцоолж, цаашдын үйл ажиллагааныхаа чиг хандлагыг тодорхойлох асуудал зүй ёсоор тавигдаж байна.

2001-2006 онуудад “Банкны салбарын бүтцийн өөрчлөлт, хөгжлийн талаарх богино хугацааны үзэл баримтлал” –д тусгасан стратегийн шинж чанартай зорилтууд болох санхүүгийн зуучлалын цар хүрээ болон чанарыг дээшлүүлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, цаашид санхүүгийн зах зээлд хямрал гарагчийг байх нөхцөл байдлыг бүрдүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн банкны салбарт итгэх итгэлийг хөхүүлэн дэмжих, банк санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах арга замыг боловсронгуй болгох, банк санхүүгийн байгууллагаар дамжуулан хууль бус үйл ажиллагаа явуулах боломжийг хаах нөхцлийг бүрдүүлэх зэрэг асуудалд анхаарч ажиллав.


2003-2006 онуудад банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний үр дүнд банкны салбарын актив, хадгаламж, зээлийн дүн ихээхэн өсөн нэмэгдсэн бөгөөд энэ нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны салбарт итгэх итгэл дээшилснийг харуулж байна.

Хяналт шалгалтын хүрээнд зохистой удирдлага, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг хангаагүй банкинд албадлагын арга хэмжээ авах асуудалд зохицуулалт хийх, активын ангилал, эрсдэлийн сангийн хүрэлцээ хангамжийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах, банкны үйл ажиллагааны эрсдэлийг тооцож, эрсдэлийн үнэлгээг хөрхэн хийх талаар зөвлөмж гаргах зэрэгээр хяналт шалгалтын бодлого, хяналт тавих механизмыг боловсронгуй болгож цаашид санхүүгийн зах зээл хямралд өртөхгүй байх нөхцөл боломжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.


Зорилтот хугацаанд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банк, санхүүгийн байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эрсдэлээ үүрэх чадварыг дээшлүүлэх үүднээс банкуудын дүрмийн сангийн доод хэмжээг 2 тэрбум төгрөгөөс 4 тэрбум төгрөгт, 4 тэрбум төгрөгөөс 8 тэрбум төгрөгт хүргэн үе шаттайгаар нэмэгдүүлсэн бөгөөд банкууд шаардлагыг заасан хугацаанд хангаж ажиллалаа.

Үүнээс үзэхэд банкны салбарын бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд банкны салбарын бүтцийн өөрчлөлт, хөгжлийн талаарх богино хугацааны үзэл баримтлалын гүйцэтгэлийн зорилт хангагдан биелэгдсэнтэй холбоотойгоор Хяналт шалгалтын газраас дараагийн шатны төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлэн хийж байна.

Зураг 4.3 ДНБ-д эзлэх банкны салбарын нийт актив



Зураг 4.4 Банкуудын зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбараар




Энэхүү шинэ стратегийн гол зорилго нь эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг хангахад банкны салбарын гүйцэтгэж байгаа үүргийг нэмэгдүүлэхэд орших бөгөөд чанарын үзүүлэлтүүдийн хүрээнд банкууд нь иргэд, аж ахуйн нэгж байгууллага болон төрийн санхүүгийн хэрэгцээг хангасан бүх төрлийн үйлчилгээг цогц хэлбэрээр үзүүлэх чадвартай болох, үүнтэй холбоотой эрх зүйн болон эдийн засгийн орчинг төрөөс бүрдүүлсэн байх зорилтыг тавин ажиллаж байна. Шинэ стратеги нь манай улсын банкны системийн онцлог талуудыг илүүтэй харгалзаж үзсэн, институциональ бус функциональ бүтцийг санал болгосноороо өмнөх стратегиас ялгаатай болно.

### *Үндсэн зорилго*


Монголбанкны Хяналт шалгалтын газар нь Төв банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, Төрийн мөнгөний бодлогын хүрээнд тусгагдсан зорилтуудыг биелүүлэх үндсэн зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг билээ. Улсын Их Хурлаас батлан гаргасан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2006 онд баримтлах үндсэн чиглэлд Хяналт шалгалтай холбоотой дараахь асуудлууд тусгагдсан байна:

- Экспортыг дэмжих, хөрөнгө оруулалтын зээл, санхүүгийн түрээсийн зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн болон эдийн засгийн орчинг бүрдүүлж, ажлын байр бий болгох хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлогыг дэмжинэ.
- Санхүүгийн гэрээ, хэлцлийн хугацааг уртасган, санхүүгийн зуучлал явуулж байгаа этгээдэд нэгдсэн байдлаар хяналт тавих тогтолцоо бүрдүүлэн, банк санхүүгийн салбарын тогтвожилтыг үргэлжлүүлэн гүнзгийрүүлнэ.
- Гадаад зах зээлээс урт хугацааны санхүүгийн эх үүсвэр татах замаар хөрөнгө оруулалт, худалдааг идэвхжүүлэх арга хэмжээ авна.
- Нийгмийн чухал ач холбогдол бүхий ипотекийн зах зээлийг гүнзгийрүүлнэ.
- Санхүүгийн зуучлалын зохистой удирдлага, эрсдэлийн хяналтын талаар гарсан шинэлэг ололтыг дэмжин, Банкны тухай хуульд заасан арилжааны банкинд тавих шаардлагад өөрчлөлт оруулна.
- Хөдөө орон нутагт өрсөлдөөнт санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, бичил санхүүгийн үйлчилгээний хүрээг өргөтгөх дорвитой арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- Монголбанкнаас арилжааны банкуудын активын чанар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, тэнцлийн гадуур хүлээж болзошгүй үүргүүдэд тавих хяналтыг сайжруулж, банкуудын дотоод хяналтын чадавхийг бэхжүүлнэ.
- Хадгаламж зээлийн хоршооны санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлж, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авна.

**Зураг 4.5 Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин**



**Зураг 4.6 Банкны салбарын активын бүтэц**



- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх ажлын хүрээнд банк, санхүү болон хууль хяналтын байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлнэ.
- Хадгаламжийн даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлэх, банкны нягтлан бодох бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлэх, мэдээллийн үнэн зөв, нээлттэй байдлыг хангана.

### *Хяналт шалгалтын тогтолцоо*


Банкуудад хяналт шалгалт хийж байгаа өнөөгийн тогтолцоо нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудад тавигддаг хяналтын нийтлэг, хулээн зөвшөөрөгдсөн үр ашигтай бүтцээр явагдаж байгаа бөгөөд цаашид боловсронгуй болгох зорилгоор Монголбанкнаас тухайн нөхцөл байдалд нь тохируулан зарим тодорхой өөрчлөлтүүдийг хийж ирлээ. Сүүлийн жилүүдэд банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны хүрээ өргөжин, шинэ техник технологи нэвтрэхийн хэрээр банкинд учирч болзошгүй эрсдэлүүд нэмэгдэж байна. Иймээс хяналт шалгалтыг үр дүнтэй явуулахын тулд заавар журмын хэрэгжилтийн хяналтаас эрсдэл дээр тулгуурласан хяналт шалгалтанд чиглүүлж, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, тодорхойлох арга хэрэгслийг боловсруулах, банкинд харилцагчдын зүгээс тавих хяналтыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна. Уг ажлын хүрээнд банкны үйл ажиллагаанд мөрдөх Монголбанкнаас баталсан дүрэм, журмыг олон улсын, ялангуяа Базелийн хяналт шалгалтын хорооноос гаргасан стандартад нийцүүлэх ажил хийгдэж байна.

#### *1. Банкуудад хийгдэж байгаа хяналт шалгалтын талаар*


Тайлант онд газар дээрх шалгалтын хүрээнд батлагдсан хуваарийн дагуу банкуудын санхүү, төлбөрийн чадварын байдал, үйл ажиллагаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан шалгалтын удирдамжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа арван гурван банкинд иж бүрэн шалгалтыг хугацаанд нь хийж гүйцэтгэн, арван нэгэн банкны шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулан, түүний биелэлтэд нь хяналт тавьж ажиллаж байна.

Иж бүрэн шалгалт нь шалгалтанд бэлтгэхээс эхлээд банкны санхүү төлбөрийн чадвар, удирдлага зохион байгуулалт, тайлан тэнцлийн бүхий л үзүүлэлтийг хамруулан шалгалт хийх, шалгалтын акт материал бэлтгэх, нэгдсэн танилцуулга хийх, төлбөр зөрчил, хууль тогтоомж зөрчсөн асуудалд улсын байцаагчийн акт тогтоох, банкны удирдлагуудаар шалгалтын үр дүнг танилцуулж, зөвшөөрүүлэх, нэгдсэн танилцуулгыг захирлын зөвлөлийн гишүүдэд танилцуулах, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын төслийг бэлтгэн батлуулах, шалгалтын акт материалыг цэгцлэн үдэж, товъёоглон Банкны үйл ажиллагааны хэлтэст шилжүүлэн өгөх арга хэмжээ авлаа.


Зураг 4.7 Банкны салбарын эх үүсвэрийн бүтэц



Зураг 4.8 Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



Зураг 4.9 Гадаад актив, пассивын нийт актив, пассивт эзлэх хувийн жин



Банкинд зайнаас хяналт тавих үйл ажиллагаагаар банкнаас ирүүлсэн мэдээлэл, тэдгээрийн динамик үзүүлэлт болон ашигт ажиллагаа, активын чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүдэд үндэслэн санхүү төлбөрийн чадварын байдалд дүгнэлт өгч, санхүү төлбөрийн чадвар нь хүндрэлд орсон банкуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу цаг алдалгүй арга хэмжээ авч ажиллалаа. Мөн 2006 оны 3-р сарын 31-ний дотор дүрмийн санг 8 тэрбумд төгрөгт Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын дагуу банкуудын дүрмийн сангийн бүрдэлтийг шалган баталгаажуулсан. Үүнээс гадна деривативын үйл ажиллагаа эрхлэгч банкуудад газар дээрх хэсэгчилсэн шалгалт хийж, дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлд танилцуулсан.

Түүнчлэн шалгалтын явцад банкны үйл ажиллагаанд тавих дотоод, гадаад аудитын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, удирдлагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, боловсон хүчний сургалтын системийг сайжруулах зэрэгт онцгой анхаарал тавин ажиллаж байна.

## *2. Хяналт шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авсан арга хэмжээ*

Хяналт шалгалтын газар нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд банкуудад газар дээр болон зайнаас хяналт шалгалт хийн, холбогдох журам заавруудыг шинэчлэн боловсронгуй болгохын зэрэгцээ тэдгээрийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн, зохистой түвшинд хүргэхийн тулд тодорхой чиглэлүүдээр зөвлөмж, аргачлалуудыг гарган хүргүүллээ. Үүнээс гадна Олон улсын санхүүгийн байгууллага болон хандивлагч орнуудаас манай орны эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн шинж чанартай асуудлууд болох орон сууц, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх төслийн хөрөнгийг банкуудаар дамжуулан олгох талаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллан, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүрэлдэхүүнд орон ажиллаж байна.

Базель 2-ын стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Монголбанкнаас 2003 онд “Зах зээлийн эрсдэлийг тооцоолох зөвлөмж”, 2004 онд “Зээлийн эрсдэлийг тооцоолох зөвлөмж”-ийг боловсруулж гаргасан бөгөөд 2006 онд Базель 2-т заасан банкны хэмжих шаардлагатай гурав дахь эрсдэл болох үйл ажиллагааны эрсдэлтэй холбоотой “Банкуудын үйл ажиллагааны эрсдэлийг тооцох зөвлөмж”-ийг боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 537 тоот тушаалаар баталсан. Мөн зах зээлийн эрсдэлийн удирдлагыг орчин үеийн арга техниктэй уялдуулах үүднээс зохистой харьцааны журамд стресс тесттэй холбоотой оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг “Зах зээлийн эрсдэлийг стресс тэстээр үнэлэх зөвлөмж”-ийн хамт боловсрууллаа.

Хяналт шалгалтын газар нь олон улсын стандарт, зааврыг дагаж мөрдөхөөс гадна тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүрт холбогдох хууль, журамд тусгаж байдаг. Тайлант онд НББОУС 32 болон 39-т орсон нэмэлт өөрчлөлт болон 2005 онд батлагдсан “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай хууль”-ийг “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-тай уялдуулах зорилгоор уг журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан.

Тайлант онд төрийн өмчийн оролцооны томоохон хувийг эзэлдэг сүүлийн банк болох Хадгаламжийн банк хувьчлагдав. Ингэснээр хоёр банк л төрийн буюу орон нутгийн өмчийн багахан оролцоотой үлдэж байгаа бөгөөд үүгээр Монгол улс хоёр шатлалт банкны системд шилжих шилжилтийн үйл явц ерөнхийдөө дуусч байгаа юм.

Санхүүгийн байгууллагуудын өрсөлдөөн нэмэгдэж, үйл ажиллагааны цар хүрээ нь өргөжих хандлагатай байгаа өнөөгийн нөхцөлд тэдгээртэй холбоотой хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага урган гарч байна. Үүнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хороог байгуулж, санхүүгийн нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог бий болгох үүднээс “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийг Хууль зүйн яам, Сангийн яам, Азийн хөгжлийн банк болон Монголбанкнаас хамтран боловсруулж, Улсын их хурлаас баталсан. Үүний үр дүнд банкны хяналт шалгалтыг Монголбанк, бусад санхүүгийн байгууллагын хяналт шалгалтыг Санхүүгийн зохицуулах хороо тус тус хариуцааар болж байгаа юм. Монголбанк 2006 оны 3-р сард банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршоодыг хянах үүргээ Санхүүгийн зохицуулах хороонд шилжүүлсэн бөгөөд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран ажиллаж, мэдээлэл солилцох зайлшгүй шаардлага урган гарч ирсэн. Үүний дагуу Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Сангийн яам хоорондын хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичгийг боловсруулж, батлуулсан бөгөөд “Монголбанк Санхүүгийн зохицуулах хороотой мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам” -ын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудад санал авахаар хүргүүлэв.

Хадгаламж, зээлийн хоршоодын хууль эрх зүйн орчин сайн биш, төрийн болон хадгаламж эзэмшигчдийн хараа хяналт сул байснаас 2006 онд хадгаламж зээлийн хоршоод олноор дампуурч, хадгаламж эзэмшигчдийг хохироосон билээ. Хадгаламж, зээлийн хоршоодын хууль эрх зүйн орчинг сайжруулах ажлын хүрээнд “Хадгаламж зээлийн хоршооны хууль”-ийн төслийг Монголбанкнаас боловсруулсан бөгөөд одоо Санхүүгийн зохицуулах хороо хариуцаж байна.

Банкны хяналт шалгалтын үндсэн зорилго нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагчдын хөрөнгийг хамгаалах явдал юм. 2005 онд харилцагчдыг хөрөнгийг хамгаалах зорилготой “Хадгаламжийн даатгал”-ын хуулийн төслийг Сангийн яам, ХЗДХЯамтай хамтран боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн бөгөөд УИХ-ын хуралд өргөн бариад байгаа билээ.

Монгол улсад Санхүүгийн тогтвортой байдлын асуудлыг хариуцсан зөвлөл байгуулах талаар судалгаа хийж, энэ асуудлыг Сангийн яаманд танилцуулж, дэмжлэг авсан. Зөвлөл нь санхүүгийн системийн эрүүл, тогтвортой байдлыг магадлан хянах, учирч болзошгүй санхүүгийн хямралаас урьдчилан сэрэмжлүүлэх дохиог олон нийтэд өгөх, шаардлагатай тохиолдолд санхүүгийн байгууллагуудын удирдлагын үйл ажиллагаанд нөлөөлэх, санхүүгийн туслалцаа үзүүлэх болон тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааг улам үр дүнтэй болгох зорилготой юм. Мөн үүнтэй холбоотойгоор банк, санхүүгийн системийн эрсдэл (хямрал)-ийг урьдчилан таамаглах үзүүлэлтүүдийг дохиоллын аргачлалаар тооцоолох аргыг боловсруулав.

Тайлант онд эдгээрээс гадна дараахь журам, заавар, судалгааг Хяналт шалгалтын газраас хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Азийн хөгжлийн банкны Санхүүгийн салбарын хөгжлийн З дахь шатны хөтөлбөрийн хүрээнд тавигдаж буй шаардлагын дагуу “Банкны зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 594 тоот тушаалаар батлуулан банкуудад хүргүүлсэн.
- Хуулийн хэлтэстэй хамтран лизингийн тухай хуулийг эцэслэн боловсруулж 2006 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-аар баталсан.
- Сангийн бодлого, мөнгөний бодлого, зохицуулалтын бодлогын харилцан хамаарлын талаар судалгаа хийсэн.
- 2004 онд Монгол улс Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүлэгт (Asia/Pacific Group) элссэн бөгөөд 2006 онд тус бүлгээс Улс хоорондын үнэлгээ хийх гэж байгаатай холбогдуулан ирүүлсэн асуулгын хяналт шалгалттай холбоотой хэсэгт хариулт өгсөн.
- Банкны системийн актив хөрөнгийн 2001-2005 оны байдлаар судалгаа хийсэн.
- Нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандарт батлуулах тухай саналыг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.
- Хуулийн хэлтэс болон Сургалтын төвтэй хамтран Зүүн бүсийн аймгуудын банкны ажилтнуудад зориулан сургалт зохион байгуулсан.
- Азийн хөгжлийн банкны Санхүүгийн салбарын З дахь шатны хөтөлбөрийг батлуулах талаар Сангийн яам, ХЗДХЯ, Үнэт цаасны хороо болон Улсын мэрэгжлийн хяналтын газартай хамтран ажилласан.
- Дэлхийн банкны Хувийн хэвшлийг хөгжүүлэх 2 дахь шатны хөтөлбөрийг УИХ-аар батлуулах талаар Сангийн яамтай хамтран ажилласан.
- ЕСБХБ-аас шаардсан мэдээллийн дагуу арилжааны банкуудаас зээл, орон сууцны барьцаатай холбоотой тоон мэдээллийг цуглуулж, түүнчлэн Монголын банк санхүүгийн хөгжлийн үе шатуудыг харуулсан дүгнэлт бүхий танилцуулга, судалгааг англи хэлнээ хөрвүүлэн хүргүүлсэн.
- Parker Randell International компанийн хуулийн зөвлөхийг Монголын арилжааны банкуудад Дотоод аудитын үйл ажиллагаа болон зохистой удирдлагын зарчмын талаар сургалт явуулах ажлыг зохион байгуулсан.
- Төгрөгийн ханшийн чангаралтыг судлах ажлын хэсэгт орж ажиллан, холбогдох танилцуулгыг бэлтгэсэн.
- Банкуудын хадгаламжийн үлдэгдэл болон хүүний талаар PANEL мэдээн дээр үндэслэн, Panel Cointegration болон Panel Critical Value of Pedroni-ийн аргыг ашиглан судалгааны ажил хийсэн.
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний талаар банкинд тавьж буй шаардлагыг хоёрдогч өглөгийн тусlamжтайгаар орлуулах асуудлыг судалсан.

## 5.1 Гадаад орчин

### *Дэлхийн түүхий эдийн зах зээл*

Түүхий эд олборлогч, экспортлогч хөгжиж буй орнуудын хувьд дэлхийн түүхий эдийн зах зээлийн төлөв байдал тухайн орнуудын эдийн засаг, импортын хүчин чадал болон бусад эдийн засгийн үзүүлэлтүүдэд шууд нөлөөлдөг.

2006 онд алтны хэрэглэгчид болон хөрөнгө оруулагчид нийт дэлхийн алтны хэрэгцээг 65.3 тэрбум ам. доллар хүртэл өсгөв. “GFMS” компанийн мэдээлж байгаагаар 2006 онд дэлхийн алтны нийт хэрэгцээ биет хэмжээгээр 3,361.6 тонн байсан бол тухайн онд алтны нийт нийлүүлэлт 13.4 хувиар буурч биет хэмжээгээр 3,451 тонн болжээ. Харин 2005 онд алтны нийт хэрэгцээ биет хэмжээгээр 3,729.3 тонн, нийлүүлэлт 3,984 тонн байжээ.

Нөгөө талаас хөрөнгө оруулагчид, Төв банкууд, нефть экспортлогч орнууд нефтийн үнийн өсөлтийн улмаас бий болж буй инфляци, валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн гарч болзошгүй алдагдлаас хөрөнгөө хамгаалах зорилгоор алт ихээр худалдан авч байсан нь 2006 оны эхний хагас жилийн явцад нэг унц алтны дэлхийн зах зээлийн үнийг эрчимтэй өсгөв. Тайлант оны 5 дугаар сарын 12-ны өдөр Лондонгийн бирж дээр нэг унц алтны үнэ 725.8 ам. долларт хүрч байлаа. Энэ нь тухайн оны алтны үнийн дээд цэг байв. Харин жилийн явцад алтны үнэ буурч 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэг унц алтны үнэ 634.3 ам. доллартай тэнцэж байв. Энэ үнэ нь 2005 оны мөн үеийнхээс 23.9 хувиар их байлаа. 2006 оны нэг унц алтны дундаж үнэ өмнөх оныхоос 36.0 хувиар их байсан бөгөөд 603.77 ам. доллар байв.

2006 онд бусад өнгөт металлын үнэ өсөхийн зэрэгцээ зэсийн дэлхийн зах зээлийн үнэ оны эхний 5 сарын турш өсч байгаад 5 дугаар сарын 11-ний өдөр Лондонгийн металлын бирж дээр нэг тонн зэсийн спот үнэ 8600 ам. долларт хүрч байлаа. Энэ үнийг 2005 оны 12-р сарын үнийн байдалтай харьцуулбал бараг 2 дахин их байв.

Сүүлийн 3 жилийн турш дэлхийн зэсийн зах зээл дээр цэвэршуулсэн зэсийн эрэлт хэрэгцээ их, түүний нийлүүлэлт харьцангуй хязгаарлагдмал байв. 2006 онд Индонези, Чили, АНУ-ын зэсийн томоохон уурхайнуудад гарсан үйлдвэрийн зогсолт, Чили, Мексикийн зэсийн уурхайн ажилчдын ажил хаялт зэрэг шалтгаанаас дэлхийн зэсийн олборлолтын нийт хэмжээ урьдчилан тооцоолж байснаас харьцангуй буурсан нь зэсийн үнийг өсөхөд нөлөөлж байв.

БНХАУ нь 2006 оны дэлхийн хамгийн том хэрэглэгч хэвээр байсан бөгөөд тус улсын хэрэгцээ нь дэлхийн зэсийн нийт нийлүүлэлтийн 20 хувьтай тэнцэж байлаа.

2006 онд Лондонгийн биржийн нэг тонн зэсийн спот үнэ дунджаар 7,141.55 ам. доллар байсан бөгөөд энэ нь өмнөх оныхоос бараг 2.3 дахин их байгаа юм. Харин 2006 оны 12 дугаар сарын байдлаар Лондонгийн биржийн нэг тонн зэсийн үнэ өмнөх сарын байдалтай харьцуулбал 5.1 хувиар буурч 6,671.26 ам. доллартай тэнцэж байв.

## Дэлхийн нефтийн зах зээл

Тайлант онд дэлхийн нэг өдрийн нефтийн хэрэгцээ өмнөх оныхос 0.9 хувиар өсч 84.5 сая баррель болов. Хөгжингүй орнуудын нэг өдрийн нефтийн хэрэгцээ 2006 онд өмнөх оныхос 0.6 хувиар буурсан хэдий ч 50.61 сая баррель байв. АНУ-ын эдийн засаг нь 2006 оны байдлаар дэлхийн хамгийн том нефтийн хэрэглэгч хэвээр байлаа. Европ болон Номхон далайн бүсийн хөгжингүй орнууд нүүрсний эрчим хүчний үйлдвэрлэлд эргээд шилжих арга хэмжээ авч эхэлсэн, мөн байгалийн хийг илүү их ашиглах болсноос тэдгээр орнуудын нефтийн хэрэглээ аажмаар буурах хандлагатай байна.

Хүснэгт 5.1 Дэлхийн нефтийн хэрэгцээ 2005-2006

	2005	2006
Дэлхийн хэрэгцээ, өдрийн сая баррелиар	83.6	84.5
Жилийн өөрчлөлт, хувиар	1.4	1.1
Жилийн өөрчлөлт, өдрийн сая баррелиар	1.2	0.9

Хүснэгт 5.2 Дэлхийн нефтийн хэрэгцээ, эдийн засгийн бүсээр 2005-2007  
(сая баррель/өдөрт)

	2006 оны хэрэгцээ	Жилийн өөрчлөлт		Жилийн өөрчлөлт (хувиар)	
		2005	2006	2005	2006
Хойд Америк	25.44	0.13	-0.06	0.50	-0.30
Европ	16.20	0.04	-0.03	0.20	-0.20
Номхон далайн бүсийн хөгжингүй орнууд	8.47	0.10	-0.12	1.20	-1.40
БНХАУ	6.98	0.18	0.37	2.80	5.60
Азийн бусад орнууд	8.87	0.16	0.09	1.80	1.00
ТТҮХН-ийн орнууд	3.95	0.05	0.15	1.30	4.00
Ойрхи Дорнод	6.45	0.32	0.33	5.60	5.40
Африк	2.94	0.08	0.07	3.00	2.40
Латин Америк	5.20	0.13	0.11	2.70	2.10
Нийт дэлхий	84.49	1.19	0.91	1.40	1.10

2006 онд ТТҮХН орнуудын хэрэгцээ урьдчилан тооцож байснаас бага гарч, БНХАУ-ын нефтийн хэрэгцээ таамаглаж байснаас бага - 5.6 хувиар өссөн / судлаачид 2006 онд БНХАУ-ын нефтийн хэрэгцээг 6.2 хувиар өснө гэж таамаглаж байсан/ хэдий ч хөгжиж буй орнуудын нийт нефтийн хэрэгцээ өмнөх оныхос 3.2 хувиар өсөв.

Дэлхийн нэг өдрийн нефтийн нийлүүлэлт 2006 оны байдлаар 85.4 сая баррель байв. 2006 онд Хойд Америк болон Хойд тэнгисийн нийлүүлэлт нэмэгдэж, харин Каспийн тэнгис болон ОПЕК-ийн нийлүүлэлт багасч байлаа.

ОПЕК-ийн гишүүн бус орнууд 2006 онд өдөрт 50.9 сая баррель нефть зах зээлд нийлүүлж байсан бөгөөд хэмжээг өмнөх оны байдалтай харьцуулбал 0.6 сая баррелиар нэмэгдсэн байна.

Опекийн орнууд зах зээлийн нөхцөл байдлыг харгалзаж 2006 оны 11 дүгээр сард өдрийн нийлүүлэлтийнхээ хэмжээг 500 килобаррелиар багасгаж нийтдээ 28.8 сая баррель нефть нийлүүлж байлаа. Олон улсын зах зээлд өдөрт 1.8 болон 2.2 сая баррель нефть тус тус нийлүүлдэг Ирак болон Нигерийн нийлүүлэлт 2006 оны турш тасалдаж байлаа.

2006 онд ОХУ-ын “Юралс”-ын дундаж спот үнэ өмнөх оныхоос 21 хувиар нэмэгдэж 60.97 ам. доллар байв. Тухайн оны 8-р сарын 11-ний өдөр Юралс нефтийн үнэ 72.95 ам. долларт хүрч байлаа. Энэ нь тухайн оны үнийн дээд цэг байв.

Тайлант оны 8 дугаар сараас эхлэн зах зээл дээр нийлүүлэлт тогтворжиж нефтийн үнэ буурч эхэлсэнтэй холбоотойгоор ОПЕК-ийн орнууд үнийг цаашид их хэмжээгээр бууруулахгүйн тулд олборлолтын хэмжээгээ багасгах талаар арга хэмжээ авч эхэлсэн.

ОПЕК-ийн орнууд 10 дугаар сард олборлолтын хэмжээгээ 1.2 сая баррелиар багасгах шийдвэр гаргаж байсан бол 12 дугаар сард Нигерийн нийслэл Абуджад зохиогдсон гишүүдийн ээлжит уулзалтаар олборлолтын хэмжээгээ 2007 оны 2 сараас эхлэн дахин 500 килобаррелиар бууруулах тухайгаа мэдэгджээ.

## 5.2 Гадаад худалдааны индекс

Манай улсын экспорт болон импортын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа нь эдийн засаг тэлж, дотоодын бизнесийн орчин таатай байгааг илтгэж байна.

Тайлант оны эцэст манай улсын экспортын индекс суурь 2000 онтой харьцуулахад бараг 2.2 дахин, өнгөрсөн оныхоос 70 хувиар өсчээ. 2006 оны импортын индекс суурь 2000 онтой харьцуулахад 1.7 дахин, өнгөрсөн оныхоос 23.0 хувиар өсчээ.

Экспортын индексийн өсөлтөд экспортын гол бараа бүтээгдэхүүн болох алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, импортын индексийн өсөлтөд нефтийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт гол нөлөөг үзүүлжээ. 2006 онд манай улсын нефтийн бараа бүтээгдэхүүний импорт биет хэмжээгээр 15.5 хувиар нэмэгдэж улсын нийт импортын 28.4 хувийг бүрдүүлсэн.

Тайлант онд гадаад худалдааны индекс суурь 2000 онтой харьцуулахад 31.4 хувиар өссөн бол өмнөх оныхоос 28.3 хувиар өсчээ.

Дэлхийн нефтийн зах зээлийн үнэ 2006 онд 21 хувиар нэмэгдсэн хэдий ч манай улсын экспортын гол бараа бүтээгдэхүүн болох алтны үнэ 35.8 хувиар, дэлхийн зэсийн зах зээлийн үнэ 2.3 дахин нэмэгдсэн тул манай улсын гадаад худалдаанд өмнөх оны байдалтай харьцуулахад илүү таатай орчин үйлчилж байв.

### 5.3 Ургал данс

Тайлант онд Монгол улсын төлбөрийн тэнцлийн ургал данс 306.3 сая ам. долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оноос 3.6 дахин сайжирч, ДНБ-ий 11.4 хувьд хүрлээ. Үүнд, бараа болон үйлчилгээний тэнцэл эрс сайжирч, ялангуяа гадаад худалдааны ашиг тогтвортой нэмэгдэн, аялал жуулчлалын салбарын орлого эрс өссөн, ургал шилжүүлэг тухайлбал, гадаад орнуудад ажиллаж буй монгол иргэдийн хувийн гүйвуулгын хэмжээ, засгийн газрын техник туслалцааны орлого нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

2006 онд гадаад худалдаа 188.5 сая ам. долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 217.3 сая ам. доллараар сайжирчээ.

Хамтарсан үйлдвэрүүд 87.8 сая ам. долларын ногдол ашгийг гадагш шилжүүлсэн, засгийн газар болон хувийн хэвшил нийтдээ гадаадын зээлийн хүүд 14.6 сая ам. долларыг төлсөн болон ажиллагдын цалин хөлс 1.6 сая ам. доллар болж буурсан зэрэг нь цэвэр орлогын данс 86.9 сая ам. долларын алдагдалтай гарахад голлон нөлөөлсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан гүйвуулгын орлого 20.6 сая ам. доллараар буурч 153.6 сая ам. доллар болсон байна. Хадгаламж зээлийн хоршоод олноороо дампууран, санхүүгийн хүндрэлд орох болсонтой холбоотойгоор гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн гүйвуулгын хэмжээ буурсан байна. 2006 онд банкуудаар дамжин орж ирсэн хувийн гүйвуулгын хэмжээ ДНБ-ий 5.7 хувьтай тэнцэж байна.

### Гадаад худалдаа

2006 онд гадаад худалдааны эргэлт 2,901.9 сая ам. долларт хүрлээ. Төлбөрийн тэнцэлд импортын үнийн дүнг С.И.Ф нөхцлөөс Ф.О.Б нөхцөлд шилжүүлж тооцсоноор нийт импорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.6 хувиар нэмэгдэж 1,356.7 сая ам. доллар болж, экспортын хэмжээ 44.6 хувиар нэмэгдэн 1,545.2 сая ам. долларт хүрч худалдааны тэнцэл 188.5 сая ам. долларын ашигтай гарсан нь гадаад худалдааны үр ашиг жил тутам өсч байгааг харуулж байна.


Гаалийн ерөнхий газрын мэдээгээр 2006 онд гадаад худалдааны нийт эргэлтийн хэмжээ 2005 оныхоос 779.2 сая ам. доллар буюу 34.6 хувиар өсч 3,028.4 сая ам. долларт хүрчээ. Тайлант онд нийт экспорт нийт импортыг давж гадаад худалдааны тэнцэл анх удаа 57.2 сая ам. долларын ашигтай гарлаа.

2006 онд манай улсын экспортын нийт орлогын 69.4 хувийг бүрдүүлсэн алт, зэс, ноолуурын зах зээлийн үнэ өндөр байсан нь манай улсын экспортын орлогыг нэмэгдэх, гадаад худалдааны тэнцлийн тэнцвэртэй байдлыг бий болгоход ихээхэн үүрэг гүйцэтгэв.

Зураг 5.1 Лондонгийн биржийн алтны үнэ



Зураг 5.2 Лондонгийн металлын биржийн зэсийн үнэ



Сүүлийн жилүүдэд Монгол улсын алтны экспорт тогтмол нэмэгдэж алт нь манай улсын экспортын гол бараа бүтээгдэхүүний нэг болсон. 2006 оны байдлаар Монгол улс 15.4 тонн алт экспортолж, экспортын орлогын 17.5 хувийг бүрдүүллээ. Гэхдээ 2006 онд экспортлосон алтны биет хэмжээ өмнөх оныхоос 8.4 тонн буюу 35.9 хувиар буурчээ.

Экспортод гаргасан эрдэс бүтээгдэхүүний экспортын 87.7 хувийг зэсийн баяжмал, молибдены баяжмал, хайлуур жонш, түүхий нефть болон чулуун нүүрсний экспорт эзэлж байна. 2006 онд нийт 599.5 мянган тонн зэсийн баяжмал экспортолж 635.4 сая ам. долларын экспортын орлого олжээ. Хувийн жингээрээ эхэнд ордог гол экспортын бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалын экспорт 2006 оны байдлаар манай улсын нийт экспортын 41.2 хувийг бүрдүүлэв. Зэсийн баяжмалын экспорт биет хэмжээгээр өмнөх оныхоос 12.5 мянган тонноор нэмэгджээ.

Тайлант онд нийт зэсийн баяжмалын экспортын 100.0 хувийг Хятадад гаргав. Монгол улсын олборлож байгаа зэсийн хэмжээ дэлхийн нийлүүлэлтийн 4.0 орчим хувийг бүрдүүлж байв.

2006 онд Монгол улс нийтдээ 4.4 мянган тонн төрөл бүрийн ноолуур, 471.8 мянган ширхэг ноолууран бүтээгдэхүүн экспортолж, нийт 165.2 сая ам. долларын орлого олсон нь 2006 оны экспортын 10.7 хувийг эзэлж байна. Хувийн жингээрээ ноолуур манай улсын экспортын 3 дахь гол бүтээгдэхүүн юм.

Импортын барааны бүтцийг авч үзвэл машин, механик тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл болон нефть бүтээгдэхүүн нийт импортын 41.7 хувийг бүрдүүлж байна.


Манай улс өөрийн хэрэгцээний нефть бүтээгдэхүүнийг 100.0 хувь импортоор авдаг тул дэлхийн нефтийн зах зээлийн байдал манай улсын гадаад худалдаанд шууд нөлөөлдөг. 2006 онд нефть бүтээгдэхүүний импортын биет хэмжээ 87.3 мянган тонноор нэмэгдэж, импортын дундаж үнэ 537.7 ам. доллараас 650.9 ам. доллар болж нэмэгдсэнээр импорт үнийн дунгээр 120.4 сая ам. доллараар өсөв.

### Хүснэгт 5.3 Нефтийн бүтээгдэхүүний импорт


Он	Нефтийн бүтээгдэхүүний жилийн импорт, сая кг	Импортын хэмжээний өөрчлөлтийн индекс
2000	445.3	100.0
2001	493.7	110.9
2002	453.6	101.9
2003	513.6	115.3
2004	574.8	129.1
2005	561.9	126.2
2006	649.3	145.8

Тайлант оны эцсийн байдлаар манай улсын эдийн засаг 649.3 мянган тонн нефть бүтээгдэхүүн хэрэглэжээ. Манай улсын нефть бүтээгдэхүүний хэрэгцээ 2006 онд 2000 оныхоос 45.8 хувиар, 2005 оныхоос 19.6 хувиар тус тус өсчээ.

Зураг 5.3 ОХУ-ын нефтийн Юралс үнэ



Зураг 5.4 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн индекс



ДНБ-ийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор авч буй арга хэмжээ, автомашин, техникийн импортын өсөлт зэргээс манай улсын нефть бүтээгдэхүүний хэрэглээ цаашид улам нэмэгдэх хандлагатай байна.

### *Импортыг экспортоор нөхөх коэффициент*

2006 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын импорт 1.49 тэрбум ам. доллар, экспорт 1.54 тэрбум ам. долларт хүрч экспорт нь анх удаа импортыг давж худалдааны тэнцэл 57.2 сая ам.долларын ашигтай гарч, импортыг экспортоор нөхөх коэффициент 103.8 хувьд хүрэв.

Тус коэффициент нь суурь 2000 оны жилийн эцсийн байдалтай харьцуулбал 36.9 хувиар, өмнөх оны /2005 оны/ байдалтай харьцуулбал 16 хувиар нэмэгджээ.

Сүүлийн жилүүдэд манай улсын импортыг экспортоор нөхөх коэффициент нь сайжирсаар улмаар 2006 оны эцсийн байдлаар 103.8 хувьтай болсон нь манай улсын гадаад худалдааны үр ашиг сайжирч, худалдааны тэнцлийн тэнцвэртэй байдлыг бий болгож манай улсын валютын орлогыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг болсныг харуулж байна.

### *Үйлчилгээ ба шилжүүлэг*

Тайлант онд үйлчилгээний нийт орлого 511.7 сая ам. доллар, зарлага 522.1 сая ам. доллар болж үйлчилгээний тэнцэл 10.4 сая ам. долларын алдагдалтай гарсан байна.

Үйлчилгээний тэнцэл сайжрахад жуулчлалын салбарт орсон орлого нэмэгдсэн болон харилцаа холбооны үйлчилгээ ашигтай гарсан, санхүү, бизнесийн үйлчилгээ, эмчилгээ, боловсрол, соёлын зэрэг бусад үйлчилгээний алдагдал эрс буурсан нь голлон нөлөөлжээ.


Монголбанкны Валютын газраас явуулсан судалгаагаар тайлант онд Монгол улсад нийт 309.1 мянган гадаадын жуулчид зорчиж, тэдгээрийн орлого 206.4 сая ам. долларт хүрсэн байна. Их Монгол улс байгуулагданы 800 жилийн ойтой холбогdon 3 дугаар улиралд Монгол улсад ирсэн гадаадын жуулчдын тоо эрс өсч жуулчлалын салбарт орсон орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үйлчилгээний тэнцлийг ийнхүү ашигтай гаргахад хүргэсэн байна.

Харин Монгол улсын нийт 817.6 мянган иргэн (давхардсан тоогоор) гадаадад зорчсоноос 308.5 мянган жуулчин гадаадад аялж манай судалгааны дундаж зардлаар тооцоход 166.4 сая ам. долларын зарлага гаргажээ.


2006 онд харилцаа холбооны үйлчилгээ 8.3 сая ам. долларын ашигтай гарч Өнгөрсөн оны мөн үеэс 17.2 сая ам. доллараар нэмэгдэв. 2005 онд 71.1 сая ам. долларын алдагдалтай байсан бусад үйлчилгээний тэнцэл 2006 онд 41.6 сая ам. долларын алдагдалтай гарч сайжирсан байна.

Тайлант онд цэвэр урсгал шилжүүлэг 215.1 сая ам. долларын ашигтай гарсан нь Монгол улсын Засгийн газар урьдчилсан байдлаар нийт 111.8 сая ам. доллартай тэнцэх техник туслалцааны хөрөнгийг ашигласан болон Монгол иргэдийн гүйвуулгын орлого 153.6 сая ам. доллар болсонтой шууд холбоотой байна. Өнгөрсөн онтой харьцуулахад урсгал шилжүүлгийн хэмжээ 4.5 хувиар буурчээ.

**Зураг 5.5 Урсгал данс болон үйлчилгээний тэнцэл**



**Зураг 5.6 Гадаад худалдааны тэнцэл**



\*Төлбөрийн тэнцлийн шинэчилсэн аргачлалын дагуу импортийн үнийн дүнг С.И.Ф нөхцлөөс Ф.О.Б нөхцөлд шилжүүлэхдээ коэффициентийг 11.0 хувиар тооцов.

\*Экспортын үнийн дүн дээр татваргүй барааны орлого нэмэгдсэн болно.

## 5.4 Хөрөнгө ба Санхүүгийн данс

Хөрөнгө ба санхүүгийн данс 19,6 сая ам. долларын ашигтай гарсан хэдий ч өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.2 дахин буурчээ. Тайлант онд ДНБ-ий 6.9 хувьтай тэнцэхүйц хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн ба энэ нь өнгөрсөн оны гадаадын шууд хөрөнгө оруулалтаас 2.1 хувиар өссөн байна. Мөн бусад хөрөнгө оруулалтын тэнцэл 166,6 сая ам. долларын алдагдалтай гарлаа.

Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын агентлагийн мэдээгээр 2006 онд гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай болон хамтарсан хөрөнгө оруулалттай нийт 1505 аж ахуйн нэгж 366.5 сая ам. долларын гадаадын хөрөнгө оруулалт хийхээр бүртгэгдсэн байна. Үүнээс хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ, Канад, АНУ, Вьетнам, БНСУ, ОХУ, Их Британи, Швейцари, Вержини аралууд (Их Британи), Япон, Кейман арал, Бельги, ХБНГУ зэрэг улс нийт хөрөнгө оруулалтын 98.8 хувийг эзэлж байна.

Хөрөнгө оруулалтыг тухайн салбарт эзлэх хувиар нь авч үзвэл геологи, уул уурхайн салбар нийт хөрөнгө оруулалтын 53.3 хувь, худалдаа, нийтийн хоолны салбар 28.2 хувь, банк, санхүүгийн салбар 3.3 хувийг тус тус эзэлж байна.


Тайлант онд Засгийн газрын шугамаар олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас нийт 88.2 сая ам. долларын урт болон дунд хугацаат зээл авснаас Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон Хятадын засгийн газраас авсан зээл нийт зээлийн 84.2 хувийг эзэлж байна. Монгол улсын Засгийн газар 2006 оны эцсийн байдлаар 31.1 сая ам. долларын үндсэн өрийг төлж, 14.6 сая ам. долларын хүүний төлбөрийг оролцуулаад нийт 45.7 сая ам. долларын гадаад зээлийн үндсэн өр, хүүг барагдуулсан байна. Өнгөрсөн онд Монгол улс ДНБ-ий 8.5 хувьтай тэнцэхүйц хөрөнгийг гадаадын өрийн үйлчилгээнд зарцуулсан бол тайлант онд энэ үзүүлэлт 1.7 хувь болон буурсан байна. Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2006 оны эцсийн байдлаар 1414 сая ам. долларт хүрчээ.

### Хүснэгт 5.4 Төлбөрийн тэнцлийн хураангуй хүснэгт


(сая ам. доллараар)

	2006				
	I улирал	II улирал	III улирал	IV улирал	Жилээр*
I. Үргсгал Тэнцэл (A+B+B)	70.4	52	127.9	56	306.3
A. Бараа ба үйлчилгээний худалдаа(a+b)	2.7	21.6	90.9	62.9	178.1
a. Бараа (1-2)	16.9	30.6	56.7	84.3	188.5
1. Экспорт Ф.О.Б.	230.4	382.4	469.2	463.3	1545.2
1.1. Зэсийн баяжмал	103.6	151.4	196.3	184.2	635.4
1.2. Мөнгөжөөгүй алт	35.5	54.2	91.3	89	270.1
1.3. Бусад	91.3	176.8	181.5	190.2	639.7
2. Импорт Ф.О.Б	-213.5	-351.7	-412.5	-379	-1356.7
1. Тээвэр /цэвэр/	2.8	2.5	-7.1	-11.6	-13.5
2. Аялал /цэвэр/	-1.5	4.7	47.4	2.5	53.2
Үүнээс: Жуулчлал / цэвэр/	-4	0	44.2	-0.2	40
3. Харилцаа холбооны үйлчилгээ /цэвэр/	0.2	0.8	5.3	2	8.3
4. Барилгын ажил /цэвэр/	-0.1	-0.4	-0.3	-0.3	-1.1
5. Даатгалын үйлчилгээ /цэвэр/	-2.2	-4.1	-4.9	-4.5	-15.7
6. Бусад үйлчилгээ /цэвэр/	-13.4	-12.5	-6.2	-9.5	-41.6
a. Ажиллагсдын цалин хөлс /цэвэр/	0.2	0	0.9	0.4	1.6

**Зураг 5.7 Нийт экспортонд алтны эзлэх хувь**



**Зураг 5.8 Нийт экспорт болон зэсийн баяжмалын экспорт**



**Хүснэгт 5.4 Төлбөрийн тэнцлийн хураангуй хүснэгт (үргэлжлэл)**  
*(сая ам. доллараар)*


	2006				
	I quarter	II quarter	III quarter	IV quarter	Annual*
b. Хөрөнгө оруулалтын орлого /цэвэр/	-2.7	-32.2	-0.6	-53	-88.4
B. Ургал шилжүүлэг (а+б+в)	70.2	62.5	36.7	45.7	215.1
а. Засгийн газрын шилжүүлэг /цэвэр/	28.1	28	27.8	27.9	111.8
б. Ажилчдын гүйвуулга	33.9	25.5	4.6	13	77.1
1. Хүлээн авсан	42.8	42.1	32.6	36.2	153.6
2. Шилжүүлсэн	8.9	16.5	28	23.2	76.6
в. Бусад шилжүүлэг /цэвэр/	8.1	9	4.3	4.7	26.2
<b>II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл (А+Б)</b>	<b>15.5</b>	<b>-80.6</b>	<b>55.9</b>	<b>28.7</b>	<b>19.6</b>
A. Хөрөнгийн данс	0	0	0	0	0
B. Санхүүгийн данс (а+б+в)	15.5	-80.6	55.9	28.7	19.6
а. Шууд хөрөнгө оруулалт /цэвэр/	24	73.2	88.3	0.6	186.1
б. Санхүүгийн хөрөнгө оруулалт	0	0	0	0	0
1. Актив	0	0	0	0	0
2. Пассив	0	0	0	0	0
в. Бусад хөрөнгө оруулалт	-8.5	-153.8	-32.4	28.1	-166.6
1. Худалдааны зээл /цэвэр/	-16.3	25.9	10.1	8.7	28.4
2. Зээл /цэвэр/	2.2	-2.5	6.2	43.5	49.4
2.1 Үрт хугацааны зээл	1.4	2.1	7.5	41.1	52
2.1.1 Актив	0	0	0	0	0
2.1.1.1 Засгийн газар	0	0	0	0	0
2.1.1.2 Бусад сектор	0	0	0	0	0
2.1.2 Пассив	1.4	2.1	7.5	41.1	52
2.1.2.1 Ашиглалт	5.4	13	14.7	55.1	88.2
2.1.2.1.1 Засгийн газар	5.4	13	14.7	55.1	88.2
2.1.2.1.2 Бусад сектор	0	0	0	0	0
2.1.2.2 Үндсэн өрийн төлбөр	4	11	7.3	14	36.3
2.1.2.2.1 Засгийн газар	2	6.9	2.9	13.4	25.2
2.1.2.2.2 Бусад сектор	2.1	4.1	4.3	0.6	11.1
2.2 Богино хугацааны зээл	0.9	-4.6	-1.2	2.4	-2.5
2.2.1 Актив	2.5	-5.3	-0.6	2.4	-1
2.2.2 Пассив	-1.7	0.7	-0.6	0	-1.5
2.2.2.1 Ашиглалт	2.2	7.3	8.1	4	21.7
2.2.2.2 Үндсэн өрийн төлбөр	3.9	6.6	8.7	4	23.2
3. Бэлэн мөнгө ба харилцах /цэвэр/	5.6	-177.1	-48.8	-24.1	-244.4
4. Бусад цэвэр актив	0	0	0	0	0
<b>III. Залруулга</b>	<b>-33.8</b>	<b>62.8</b>	<b>-22.3</b>	<b>91.6</b>	<b>98.3</b>
<b>IV. Нийт Төлбөрийн Тэнцэл (I+II+III)</b>	<b>52.1</b>	<b>34.2</b>	<b>161.5</b>	<b>176.4</b>	<b>424.2</b>
<b>V. Цэвэр нөөцийн өөрчлөлт (А+Б-В)</b>	<b>-52.1</b>	<b>-34.2</b>	<b>-161.5</b>	<b>-176.4</b>	<b>-424.2</b>
A. Мөнгөжсөн алтны өөрчлөлт	36.8	148.8	-11.8	-2.4	171.4
Б. Бусад цэвэр активийн өөрчлөлт	12.9	-114.7	174.7	179.2	252.1
В. ОУВС-гийн зээлийн өөрчлөлт	-2.4	-0.1	1.5	0.4	-0.6

\* Үрьдчилсан


**Зураг 5.9 Экспорт, импортын хэмжээ, импортыг экспортоор нөхөх коэффициент**




**Зураг 5.10 Санхүүгийн данс**



Зураг 5.11 Гадаадын хөрөнгө оруулалт (улсаар)



Зураг 5.12 Гадаадын хөрөнгө оруулалт (салбараар)



# ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 6.1 Удирдлага, зохион байгуулалт

Тайлант онд ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх, санал бодлоо чөлөөтэй, ил тод илэрхийлэх, чөлөөт итгэлцлийн зарчим дээр тулгуурласан, шагнал урамшуулал, нийгмийн асуудлыг хангах механизмыг хүний нөөцийн бодлогодоо тусган ажиллалаа.

Төв банк нь удирдлага, 6 газар, 1 бие даасан алба, 10 хэлтэс, 9 алба, 1 тусгай тасаг, 1 төлбөр тооцооны төв, орон нутаг дахь 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц, зохион байгуулалтаар үйл ажиллагаага явуулж тэдгээрт нийт 304 албан хаагч ажиллаж байна.

Монголбанкны төв аппаратад 212 ажилтан ажиллаж байгаагаас эмэгтэй 100, эрэгтэй 112, орон нутаг дахь салбарт нийт 92 ажилтан, эдгээрээс эмэгтэй 50, эрэгтэй 42 ажилтан ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, санхүү банкны салбарын тогтвортой байдлыг хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн ажилтнуудыг дайчлан ажиллуулах боломжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тэдгээрийн боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд хүргэх, сурч боловсрох эрхээ чөлөөтэй эдлэх боломж олгохын тулд Дэлхийн банк, ОУВС, бусад олон улсын байгууллагаас зохион байгуулж буй тэтгэлэгт сургалт, семинаруудад байнга оролцуулж, түүний үр дүнд оюуны хөрөнгө оруулалт, мэдлэг боловсролыг чанаржуулж тэдгээрээс нийлүүлэх бүтээгдэхүүний гарцыг байнга нэмэгдүүлж ирлээ. Тухайлбал, 2006 онд гадаад, дотоодод 60 гаруй ажилтан давхардсан тоогоор 77 сургууль, курс семинарт хамрагджээ.

Тайлант онд тус банкинд магистрын зэргийг Япон, Америк, Австрали улсуудад 12 ажилтан хамгаалснаар байгууллагын хэмжээгээр нийт 2 доктор, 67 магистрын зэрэгтэй ажилтнууд ажиллаж байна. 2006-2007 онд докторын сургалтад 4 ажилтан, магистрын сургалтад ОУВС болон гадаад орнуудын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн шугамаар 15 ажилтан суралцаж байна.

Нийт ажиллагдын 75.0 орчим хувь нь нарийн мэргэжлийн инженер, эдийн засагч мэргэжлийн боловсон хүчин байгаа бол үйлчилгээний албан тушаалтнуудын 38 орчим хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.

Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд тэдгээрийн ажиллаж амьдрах тав тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор ихээхэн анхаарал тавьж ажиллалаа. Тухайлбал бүх ажиллагдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан, 8 ажилтны орон сууцны болон сууц хувьчлалын асуудыг шийдвэрлэн, Монголбанкны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж олгох тухай журмын дагуу ахмадуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн зэрэг арга хэмжээг зохион байгуулав.

## 6.2 Бэлэн мөнгөний хангалт

Монголбанкнаас тайлант онд мөнгөн тэмдэгттэй холбоотой дараахь үйл ажиллагааг явуулав. Үүнд:

- Гүйлгээний эрэлт хэрэгцээ, шаардлага болон дэвсгэртийн зохистой бүтцийг судалж үзсэний үндсэн дээр 20000 төгрөгийн цаасан дэвсгэртийг чанар, нууцлалын өндөр төвшинд гүйцэтгэж 2006 оны 10 дугаар сараас шинээр гүйлгээнд гаргав.
- Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан шинээр 20000-тын дурсгалын цаасан дэвсгэрт болон 1925-1994 оны гүйлгээний зоосыг цуглуулга болгон гаргав.
- Аймаг, орон нутгийн салбар банкуудаар дамжуулан бэлэн мөнгөөр хангах, муудсан мөнгөн тэмдэгтийг татаж устгах, давтан тоолох, хянах үйл ажиллагааг тогтмол явуулж ирлээ.
- Тайлант онд Монголбанк 5000-т, 10000-т, 20000-тын дэвсгэртийн нууцлалыг таних тэмдэг бүхий зурагт хуудас хийлгэн арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод, валют солих цэгүүд, болон томоохон худалдааны төвүүдээр тараав.
- 2006 онд 34.1 тэрбум төгрөгийн 30.6 сая ширхэг муу дэвсгэртийг устгав. Тайлант оны эцсийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 245.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- Монголбанк 2006 онд Монгол улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтийн дунд явуулсан санал асуулгадаа мөнгөн тэмдэгттэй холбоотой асуултууд оруулсан нь иргэдийн мөнгөн тэмдэгтийн талаарх санаа бодол, эрэлт хэрэгцээг судлахад ач холбогдолтой байв.

## 6.3 Гадаад хамтын ажиллагаа

Монгол улсын зээлжих зэрэглэлийг ахиулан бататгах талаар Монголбанк 2006 онд идэвхтэй ажиллалаа. Дэлхийд нэр хүндтэй зэрэглэл тогтоогч байгууллагууд болох Фич, Мүүдийз болон Стандарт энд Пүэрс компаниудтай хамтран ажилласны үр дүнд улсын зээлжих зэрэглэлийг Стандарт энд Пүэрс “Б+ Эрэг Б+” болон ахиулан тогтоосон бол удаахь хоёр компани өмнө тогтоосон зэрэглэлээ бататгалаа.

Өнгөрсөн онд гарсан өөр нэг үйл явдал бол Мүүдийз компани Монгол улсын төгрөгийн бондод “Ba1”, төгрөгийн хадгаламжид “Ba2” буюу хөрөнгө оруулалтын түвшний зэрэглэлийн дээд хязгаар тогтоосон явдал юм. Урьд өмнө тогтоож байгаагүй энэхүү хязгаар нь хамгийн эрсдэл багатай төгрөгийн үнэт цаас болон хадгаламжид оноож болох зэрэглэлийг харуулдаг бөгөөд хөрөнгө оруулалтын түвшинд хүрснээр гадаадын хөрөнгө оруулалтыг улам их татах боломж бүрдүүлсэн юм.

Улсын зээлжих зэрэглэлийг ахиулан бататгах ажлыг Монголбанк гардан хийснээр нэг үе буурах төлөвтэй байсан зэрэглэл тогтоогч байгууллагуудын сонирхлыг сэргээлээ. Түүнчлэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад зэрэглэл тогтоолгосноор гадаад зах зээлд гарах үүд хаалгыг нээж өгдөг гэдгийг ойлгууллаа. Үүний үр дүнд үндэсний томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд зэрэглэлээ тогтоолгон, гадаад зах зээлээс санхүүгийн хямд эх үүсвэр татах ажлыг эхлүүлээд байна.

Их Монгол улс байгууллагдсаны 800 жилийн ойн хүрээнд Монгол улсын эдийн засаг, банк санхүүгийн салбарыг гадаадад сурталчлах, гадаадын хөрөнгө оруулалтыг татаар Монголбанк багагүй ажил хийллээ. Гадаадын нэр хүндтэй “Fortune”, “Forbes”, “Newsweek”, “Businessweek”, “Foreign Affairs”, “CNBC”, “International Herald Tribune” зэрэг сонин хэвлэлд нийтлэл, сурталчилгааны материал хэвлүүллээ.

Ойн хүрээнд “Euromoney Conferences” болон Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын агентлагтай хамтран “Хөрөнгө оруулагчдын форум-2006”-г Улаанбаатар хотод 9 дүгээр сард амжилттай зохион байгууллаа. Уг форумд гадаад, дотоодын нийт 800 гаруй зочин, төлөөлөгчид оролцсон нь урьд өмнө зохиогдж байсан уулзалт, хуралдаанаас оролцогчдын тоо, хамрах цар хүрээний хувьд илүү өргөн хүрээнд болж өнгөрлөө.

### *Лондон дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа*

2006 оны 2 дугаар сард “Монгол улс болон Олон улсын санхүүгийн төв” хуралдааныг Лондон хотын Ситигийн амбан захирагч Дэвид Брюверийн Монгол улсад хийсэн айлчлалын үеэр зохион байгуулав. Уулзалтад Монголбанкны Ерөнхийлөгч, арилжааны банкуудын төлөөлөгчид болон албаны бусад хүмүүс, Лондон хотын Ситигийн амбан захирагч Дэвид Брювер, түүнийг дагалдан явваа бизнесийн төлөөлөгчид оролцов. Уулзалтад оролцогчид Монгол улсын эдийн засаг, санхүүгийн салбарын нөөц боломж, түүнийг олон улсын санхүүгийн төв болгон хөгжүүлэхэд дэлхийн санхүүгийн тэргүүлэх төв Лондон хоттой хамтран ажиллах талаар онцлон ярилцсан байна. Хоёр хөршийн эдийн засгийн хурдацтай хөгжил, газар зүйн ашигтай байршил зэрэг нь Монгол улсыг бүсийн санхүүгийн төв болгон хөгжүүлэх таатай боломж, ирээдүй байгааг уулзалтад оролцогчид тэмдэглээд, энэ зорилтыг хэрэгжүүлэхэд санхүү хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашигийг хамгаалах нөхцлийг сайжруулах, мөн банкны салбараас гадна даатгал, хөрөнгийн зах зээлийг улам хөгжүүлэх, энэ талаар цаашид хамтран ажиллах талаар санал солилцож, энэ чиглэлээр Лондон хотын зүгээс тусламж дэмжлэг үзүүлэх, Монголын компаниудын хувьцааг Лондонгийн хөрөнгийн бирж дээр арилжаалах боломжийг судлахаар тохиролцлоо. Лондон хотод үйл ажиллагаа явуулдаг олон улсын нэр хүнд бүхий 10 гаруй банк санхүүгийн байгууллагын төлөөлөгчид энэ уулзaltaар Монголын банк санхүүгийн салбарын удирдлагуудтай уулzan бизнесийн холбоо тогтоон ажиллаж эхэллээ.

Мөн 9 дүгээр сард “Монголын банк санхүүгийн салбар болон Европын Сэргээн Босголт хөгжлийн банк (ЕСБХБ)” сэдвээр дугуй ширээний уулзалтыг тус банкны Ерөнхийлөгч Жан Лемьерийн Монгол улсад хийсэн айлчлалын үеэр зохион байгуулж, банк санхүүгийн салбарт хэрхэн хамтран ажиллах талаар ярилцлаа. ЕСБХБанкны мэргжилтнүүдийг Монголын банкуудтай уулзуулах ажлыг зохион

байгуулав. Тус банк нь Улаанбаатарт төлөөлөгчийн газраа нээж, ХАС банкинд 5 сая еврогийн зээл олгосноор жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулсан анхны төсөл хэрэгжих эхэллээ. Монгол улстай ажиллах стратегийн бичиг баримтын төсөлд банк, санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхтэй холбогдуулан өгсөн саналууд тусгалаа олж, уг бичиг баримт нь батлагдан мөрдөгдөж эхлээд байна. Уг баримт бичгийн дагуу ЕСБХБ нь банк санхүүгийн салбарын шууд хөренгө оруулалт хийх, урт хугацааны зээл олгох, зөвлөх мэргэжилтэн ажиллуулах, сургалт хийх зэргээр техникийн туслалцаа үзүүлнэ.

ЕСБХБ-наас төгрөгөөр бондыг Монгол улсад гаргуулах боломжийг судлах, хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох, даатгалын эрх зүйн шинэчлэлийг хийх, тэтгэврийн тогтолцоог шинэчлэхэд техник туслалцаа, сургалт авахаар тохиролцож 2007 онос хэрэгжүүлж эхэлнэ. 2004 онд эхэлсэн банкны салбарын ажилтнуудыг сургах 450.0 мянган еврогийн төсөл 2006 онд амжилттай хэрэгжиж дууслаа. Сургалтад банкны 300 гаруй ажилтан хамрагдлаа.

Монголын банк санхүүгийн салбарын үйл ажиллагааг цаашид олон улсын түвшинд хүргэн хөгжүүлэхэд хийх ажлын талаар бие даасан зөвлөмж дүгнэлтийг олон улсад нэр хүнд бүхий мэргэжилтнүүдээр гаргуулах ажлыг зохион байгуулж, тэдний томилолт үйлчилгээний 50.0 мянган еврогийн зардлыг ЕСБХБ-наас гаргуулав. Энэхүү зөвлөмжийг Монгол улсын санхүүгийн дунд хугацааны хөтөлбөр боловсруулахад хэрэглэснээс гадна инфляцид суурилсан урт хугацааны үнэт цаасыг төрөөс гаргуулах замаар инфляцийн гэнэтийн хүлээлтийг тодорхой болгоход тусалж, улмаар хүүг бууруулах боломжтой талаархи зөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлыг холбогдох газруудад тавиад байна.

Тайлант онд Английн Төв банкинд мөнгөний бодлогод эдийн засгийн загварчлалыг ашиглах, санхүүгийн салбарын системийн эрсдэл, хяналт шалгалтын зохицуулалтын шинэ загварууд, банкны үйл ажиллагааны эрсдэлийг удирдах нь сэдвээр Монголбанкны ажилтнуудыг сургав. Монгол улсад картын болон бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монголбанкны 10 ажилтанг Англи, Герман, Исланд, Белгийн төв банкууд болон Visa, Master зэрэг олон улсын төлбөр тооцооны байгууллагуудтай уулзуулан сургалт зохион байгуулав. Германы Төв банктай хамтран бэлэн бус тооцоо, картын гүйлгээг зохион байгуулах асуудлаар 2006 онд хамтран ажилласан бол 2007 онд бэлэн мөнгөний хангарт, үйлчилгээнд судалгаа хийх, Төв банкинд эрсдэлийн удирдлагын системийг нэвтрүүлэх, дотоод хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллана. Энэ нь төлбөр тооцоонд дахь бэлэн мөнгөний хэрэгцээг багасган, оронд нь бэлэн бус төлбөр тооцооны шинэ хэрэгслүүдийг өргөн нэвтрүүлэх хөтөлбөрийн бэлтгэл ажил болох юм.

Монголбанк, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны хамтран гаргасан санамж бичгийн дагуу шинээр байгуулагдсан СЗХ-г олон улсын байгууллага, ижил төстэй гадаадын байгууллагуудтай холбоо тогтоолгон ажиллахад анхаарал тавин ажиллав. Үүний үр дүнд даатгалын эрх зүйн баримт бичгүүдийг олон улсын жишигт хүргэн сайжруулж боловсронгуй болгох, даатгалын ажилтнууд, хялан шалгагчдыг сургах, мэргшүүлэхэд зориулан 300.0 мянган еврогийн техникийн туслалцаа авах төслийг батлууллаа. Төсөл хэрэгжсэнээр даатгалын үйл ажиллагаа өргөжин, улмаар даатгалтай хөрөнгийг барьцаалан зээл олгох таатай орчин бүрдэж, банкны зээлийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой. Банкны сул чөлөөтэй хөрөнгийг үнэт цаасны зах зээлд оруулах таатай нөхцлийг бүрдүүлэх,

үнэт цаасны үйл ажиллагаа эрхэлдэг мэргэшсэн ажилтнуудыг бэлтгэх сургалтын төв байгуулахад Дэлхийн банкны дэргэдэх First Initiative байгуулагаар дамжуулан 1 сая ам. долларын техникийн туслалцаа бүхий төсөл хэрэгжүүлэх саналыг тавьж хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтанд оруулав. Хадгаламж зээлийн хошооны Английн туршлагаас судалж, мэдээллийг СЗХ-ны хадгаламж зээлийн хоршооны хяналт шалгالت, зохицуулалтын талаархи эрх зүйн шиэнэчлэлтийн ажлын хэсгийн хэрэгцээнд зориулан хүргүүллээ.

Люксембургийн ЗГ-ын 100 хувийн тэтгэлэлгээр 2005 онд зургаа, 2006 онд дөрвөн оюутанг банкны магистрert сургах хөрөнгийг шийдвэрлүүлэн таван оюутан суралцаж, үүнээс гурав нь Люксембургийн их сургуулийн санхүүгийн сургуулийг 2006 онд дүүргээд Монголбанк, Худалдаа хөгжлийн банкуудад ажиллаж байна. Эдгээр оюутнуудын сургалт, стипенд, даатгал, байр, Нью-Йоркод хийх дадлагын 125.0 мянган еврогийн зардлыг Люксембургээс санхүүжүүлээд байна. 2007 онд хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын банк, даатгалын сургалтуудыг Монголд зохион байгуулах замаар 200 гаруй ажилтанг сургах, Люксембургэд болох банкны удирдлагын сургалтад 6 ажилтанг, магистрert 2-3 оюутан сургах хөтөлбөрийг шийдвэрлүүллээ.

Гадаадад ажиллаж амьдрагсдын ар гэртээ шилжүүлж буй мөнгөн гүйвуулгын талаар Лондон хотноо зохиогдсон олон улсын хуралд Монгол улсыг төлөөлөн оролцож, хурлын материалыг холбогдох саналын хамт Монголбанкны ажлын хэрэгцээнд хүргүүлснээс гадна Солонгос, Герман, АНУ, Англи дахь монголчуудаас Монгол руу шилжүүлж буй мөнгөн гүйвуулгын судалгааг Дэлхийн банкны тусламжтайгаар хийлгүүлэх ажлыг тохиролцлоо. Энэ нь мөнгөн гүйвуулгын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

Монгол улсын валютын нөөцийг үр ашигтай зохистой байршуулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, нөөцийн удирдлагыг сайжруулж боловсронгуй болгохтой холбогдсон мэдээ мэдээлэл цуглуулах, санхүүгийн шинэ хэрэгслийдийн судалгаа хийх, зэрэглэл сайтай банкууд, тэдгээрийн ажил үйлчилгээний чанар, үнийн судалгаа хийх зэргээр Монголбанкны ажилтнуудыг мэдээ мэдээллээр хангах, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжилтнүүдийг Монголд уулзуулах зэрэг ажлууд нь валютын нөөц, Монголбанкны ашиг орлого өсөн нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Банкны байгууллагаас гадна Сангийн Яам, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам, Хөрөнгийн Бирж, Нийгмийн даатгалын Ерөнхий газруудыг ижил төстэй байгууллагуудтай холбоо тогтоон хамтран ажиллахад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүллээ. Монгол улсын эдийн засаг, банк санхүүгийн салбар, хувьчлалын талаар гадаадын байгууллагуудад танилцуулах сурталчлах, мэдээлэх ажлыг байнга гүйцэтгэж байна.

## 6.4 Дотоод аудит

Монголбанкны Дотоод аудитын газраас Дотоод аудитын 2002-2006 оны хөтөлбөр, 2006 оны ажлын төлөвлөгөөний дагуу Монголбанкны газар, хэлтэс, орон нутаг дахь салбар нэгжүүдэд Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж, шалгалт хийн, учирч болзошгүй аливаа эрсдэл, алдагдлаас хамгаалах, бий болсон эрсдэлийг бууруулах, арилгах, илэрсэн зөрчил дутагдлын мөрөөр холбогдох арга хэмжээ авах талаар шийдвэр гаргуулах, санал, зөвлөмж болон үүрэг даалгавар өгөх зэргээр ажиллалаа.

Тайланд онд Монголбанкны Төв орон нутгийн газар, хэлтэс, алба, салбар нэгжид бүрэн болон хэсэгчилсэн байдлаар нийт 59 удаа шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг цаг тухайд нь аван, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ирлээ. Шалгалтыг эрсдэл ихтэй, эрсдэл бий болзошгүй талбарт чиглүүлэн явуулав.

Мөн Дотоод аудитын үйл ажиллагааг улирал тутам нэгтгэн дүгнэж, Захирлуудын Зөвлөлийн гишүүд болон Монголбанкны Хяналтын Зөвлөлд тайлагнаж, шалгалтын үр дүнгээр холбогдох арга хэмжээ авч ажилласан болно.

Тайлант онд Монголбанкны 2005 оны санхүүгийн тайланг “КПМЖ” компаниар баталгаажуулах ажлыг зохион байгуулж, Монголбанкинд өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж, мөрөөр нь холбогдох арга хэмжээ авч ажиллалаа.

## 6.5. Нягтан бодох бүртгэл


Монголбанкны nyaгтан бодох бүртгэлийг Олон улсын стандартад нийцүүлэн, бүртгэлийн сахилга бат, төлбөрийн шуурхай байдлыг хангахад анхааран ажиллаж байна. Тайлант онд хөндлөнгийн аудитын КПМЖ компанийн зөвлөмжийн дагуу санхүүгийн тайландаа зарим тохицуулгын гүйлгээг хийж гүйцэтгэлээ.

### *Банк хоорондын төлбөр тооцоо*


Манай улсын эдийн засаг өргөжин тэлэхийн хэрээр банк хоорондын тооцоогоор дамжин хийгдэх гүйлгээ нэмэгдсээр байна. Банк хоорондын тооцоонд оролцож буй нийт төлбөрийн дүн болон ДНБ-ий харьцаа 2001 онд 1.7 байсан бол 2006 онд 3.0 болж өсчээ. Энэ нь иргэд, байгууллагын банкинд итгэх итгэл улам сайжирч, банкаар хийгдэх гүйлгээ эрс нэмэгдэж буйг илтгэж байна.

Банк хоорондын гүйлгээ 2, 4 дүгээр улирлууд хамгийн их хийгддэг бөгөөд энэ нь оны төгсгөлд оны эцсийн гүйлгээнүүд хийгддэг болон 2 дугаар улиралд цаг агаар дулаарч барилга болон уул уурхайн салбарууд идэвхжиж иргэд, албан байгууллагуудын банкуудаар дамжуулан гүйлгээ нэмэгддэгтэй холбоотой юм. Харин хамгийн бага гүйлгээг I улиралд хийж байгаа нь оны эхэн дэх гүйлгээнүүд харьцангуй бага, төсвийн санхүүжилт дөнгөж хийгдэж эхэлдэгтэй холбоотой байж болох юм.

Зураг 6.1 Банк хоорондын төлбөр тооцоо, ДНБ



Зураг 6.2 Банк хоорондын гүйлгээний тоо, сараар



## Хүснэгт 6.1 Банк хоорондын гүйлгээний тоо, улирлаар

(мянган ширхээр)

	2002	2003	2004	2005	2006
1 улирал	222.2	406.4	586.3	620.2	689.7
өсөлт (%)	22.9	82.9	44.3	5.8	11.2
2 улирал	287.1	611.7	793.5	797.5	851.5
өсөлт (%)	25.6	113.1	29.7	0.5	6.8
3 улирал	295.6	561.9	617.3	541.6	762.8
өсөлт (%)	56.9	90.1	9.9	-12.3	40.8
4 улирал	405.9	636.8	727.1	391	910.6
өсөлт (%)	68.3	56.9	14.2	-46.2	132.9
Бүгд	1210.8	2216.8	2724.2	2350.3	3214.6
өсөлт (%)	44.3	83.1	22.9	-13.7	36.8


Сараар авч үзвэл, 1, 2, 7, 11 дүгээр саруудад гүйлгээний тоо болон гүйлгээний дун буурч байгаа бол бусад саруудад өссөн байна. Гүйлгээ буурч байгаа саруудын ажлын хоног бусад саруудаас бага байсантай холбоотой байв.

Банк хоорондын төлбөр тооцоонд оролцогчдын төлбөрийн системийг шинэчлэх, сайжруулах зорилгоор 2006 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Төлбөр тооцооны төвийг ашиглалтанд оруулав. Банк хоорондын их дүнтэй гүйлгээ болон банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дүнгийн хязгаарыг нэг сая төгрөгөөр тогтоосон бөгөөд 2006 онд банк хооронд нийт 3.2 сая удаагийн гүйлгээгээр 9.5 их наяд төгрөгийн гүйлгээ хийгджээ. Үүний 350.1 тэрбум төгрөг буюу 3.7 хувь нь бага дүнтэй гүйлгээ, 9.2 их наяд төгрөг буюу 96.3 хувь нь банк хоорондын их дүнтэй гүйлгээ байв. Харин гүйлгээний тоогоороо бага дүнтэй гүйлгээ нийт гүйлгээний тооны дийлэнх буюу 84.9 хувийг эзэлж байна.


Тайлант онд дунджаар нэг гүйлгээний дун 2.5-3.5 сая төгрөгийн хооронд хэлбэлзэлзэж байлаа.

Банк хоорондын гүйлгээний дүнгийн 24.6 хувийг Төрийн сан, 14.6 хувийг Худалдаа хөгжлийн банк, 13.5 хувийг ХААН банк, 11.5 хувийг Голомт банк, 7.3 хувийг Улаанбаатар хотын банк, 6.4 хувийг Хадгаламжийн банк, 5.0 хувийг Монгол Шуудан банк, 4.3 хувийг Анод банк, 12.7 хувийг бусад банк тус тус эзэлж байна. Үүнийг өмнөх онтой харьцуулж үзвэл, Худалдаа хөгжлийн банкных 1.7 нэгж, Хадгаламж банкных 1.5 нэгж, Монгол Шуудан банкных 1.0 нэгж, бусад банкуудынх 0.3 нэгжээр тус тус буурсан байхад ХААН банкных 2.4 нэгж, Голомт банкных 1.3 нэгж, Төрийн сангийнх 0.4 нэгж, Улаанбаатар хотын банкных 0.2 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 6.3 Банк хоорондын гүйлгээний тоо, их болон бага тоогоор



Зураг 6.4 Банк хоорондын гүйлгээний дүн, сараар



## Хүснэгт 6.2 Банк хоорондын гүйлгээний дүн, улирлаар

(тэрбум төгрөг)

	2002	2003	2004	2005	2006
1 улирал	471.48	850.17	1,086.39	1,481.79	1,787.63
өсөлт (%)	13.9	80.3	27.8	36.4	20.6
2 улирал	581.98	1,000.43	1,429.33	1,809.40	2,742.82
өсөлт (%)	33.2	71.9	42.9	26.6	51.6
3 улирал	718.18	986.84	1,400.15	2,057.20	2,145.66
өсөлт (%)	45.1	37.4	41.9	46.9	4.3
4 улирал	972.34	1,249.53	1,746.27	2,222.72	2,847.43
өсөлт (%)	81.6	28.5	39.8	27.3	28.1
Бүгд	2,743.97	4,086.97	5,662.13	7,571.10	9,523.55
өсөлт (%)	45.9	48.9	38.5	33.7	25.8


## 6.6 Мэдээллийн технологийн талаар

Монголбанкны нийт газар, хэлтэс, салбарууд нь Төв банкны үндсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасан чиглэлийн дагуу үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд энэхүү нэгжүүдийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, харилцан уялдаа холбоог дээд зэргээр хангах, ажлын давхардлыг арилгах, түргэн шуурхай, найдвартай байдлыг хангах, хяналт тавих, удирдлагад тайлагнах ажлыг сайжруулах нь чухал асуудал юм. Мөн Монголбанкны ажилтнуудын үйл ажиллагааг оновчтой, үр өгөөжтэй зохион байгуулах, хөдөлмөрийн бүтээмж, ажлын цаг ашиглалтыг дээшлүүлэх, тэдгээрт тавих хяналтыг сайжруулах нь Төв банкны үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулахад чухал нөлөөтэй билээ.


Нөгөө талаас сүүлийн жилүүдэд мэдээллийн техник, технологийн хөгжил асар хурдацтай явагдаж, хүн төрөлхтний бүхий л үйл ажиллагаанд нэвтрэч, улам боловсронгуй болгоход ихээхэн түлхэц болж байна. Монголбанк нь мэдээллийн технологийн ололт амжилтыг цаг тухайд нь нэвтрүүлэн ашигласнаар ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын цагийг зүй зохистой ашиглах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг дээшлүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох зэрэг олон чухал ач холбогдолтой ба үүний үр дүнд зардал болон цаг хугацаа хэмнэж, илүү өндөр ололт, амжилтанд хүрэх боломжтой болох юм. Иймд Мэдээллийн технологийн хэлтсээс Монголбанкны бүхий л үйл ажиллагаанд мэдээллийн системийн ололт амжилтыг нэвтрүүлж, ажлын үр дүнг дээшлүүлэх олон шинэ ажлуудыг шат дараалан хийж байна.

Монголбанк нь Төв банкны үнэт цаасны арилжааны програм хангамжийн нэмэлт өөрчлөлтийг хийж, арилжааг цаасан хэлбэрээр явуулахыг бүрэн зогсоосон ба одоо бүх арилжааг онлайнаар хийдэг болгов. Мөн Мөнгөний бодлого, судалгааны газартай хамтран тус програмын талаар арилжааны банкуудад семинар зохион байгууллаа. Ирэх онд Монголбанкнаас зохион байгуулж буй бүх төрлийн арилжаа, мөн Монголбанкнаас олгох бүх санхүүжилт болон банк хоорондын зах дээр хийгддэг бүх арилжааны үйл ажиллагааг онлайнаар хийх боломжийг

Зураг 6.5 Нэг гүйлгээний дундаж гүйлгээний дүн



Зураг 6.6 Банк хоорондын гүйлгээний дүн, их болон бага дүнтэйгээр



агуулсан нэмэлт, өөрчлөлтийг ТБҮЦ-ны програм хангамжид оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн Монголбанкны гадаад, дотоод төлбөр тооцоог үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэх, банкны төлбөр тооцоонд дэвшилтэд технологи нэвтрүүлэх, банк хоорондын тооцооны эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн системд шаардлагатай нэмэлт өөрчлөлт, програм, модулиудыг хийж гүйцэтгэв.

Төв банкны хэрэгжүүлж буй бодлого, үндсэн чиг үүргийн талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, түргэн шуурхай хүргэж байх зорилгоор Монголбанкны вэб хуудсыг шинэчлэн боловсронгуй болгож, хамгийн нууцлал сайтай, аюулгүй байдлыг өндөр түвшинд хангасан, хурдан, найдвартай ажиллагаатай технологиудыг ашиглан мэдээллийг онлайн болон файл гэсэн горимоор хүлээн авах боломжтой, мөн хайлтын системтэй шинэ веб хуудсыг ашиглалтанд орууллаа.

Мөн олон улсын төлбөр тооцооны Swift сүлжээний өдөр тутмын найдвартай ажиллагааг ханган ажиллаж, dial-up холболтыг ISP\_LL холболтоор сольж, мэдээлэл дамжуулах ажиллагааг online горимд амжилттай шилжүүлэв. Swift сүлжээний нууцлалын техник, технологийг сайжруулах зорилгоор СВИФТНетийн 2-р үе шатны бэлтгэл ажлыг хийж дууссан ба энэ ажлын хүрээнд SAS програм хангамж болон бусад хэрэгслүүдийг сервер компьютерт суурилуулж, мөн Swift-ийн сургалтын төвтэй хамтран нийт арижааны банкуудын дунд сургалт зохион байгуулав.


Монголбанкны интернэтийн болон дотоод сүлжээний техник, төхөөрөмжийг шинэчлэн сайжруулж, интернэтийн хурдыг 2 МВ хүртэл нэмэгдүүлэв. Нийт ажилтнуудын сүлжээний орчин дахь нууцлалын түвшинг нэмэгдүүлэх, сүлжээний зохион байгуулалтыг сайжруулах, мөн зохистой хэрэглээг нэвтрүүлэх, найдвартай ажиллагааг хангах зорилгоор Active Directory технологийг нэвтрүүлэх туршилтийг хийж, шаардагдах бэлтгэл ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Мөн “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн сүлжээ”, “SWIFT сүлжээ”, “Банк хоорондын сүлжээ”, “Зээлийн мэдээллийн сан”-ийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж, серверүүдийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, гадны халдлагаас сэргийлэх нэмэлт арга хэмжээ авч, сүлжээний хамгаалалтыг сайжруулав.

Мэдээллийн технологийн ажилтнуудын мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллан Энэтхэг улсад болсон BankTech-2006 арга хэмжээнд хоёр ажилтан, Тайланд улсын Азийн технологийн институт болон Oracle Их сургуулийн Тайланд дахь салбарт Oracle-ийн мэргэжил дээшлүүлэх сургалтад гурван програм зохиогч, мөн тус сургуулийн Linux системийн сургалтад нэг програм зохиогчийг тус тус хамрууллаа.


### Төлбөр тооцооны төв

Тус төв нь нийт 16 банкны төв, Сангийн яамны Төрийн сангийн газар, Монголбанкны төвтэй үндсэн шугам болох шилэн кабель, нөөц шугам болох физик кабелиар холбогдон, дундын сүлжээг найдвартай ажиллуулаад

Зураг 6.7 Банкуудын гүйлгээний дүн



Зураг 6.8 Банк хоорондын гүйлгээний дүнд эзлэх хувь, банкуудаар



шаардлагатай гэрээ хэлэлцээрүүдийг холбогдох байгууллагуудтай хийж, тэдгээрт өдөр тутмын хяналт тавин ажиллаж байна.

2006 оны 2 дугаар сараас эхлэн банк хоорондын гүйлгээг санхүүгийн дундын сүлжээг ашиглан дамжуулж эхэлсэн ба энэхүү сүлжээ ашиглалтанд орсноор Монголбанк нь банкуудын төв болон Сангийн яамны Төрийн сангийн газартай бодит цагийн горимд онлайн холбоотой болж санхүүгийн аливаа үйлчилгээг тухайн мөчид түргэн шуурхай явуулах боломжтой болсон юм. Үүний зэрэгцээ банкууд санхүүгийн дундын сүлжээний тусламжтайгаар ТБҮЦ-ны арилжаа буюу мөнгөний захиын үйл ажиллагаанд оролцох, тайлан мэдээллээ солилцох зэрэг нэмэлт үйлчилгээнүүдийг авч байна.

Төлбөр тооцооны төв нь 2006 онд багтаан банкуудыг ISO 8583 стандартад шилжүүлэх зорилгоор тус стандартыг байгууллагуудад тараан холбогдох мэргэжилтнүүдэд сургалт явуулах, банкны програм хангамж нийлүүлэгч компаниудтай хамтран ажиллан ISO 8583 стандартыг сурталчлан таниулах, ISO 8583-д тохирсон програм хангамжийн туршилтыг хамтран хийх, банкуудын туршилтын явцад гарсан алдаа дутагдлыг илрүүлж зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна. Банк хоорондын гүйлгээний мэдээг Олон улсын ISO 8583 стандартын шаардлагыг хангасан нэгдсэн стандарт руу шилжүүлснээр банк хоорондын гүйлгээ дамжуулах байгууллагууд өөрсдийн бүртгэлийн программ хангамжид холбогдох өөрчлөлтийг оруулан гүйлгээгээ багцаар биш гүйлгээ тус бүрээр тухайн мөчид шууд дамжуулах боломжтой болох юм.

## 6.7 Банкны сургалтын төвийн үйл ажиллагаа

Банкны сургалтын төв (БСТ) нь 2006 онд өөрийн гол үүрэг болох сургалт семинарыг төлөвлөгөөний дагуу тогтмол явуулж ирсэн ба сургалт семинарыг чанартай, үр өгөөжтэй зохион байгуулахад гол анхаарлаа хандуулан ажиллалаа. Ингэснээр энэ онд төлөвлөгдсөн дотоод гадаад сургалт, семинар давхардсан тоогоор нийт 1102 хүн хамрагдан оролцсон байна.

БСТ нь энэ онд 32 сэдэв бүхий 44 удаагийн дотоод гадаад сургалт семинарыг зохион байгуулахаар төлөвлөснөөс тайлангийн хугацаанд 37 сэдвээр 48 удаагийн сургалт семинар зохион байгууллаа. БСТ 2006 онд өмнөө тавьсан зорилтоо амжилттай биелүүлсэн нь Монголбанк болон арилжааны банкууд, мөн зарим ББСБ-үүд, тус сургалтын төвийн үйл ажиллагааг байнга дэмжин туслалцаа үзүүлэн, сургалт семинарт өөрсдийн ажиллагсдыг идэвхтэй оролцуулж байгаатай холбоотой юм. Энэ онд БСТ-өөс сургалт семинарын үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд сургалт семинарын үргэлжлэх хугацааг сунгаж, аль болох урт хугацаагаар зохион байгуулахыг хичээн ажилласны дунд нийт 2887 хүн/өдөр сургалт семинарыг зохион байгуулсан нь өмнөх оныхоос 40 хувь буюу 848 хүн/өдөр-өөр нэмэгдсэн байна.

### Дотоодод зохион байгуулсан сургалт

БСТ нь арилжааны банкуудын ажилнуудын эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангахуйц сургалт семинарыг зохион байгуулж явуулахын тулд сүүлийн жилүүдэд тогтоод байгаа уламжлалын дагуу оны эхэнд арилжааны банкуудаас санал

авч 2006 оны сургалтын төлөвлөгөөг хамтран боловсруулж, уг төлөвлөгөөний дагуу сургалт семинарыг зохион байгуулав. Тайланийн хугацаанд банкуудын хүний нөөцийн менежерүүд болон сургалтын менежерүүдтэй хамтран ажиллаж, тэдэнтэй сургалт семинар хэрхэн зохион байгуулагдаж байгаа, сургалтын агуулга, төлөвлөгөөнд оруулах өөрчлөлтүүдийн тухай, хамтарч сургалтыг зохион байгуулах болон бусад асуудлаар тогтмол уулзан ярилцаж, зөвлөлдөн ажилласны үр дүнд сургалт семинарыг чанартай, өгөөжтэй болох гол хүчин зүйл болсноос гадна банкуудын БСТ-ийн үйл ажиллагааг дэмжин сургалтад хамрагдах идэвх урд онуудын адил сайн байв. БСТ энэ онд 36 сэдэв бүхий 47 удаагийн /2849 хүн.өдөр/ сургалт семинарыг дотооддоо зохион байгуулж, нийт 1091 хүнийг хамруулжээ. БСТ нь энэ онд сургалт семинарыг чанартай, өгөөжтэй, үр дүнтэй аль болох сонирхолтой, урт хугацаатай байхаар зохион байгуулах, үйл ажиллагааныхаа хүрээг хөдөө орон нутагт ажиллаж байгаа банкны ажилтнуудад чиглүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажилласан байна.

БСТ нь энэ онд сургалтыг системтэй явуулах зорилгоор хэд хэдэн шинэ бүтээгдэхүүн гаргаж, концепц программуудыг боловсруулан хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Зээлийн ажилтнуудад зориулсан сургалтын концепц
2. Банкны залуу ажилтны мэргэжлийн үр чадвар дээшлүүлэх сургалтын программ
3. Сургагч багшийн сургалтын программ
4. Сонгон шалгаруулалтын аргачлал АС
5. Хөтлөгчийн сургалтын хөтөлбөр.

БСТ нь энэ онд хөдөө орон нутагт ажиллаж байгаа банкны ажилтнуудад зориулсан мэргэжил дээшлүүлэх бүсчилсэн 6 өдрийн сургалтыг анх удаагаа зохион байгуулсан бөгөөд энэхүү арга хэмжээнд 15 аймгийн нийт 163 хүн оролцов. Эдгээр хүмүүсээс 148 хүн шалгалтанд тэнцэж сертификат авлаа.

Банкны ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор банк санхүүгийн англи хэлний гадаад багштай дамжаа, арилжааны банкуудад ажиллаж байгаа мэргэжлийн бус ажилтнуудад зориулж “Банкны нягтлан бodoх бүртгэлийн” 2 сарын дунд шатны дамжааг тус тус зохион байгуулж явуулсан ба дээрх 2 дамжаанд нийт 41 хүнийг хамруулсан ба хамрагдагсдаас сургалтын программыг хангаж шалгалтанд тэнцсэн 34 хүнд сертификат олгожээ.

БСТ сургалт бүр дээр сургалт семинарт оролцогсдын дунд сургалт хэрхэн явагдсан, багшид өгөх үнэлгээ, БСТ-ийн үйл ажиллагааны талаар санал асуулга байнга явуулж, гарсан санал шүүмжлэлийг цаг хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байгаа нь тус төвийн үйл ажиллагааг хэвийн явуулахад, сургалтын чанар өгөөж, үр нөлөөг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна гэж үзэж байна.

Мөн сургалт эхлэхээс 2-3 долоо хоногийн өмнө багш бүрийг сургалтыг хөтлөн явуулах бэлтгэлийг хангуулах, сургалтад оролцогсодод сургалтын материал, бусад гарын авлагыг урьдчилан бэлтгэж тарааж байна.

БСТ нь тайлангийн хугацаанд өөрийн гишүүн байгууллагуудаас ирүүлсэн 28 санал хүсэлтийг хүлээн авч цаг хугацаанд нь 100 хувь шуурхай барагдуулж

ажилласан ба зарим арилжааны банкуудын хүсэлтийн дагуу төлөвлөгөөнөөс гадуурхи сургалтуудыг зохион байгуулахын зэрэгцээ өөрийн сургалтын танхим, тоног төхөөрөмж, сургалтын программ хангамжaa үнэгүй ашиглуулах, багш олж өгөх зэргээр туслалцаа үзүүлж иржээ.

Мөн гадаад түнш байгууллагуудын туслалцаа дэмжлэгээр Англи, Герман, Люксенбург, Бельги, Франц зэрэг орнуудаас банкны мэргэжилтнүүдийг урин ирүүлж гадаад багштай 18 удаагийн сургалт семинарыг зохион байгуулсан нь арилжааны банкуудын хувьд ажилтнуудаа гадаадад сургах зардал хэмнэсэн арга хэмжээ боллоо.

### *Гадаад орнуудад зохион байгуулсан сургалт*

БСТ энэ онд гадаад орнуудын банк санхүүгийн үйл ажиллагаатай танилцуулах, туршлагаас нь суралцуулах зорилгоор ХБНГУ-ын Франкфурт, БНХАУ-ын Шанхай, ОХУ-ын Эрхүү зэрэг хотуудад сургалт аяллуудыг зохион байгуулж 24 хүнийг хамруулав. 2007 онд ХБНГУ болон бусад орнуудад банкны удирдах ажилтны сургалт-аялал, мэргэжилтнүүдэд зориулсан 5 удаагийн сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөж зохих байгууллагуудтай тохиролцоод байна.

## Бодлого уйл ажиллагааны хураангуй

### *Банкны тухай хууль тогтоомжийн хөгжил*

Тайлант онд УИХ-аас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль /2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр/ болон Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай хууль /2006 оны 6 дугаар сарын 22-ны өдөр/- ийг тус тус батлан гаргажээ.

Мөнгө угаах, терроризмын санхүүжилттэй тэмцэх нь дэлхийн хамтын нийгэмлэгийн бодлогын тэргүүлэх асуудлын нэг болсон бөгөөд Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталснаар банк, санхүүгийн системийн эрүүл, тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал алхам болов.

Энэхүү хуулийн зорилго нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар тухайлбал, мэдээлэх үүрэгтэй этгээдийн хүлээх үүрэг, сэжигтэй болон тусгайлан хянах гүйлгээ, Санхүүгийн мэдээллийн албанд сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх, харилцагчийн талаархи мэдээллийг шалгаж тогтоох, холбогдох материалыг хадгалах, гүйлгээг түдгэлзүүлэх зэрэг харилцааг зохицуулах юм. Түүнчлэн Монголбанкны бүтцэд Санхүүгийн мэдээллийн албыг байгуулах эрх зүйн үндэс бий болгов.

Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай хуулиар санхүүгийн түрээсийн гэрээ байгуулах, дуусгавар болгох, санхүүгийн түрээс, түүний төрөл, хэлбэр, агуулга, гэрээний зүйл, гэрээнд тавигдах шаардлага, гэрээний оролцогч, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлага, гэрээг бүртгүүлэх зэрэг асуудалтай холбогдсон харилцааг зохицуулжээ.

Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай хууль батлагдсантай холбогдуулж Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “зээлдүүлэх газар” гэсний дараа “санхүүгийн түрээсийн үйлчилгээ” гэж нэмэлт оруулав.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт болон 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг болон Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтыг тус тус хүчингүй болгов.

**МОНГОЛБАНКНААС 2006 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН  
БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ХУРААНГУЙ**

Сар, өдөр	Дугаар	Нэр	Агуулга
I / 16	19	<ul style="list-style-type: none"> <li>• Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам</li> <li>• Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам</li> <li>• Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ</li> <li>• Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ</li> </ul>	Банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах зорилгоор энэхүү журмыг батлав.
III / 24	147/94	МБЕ, Сангийн сайдын хамтарсан 2004 оны 207/459 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын З дугаар бүлгийн 3.1; 5.3; 5.4 дэх заалтуудыг өөрчлөн найруулсан.	Журмыг боловсронгуй болгох зорилгоор өөрчлөлт оруулав.
V / 26	250	МБЕ-ийн 2006 оны 19 тоот тушаалаар батлагдсан “Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэх ажлын гэрээ”-ний 1.5.3 дахь хэсгийн заалтыг өөрчилсөн.	Журмыг боловсронгуй болгох зорилгоор өөрчлөлт оруулав.
VI / 19	286	Төв банкны үнэт цаасны цахим арилжааны ерөнхий гэрээ	Төв банкны үнэт цаасыг Монголбанкнаас банкинд худалдах, банкнаас Монголбанк буцаан худалдан авах, банк хоорондоо худалдах, худалдан авах, тэдгээр үйл ажиллагаанд Банк хоорондын арилжааны цахим системийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор энэхүү гэрээг батлав.
X / 11	452/81 /483	Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам	Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар энэхүү журмыг батлав.
XI / 17	537	Үйл ажиллагааны эрсдэл тооцох зөвлөмж	Банк, санхүүгийн байгууллагаас үйл ажиллагааны эрсдэлээ тооцоход тус дөхөм болох зорилгоор энэхүү журмыг боловсруулав.
XII / 21	594	Банкны зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх журам	Банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг банкны хувь нийлүүлэгчийн эрх ашигт нийцүүлэх болон банкны зохистой удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор энэхүү журмыг батлав.



## ҮДИТОРЫН ТАЙЛАН

### Захирлуудын Зөвлөлийн хүлээх үүрэг

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын Зөвлөлийн хүлээх үүрэг байна.

Монголбанкны санхүүгийн тайланг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Захирлуудын Зөвлөл нь 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны үйл ажиллагаа, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг энэхүү санхүүгийн тайланд үнэн зөвөөр илэрхийлэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын Зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх нягтлан бодох бүртгэлийг зөв зохистой хөтөлж явуулдаг бөгөөд санхүүгийн тайлан нь Тодруулга 3 ба Тодруулга 4-т тусгагдсан шаардлагуудад нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил, дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байдаг.

3-34 дугаар хуудсанд үзүүлсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ зохих бодлогыг баримталж, үндэслэлтэй бөгөөд зохистой шийдэл, тооцооллыг ашиглаж, бүхий л холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг дагаж мөрдсөн гэж Захирлуудын Зөвлөл үзэж байна.

Захирлуудын Зөвлөлийн шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:



А. Батсүх  
Ерөнхийлөгч, Монголбанк

Улаанбаатар, Монгол улс  
2007 оны 5 дугаар сарын 29



**KPMG (Firm No.AF 0758)**  
Chartered Accountants  
Wisma KPMG  
Jalan Dungun, Damansara Heights  
50490 Kuala Lumpur, Malaysia



**Tentsver Orgil Audit LLC**  
Suite 402, 4th Floor, Khatan Sulkh Building  
Zaluuchuudlin Urgun Chuluu  
Sukhbaatar District 8th subdistrict  
Ulaanbaatar city, Mongolia  
Phone/Fax: 976-11-324496

## Аудиторын дүгнэлт

### Монголбанкны гишүүдэд

Бид Монголбанкны санхүүгийн тайланда аудит хийж 3-34 дүгээр хуудсанд үзүүллээ. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэх нь Банкны Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Бидний үүрэг бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлтээ гаргаж, та бүхэнд тайллагнах явдал юм. Энэхүү тайлангийн талаар өөр бусад этгээдийн өмнө бид хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартууд нь санхүүгийн тайлангууд материалын хэмжээний алдаагүй эсэхийг нотлох хангалттай нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөн гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын явцад санхүүгийн тайланда тусгагдсан дүн мэдээ, тодотголын дагалдах нотолгоог түүврийн аргаар шалгах ажил ордог. Мөн түүнчлэн аудитын явцад санхүүгийн тайлангуудын ерөнхий танилцуулгад үнэлэлт өгөх, захирлуудын хийсэн томоохон тооцоолол, ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх зэрэг ажил багтдаг. Бидний гүйцэтгэсэн аудитын үр дүн нь дүгнэлт гаргахад хангалттай үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Бидний дүгнэлтээр, 3-34 дугаар хуудсанд үзүүлсэн санхүүгийн тайлангууд нь бүхий л материалын зүйлсийн хувьд 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Монголбанкны үйл ажиллагаа, тухай өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг нь Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв үзүүлсэн байна.

Бид аудитын дүгнэлтдээ хязгаарлалт хийлгүйгээр, санхүүгийн тайлангийн Тодотгол 16-д үзүүлсэнчлэн Банк нь Төв Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийг мөрдөөгүй болохыг онцлон тэмдэглэж байна.

*KPMG*

КПМЖ  
Мэргэшсэн нягтлан бодогчид  
Компанийн дугаар: AF 0758

Улаанбаатар, Монгол Улс



2007 оны 5 дугаар сарын 29

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Орлого, үр дүнгийн тайлан

	Тодотгол	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Хүүгийн орлого	<b>5</b>	18,779	8,505
Хүүгийн зардал	<b>6</b>	(8,072)	(7,342)
<b>Цэвэр хүүгийн орлого</b>		10,707	1,163
Алтны цэвэр ашиг		2,309	18,773
Гадаад валютын арилжааны цэвэр алдагдал		(7,487)	(3,175)
Үйл ажиллагааны бусад орлого		1,204	648
<b>Хүүгийн бус орлого/(зардал)</b>		(3,974)	16,246
<b>Нийт орлого</b>		6,733	17,409
Захиргааны зардал		(4,667)	(4,805)
Бусад үйл ажиллагааны зардал	<b>8</b>	(5,199)	(3,964)
<b>Тайлант жилийн ашиг/(алдагдал)</b>		(3,133)	8,640

7-34 дугаар хуудсанда үзүүлсэн тодотголууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Тайлан тэнцэл

	Тодотгол	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
<b>АКТИВ</b>			
Бэлэн мөнгө	9	20,792	12,116
Алт, үнэт металл	10	167,870	9,893
Гадаад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	11	56,972	28,616
Бушаан худалдан авсан гэрээ	12	115,967	59,707
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	13	616,588	403,400
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	14	18,373	17,615
Санхүү Эдийн Засгийн Яаманд олгосон урьдчилгаа	15	35,822	137,275
Аж ахуйн нэгжүүдэд олгосон урьдчилгаа	16	6,156	10,472
Бусад актив	17	24,503	7,685
Үндсэн хөрөнгө	18	18,276	17,563
<b>НИЙТ АКТИВ</b>		<b>1,081,319</b>	<b>704,342</b>
<b>ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		245,099	191,686
Гаргасан үнэт цаас	19	70,845	125,713
Гадаад өр төлбөр	20	150,633	158,876
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	21	405,129	90,298
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	22	148,542	89,548
Бусад пассив	23	27,955	11,109
<b>НИЙТ ПАССИВ</b>		<b>1,048,203</b>	<b>667,230</b>
<b>ДҮРМΙЙН САН БА НӨӨЦ</b>			
Дүрмийн сан	24	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг/алдагдал		4,561	(350)
Бусад нөөц	25	23,555	32,462
<b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>33,116</b>	<b>37,112</b>
<b>НИЙТ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>1,081,319</b>	<b>704,342</b>

7-34 дугаар хуудсанд үзүүлсэн тодотголууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Мөнгөн гүйлгээний тайлан

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Тухайн жилийн ашиг/(алдагдал)	(3,133)	8,640
Тохиргуулга:-		
Үндсэн хөрөнгийн данснаас хасалт	17	175
Үндсэн хөрөнгийн данснаас хасалтын алдагдал	-	37
Элэгдэл	877	805
<b>Ажлын капитальын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг</b>	(2,239)	9,657
<i>Активын (өсөлт)/бууралт:-</i>		
Алт, үнэт металл	(157,977)	12,690
Гадаад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	(28,423)	(16,510)
Буцаан худалдан авсан гэрээ	(56,260)	(10,501)
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	(213,188)	(150,897)
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	(758)	4,588
СЭЗЯ-нд олгосон урьдчилгаа	101,453	21,457
Аж ахуйн нэгжүүдэд олгосон урьдчилгаа	4,316	(4,581)
Бусад актив	(16,818)	2,502
<i>Пассивын өсөлт/(бууралт):-</i>		
Гүйлгээнд гаргасан мөнгө	53,413	23,165
Гаргасан үнэт цаас	(54,868)	56,466
Гадаад валютаарх пассив	(8,243)	(7,632)
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	314,831	37,272
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	58,994	23,164
Бусад пассив	16,050	(198)
<b>Үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>10,283</b>	<b>642</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7	3
Үндсэн хөрөнгө худалдан авалт	(1,614)	(780)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(1,607)</b>	<b>(777)</b>
<b>Мөнгөн хөрөнгийн цэвэр бууралт</b>	<b>8,676</b>	<b>(135)</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>12,116</b>	<b>12,251</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>20,792</b>	<b>12,116</b>

## МОНГОЛБАНК

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Аудиторын тайлан

		Хувьцаслагдахгүй		Хувьцаслагдах	
		Дурмийн Сан сая төгрөг	Ерөнхий Нөөцийн Сан сая төгрөг	Дахин Үнэшүүний Сан сая төгрөг	(Хуримтлагдсан алдаагал) / Хуримтлагдсан ашиг сая төгрөг
Нийт сая төгрөг					
<b>2005.01.01-ний өдрийн байдлаар</b>					
- Өмнөх нь тайлзгаснаар	5,000	5,000		24,266	(5,475)
- Өнөөгөөн эсилийн заплуулга	-	-		-	(386)
<b>2005.01.01-ний өдрийн байдлаар (шинэчилсэн)</b>	<b>5,000</b>	<b>5,000</b>		<b>24,266</b>	<b>(5,861)</b>
Тухайн жилийн ашиг (шинэчилсэн)	-	-		-	8,640
Худалдан авах боломжтой Үнэт цаасны дахин Үнэлгээнээс үүсэх болит бус цэвэр ашиг	-	-		67	-
Дахин Үнэлгээний санд жилжүүлсэн болит бус ashiig	-	-		(3,016)	3,016
Ерөнхий нөөцийн санд шилжүүлсэн	-	6,145		-	(6,145)
<b>2005.12.31-ний өдрийн байдлаар (шинэчилсэн)</b>	<b>5,000</b>	<b>11,145</b>		<b>21,317</b>	<b>(350)</b>
<b>2005.12.31-ний өдрийн байдлаар</b>	<b>5,000</b>	<b>11,145</b>		<b>21,317</b>	<b>6</b>
- Өмнөх нь тайлзгаснаар	-	-		-	(356)
- Өнөөгөөн эсилийн заплуулга	-	-		-	-
<b>2005.12.31-ний өдрийн байдлаар (шинэчилсэн)</b>	<b>5,000</b>	<b>11,145</b>		<b>21,317</b>	<b>(350)</b>
Тухайн жилийн алдагдал	-	-		-	(3,133)
Худалдах боломжтой Үнэт цаасны дахин Үнэлгээнээс үүсэх болит бус цэвэр ашиг	-	-		(67)	-
ashiigийн өөрчлөлт	-	-		(8,840)	8,840
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн	-	-		(796)	(796)
Дахин Үнэлгээний неөцийн санд шилжүүлсэн болит бус цэвэр алдагдал	-	-		-	-
<b>2006.12.31-ний өдрийн байдлаар</b>	<b>5,000</b>	<b>11,145</b>		<b>12,410</b>	<b>4,561</b>
<b>Тодотогл 25</b>					<b>33,116</b>

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол

#### 1. Банкны талаархи ерөнхий мэдээлэл

Монголбанк, Монгол Улсын Төв Банк (цаашид “Банк” гэнэ) нь Монгол Улсын Засгийн Газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор байгуулагдсан ба байршил нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага Тойруу 9.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол улсад явуулдаг бөгөөд Англи улсын Лондон хот дахь төлөөлөгчийн газраас өөр хилийн чанадад үйл ажиллагаа явуулдаг салбаргүй болно.

Банкны 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг Захирлуудын Зөвлөлийн 2007 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн шийдвэрээр зөвшөөрсөн болно.

#### 2. Үндсэн үүрэг

Банкны хүлээх үндсэн үүргийг Төв банк (Монголбанк)-ны тухай хуулиар зохицуулна.

Банк нь үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мөнгөний бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд үнэт цаас арилжих, санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татан авах зэргээр хүүгийн түвшинг зохицуулж, банкны төлбөрийн чадварыг сайжруулах замаар банкны системд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч ирсэн байна.

Банк нь Монгол улсын нэрийн өмнөөс төгрөг, гадаад валютын хоорондын харилцааг зохицуулдаг. Иймээс Банк нь улсын алт болон гадаад валютын нөөцийг эзэмшиж, удирддаг. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Банк нь бусад орны төв болон арилжааны банкуудад гадаад валютын хадгаламж байршуулж, гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэт цаас, своп болон форвардын зах зээл дээр арилжаа хийдэг.

Банк нь Монгол улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрх эдэлнэ.

#### 3. Тайланг гаргахад баримталсан ерөнхий зарчим

##### (а). Нийцэлтийн талаарх мэдэгдэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу (“СТОУС”) бэлтгэгдсэн.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 3. Тайланг гарахад баримталсан ерөнхий зарчим (үргэлжлэл)

##### (б). Хэмжилтийн үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг зах зээлийн өртгөөр нь тусгадаг үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон борлуулахад бэлэн буй санхүүгийн хөрөнгүүдийг эс тооцвол түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн.

##### (в). Үндсэн болон тайлан гарахад хэрэглэсэн валют

Санхүүгийн тайланд ашигласан мөнгөн тэмдэгт нь Монгол төгрөг бөгөөд түүнийг сая төгрөгөөр илэрхийлэв. Монгол төгрөг нь Монголбанкны үндсэн мөнгөн тэмдэгт болно.

##### (г). Тооцоолол, саналыг тусгах

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад хөрөнгө, өр телбөр, орлого, зарлыг илэрхийлж буй дүн ба нягтлан бодох бүртгэлийн хэрэгжүүлж байгаа бодлогод удирдлагын зүгээс нөлөөлж болох санал зөвлөмж, үнэлэлт дүгнэлт, таамаглалыг хийж байх шаардлагатай байдаг байна. Бодит үр дүн эдгээр тооцоо, аргачлалаас өөр байж болно.

Үнэлгээ болон таамаглалыг одоо мөрдөж буй зарчим дээр хянаж үздэг. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ямар нэг өөрчлөлтийг тухайн өөрчлөлт гарсан ёе болон тухайн өөрчлөлтөөс хамаарах ирээдүйн тооцоололд хамруулан тайлагнана.

#### 4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Банк нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг туштай баримталдаг бөгөөд эдгээр бодлого нь өмнөх жилүүдийнхээс өөрчлөгдөөгүй байна.

##### (а) Гадаад валютын гүйлгээ

Түүхэн өртгөөр бүртгэгдэж гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөжсөн актив, пассивыг тайлан тэнцэлд тухайн өдрийн ханшаар хөрвүүлж төгрөгөөр илэрхийлнэ. Банк нь гадаад валютаар илэрхийлэгдсэн актив, пассивыг өдөр бүр дахин үнэлдэг. Ханшийн тэгшитгэлийн зөрүүг Орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч улмаар дахин үнэлгээний санд шилжүүлдэг.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

##### (а) Гадаад валютын гүйлгээ (үргэлжлэл)

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус актив, пассив нь өртгөөрөө болон дахин үнэлсэн мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн болно. Тухайн актив, пассив болон актив пассивыг дахин үнэлснийг тухайн үеийн ханшаар бүртгэнэ.

Гадаад валютын гүйлгээг тухайн өдрийн ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцсон болно. Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зөрүүг Орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч улмаар дахин үнэлгээний санд шилжүүлдэг.

##### (б) Алт, үнэт метал

Алтыг бодит үнэлгээгээр нь тайлан тэнцэлд тусгадаг бөгөөд дахин үнэлгээг өдөр бүр хийдэг. Дахин үнэлгээг тогтоохдоо мөнгөжсөн алтны зах зээлийн үнэ, түүний хандлага, төгрөгийн худалдан авах чадвар, төгрөгийн ханшийн өсөлт, бууралт зэргийг харгалздаг. Дахин үнэлгээний ашиг, алдагдлыг Орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч улмаар дахин үнэлгээний санд шилжүүлдэг.

Цэвэршүүлээгүй алт, мөнгө, зоос болон түүх соёлын үнэт зүйлсийг өртөг, зах зээлийн үнийн аль багаар нь бүртгэдэг.

##### (в) Санхүүгийн хэрэгслүүд

###### *(i) Ангилал*

Арилжааны хэрэгсэл нь богино хугацаанд ашиг олох зорилгоор Банкны эзэмшиж буй хэрэгсэл юм. Эдгээрт эрсдлээс үр дүнтэй хамгаалах зориулалтгүй санхүүгийн үүсмэл хэлцэл ордог. Авлагад (эерэг бодит үнэлгээ) бүртгэгдсэн бүх үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон худалдан авсан опшин нь арилжааны активт орно. Өглөгт (сөрөг бодит үнэлгээ) бүртгэгдсэн бүх үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон опшин нь арилжааны пассивт орно.

Богино хугацаанд арилжаалах зорилгоор бий болсон зээлээс бусад замаар үссэн зээл болон авлага нь Банкны бий болгосон зээл болон авлага бөгөөд зээлдэгчид олгож буй мөнгөн хөрөнгө юм. Олгосон зээл, авлагад бонд худалдан авснаас бусад зээл, урьдчилгаа орно.

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### **4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)**

#### **(в) Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)**

##### *(i) Ангилал(үргэлжлэл)*

Дуусгавар өдөр хүртэл эзэмших хөрөнгөд төлбөр нь тогтмол буюу тооцоологдох, дуусгавар хугацаа нь тодорхой санхүүгийн хэрэгслүүд орох бөгөөд эдгээрийг Банк дуусгавар хугацаа хүртэл эзэмших зорилготой бөгөөд боломжтой байна.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгөд арилжааны зориулалтаар эзэмшиж буй, Банкнаас олгосон, дуусгавар өдөр хүртэл эзэмших санхүүгийн хэрэгслүүд орохгүй. Үүнд зарим зээлийн хөрөнгө оруулалт орно.

##### *(ii) Анхны өртгийн хүлээн зөвшөөрөлт*

Банк худалдан авсан, үүссэн санхүүгийн хэрэгслийг анхны үнээр нь бүртгэх ба эдгээр нь бодит өртөгтэй нь тэнцүү байна.

Хэрэв ямар нэгэн арилжаа, гүйлгээ нь зах зээлийн үнэд тулгуурлаагүй эсвэл зах зээлийн үнийг нь шууд тодорхойлох боломжгүй бол ирээдүйд гарах төлбөр, орох орлогын ойролцоо тооцооллыг ижил төстэй санхүүгийн хэрэгслийн зах зээлийн хүүгийн өнөөгийн үнэ цэнийг үндэс болгож бодит өртгийг ойролцоогоор тогтоодог. Санхүүгийн хэрэгслийн бодит өртөг болон зах зээлийн үнийн зөрүүг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын холбогдох заалтын дагуу хөрөнгө, өр төлбөр хэмээн тодорхойлогдох боломжгүй л бол шууд орлогын тайландаа хүлээн зөвшөөрдөг.

##### *(iii) Дараахь үеийн хэмжилт*

Анх бүртгэнээс хойш, бүхий л арилжааны хэрэгслүүд, борлуулахад бэлэн хөрөнгийг бодит үнэлгээгээр нь бүртгэнэ. Харин идэвхтэй зах зээлд зах зээлийн үнэлгээ байхгүй хэрэгсэл, бодит зах зээлийн үнэлгээг оновчтой хийж болохгүй тохиолдолд тухайн санхүүгийн хэрэгслийг үнийн бууралтыг хасч өртгөөр нь бүртгэнэ. Арилжааны хэрэгсэл болон борлуулахад бэлэн активын бодит үнэлгээний өөрчлөлтөөс үүссэн ашиг алдагдлыг орлогын тайлан болон өөрийн хөрөнгөд тус тус бүртгэнэ.

Арилжааны бус санхүүгийн хэрэгслүүд, олгосон зээл, авлага, дуусгавар өдөр хүртэл эзэмших хөрөнгийг үнийн бууралтын алдагдлыг хасаж элэгдсэн өртгөөр нь бүртгэнэ. Элэгдсэн өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцно. Урамшуулал ба хямдруулалт, анхны гүйлгээний зардал нь холбогдох санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн дунд орох бөгөөд түүнийг тухайн хэрэгслийн үр ашигт хүүгийн аргаар элэгдүүлнэ.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 4. Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

##### (в) Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

###### *(iv) Бодит үнэлгээний хэмжилтийн зарчим*

Санхүүгийн хэрэгслийн бодит үнэлгээ нь тухайн балансын өдрийн зах зээлийн үнэлгээнд үндэслэгдэнэ. Хэрэв зах зээлийн үнэлгээ байхгүй тохиолдолд санхүүгийн хэрэгслийн бодит үнэлгээг тооцоходо үнэлгээний загвар буюу хямдруулсан мөнгөн гүйлгээний аргачлалыг ашиглана.

Хямдруулсан мөнгөн гүйлгээний аргачлалыг ашиглах үед ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоходо удирдлагын тооцоололд үндэслэх бөгөөд ижил төстэй нөхцөл бүхий санхүүгийн хэрэгслийн балансын өдрөөрх зах зээлийн ханшийг ашиглан хямдруулалтын хувийг тооцно. Үнэлгээний загварыг ашиглах үед балансын өдрөөрх зах зээлийн мэдээлэлд үндэслэн өгөгдлийг оруулна.

Харилцан солилцдоггүй үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэлгээ нь Банкны балансын хаалтын өдрөөр тухайн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг зах зээлийн нөхцөл байдал ба худалдан авагчийн төлбөрийн чадварыг харгалзан дуусгавар болгоно гэж таамагласан үнээр тооцоологдоно.

###### *(v) Дараа үеийн хэмжилтийн ашиг, алдагдал*

Борлуулахад бэлэн хөрөнгийн бодит үнэлгээний өөрчлөлтөөс үүссэн ашиг, алдагдлыг шууд өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хэрэгслийг худалдсан, цуглувалсан буюу данснаас хассан үед өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрсөн ашиг, алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд шилжүүлнэ.

Арилжааны хэрэгслийн бодит үнэлгээний өөрчлөлтөөс үүссэн ашиг, алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

###### *(vi) Онцгой хэрэгслүүд*

###### *Хөрөнгө оруулалт*

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших зорилготой бөгөөд боломжтой зээлийн хөрөнгө оруулалт нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө гэж ангилагдана. Бусад хөрөнгө оруулалт нь борлуулахад бэлэн хөрөнгө гэж ангилагдана.

###### *Зээл, урьдчилгаа*

Банкны олгосон зээл, урьдчилгаа нь олгосон зээл, авлага гэж ангилагдана.

Зээл, урьдчилгааг тооцоолсон буцаан төлөгдөх дүнгээр тусгах үүднээс сангаар цэвэршүүлэн тайлагнана. (нягтлан бodoх бүртгэлийн бодлого 4(i)-ийг үзнэ үү).

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

##### (в) Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

###### *Арилжааны бус санхүүгийн өр, төлбөр*

Арилжааны бус санхүүгийн өр, төлбөрт гаргасан үнэт цаас, Засгийн газрын байгууллагын хадгаламж, дотоодын санхүүгийн байгууллагын хадгаламж, гадаад өр, төлбөр болон бусад өглөг орно. Арилжааны бус санхүүгийн өр, төлбөрийг анх өртгөөр нь бүртгэнэ. Анх бүртгэснээс хойш түүний буцаан төлөгдөх дүн болон өртгийн зөрүүгээр тухайн хэрэгслийн хугацааны туршид үр ашигт хүүгийн аргаар элэгдүүлж, орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

##### (г) Харилцан суутгал

Банк нь хүлээн зөвшөөрөгдсөн дүнг харилцан суутгах хуулийн хүчин төгөлдөр эрхтэй бөгөөд төлбөр тооцоог харилцан суутгаж зөрүүгээр хийх тохиолдолд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэршүүлэн, цэвэр дунг балансад тайлагнана.

##### (д) Буцаан худалдан авах гэрээ

Банк нь ижил төстэй хөрөнгө оруулалтыг ирээдүйн тодорхой өдөр, тодорхой үнээр буцаан худалдах, худалдан авах зорилгоор хөрөнгө оруулалтыг худалдан авах, худалдах гэрээг байгуулдаг. Ирээдүйд буцаан худалдах зорилготой худалдан авсан хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрөхгүй. Төлөгдсөн дүнг авлагадаг хүлээн зөвшөөрч холбогдох үнэт цаасаар барьцаалагдана. Буцаан худалдан авах гэрээний дагуу худалдсан хөрөнгийг тэнцэлд хүлээн зөвшөөрч, Банкны холбогдох нягтлан бодох бүртгэлийн дагуу бүртгэнэ. Тухайн хөрөнгийн борлуултаас орсон орлогыг тэнцэлд өр төлбөр болгон тайлагнана.

Худалдах ба буцаан худалдан авах үнийн зөрүүг гэрээний хугацаанд хуримтлуулан хүүнд тооцно.

##### (е) Үндсэн хөрөнгө

###### *(i) Өртөг*

Үндсэн хөрөнгийг өртгөөр нь буюу хуримтлагдсан элэгдэл (дор дурьдсан) болон үнийн бууралтын алдагдлыг (бүртгэлийн бодлогын ё-д дурьдсан) хасаж дахин үнэлсэн дүнгээр бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, импортын албан татвар, эргэн төлөгдөх нөхцөлгүй худалдан авалтын татвар болон хөрөнгийг товлосон газарт нь зориулалтаар нь ашиглалтанд оруулахад гарах шууд зардлуудаас бүрдэнэ. Үндсэн хөрөнгийг ашиглалтанд орсноос хойш гарах урсгал болон их засварын зардлуудыг гарсан хугацааных нь орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

##### (e) Үндсэн хөрөнгө

###### (i) Өртөг (үргэлжлэл)

Гарсан зардал нь үндсэн хөрөнгийн стандарт гүйцэтгэлийг нэмэгдүүлж, үндсэн хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд орж ирэх эдийн засгийн үр ашгийг өсгөж байгаа тохиолдолд эдгээр зардлыг үндсэн хөрөнгийн нэмэгдэл өртөг болгон капиталжуулж болно.

2002 онд Монголбанк нь барилга байшингаа дахин үнэлүүлж, дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүнг дахин үнэлгээний нөөцөд тусгасан байна. Дахин үнэлгээг мэргэжлийн үнэлгээний байгууллагын хийсэн үнэлгээнд үндэслэсэн.

###### (ii) Элэгдэл

Хөрөнгийн элэгдлийг ашиглах хугацаанд үндэслэн шулуун шугамын аргаар тооцож орлогын тайланд бүртгэж дараах хувь хэмжээгээр тооцно. Үүнд:

	2006 он	2005 он
Байшин, барилга	25 - 60 жил	17 - 42 жил
Тавилга, тоног төхөөрөмж	8 - 10 жил	8 - 10 жил
Компьютер	5 - 8 жил	5 - 8 жил
Тээврийн хэрэгсэл	6 - 8 жил	6 - 8 жил

Дуусаагүй капитал ажилд элэгдэл тооцдоггүй. Эдгээр активын элэгдлийг холбогдох активууд ашиглалтанд орсон үеэс тооцож эхэлдэг.

Байшин барилгын тооцооллыг 2006 онд өөрчилсөн болно (18 дугаар тодотголоос хар).

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулахдаа, бүртгэлийн үнэ болон борлуулалтын үнийн зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч, тухайн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүгийн ашиглагдаагүй хэсгийг хуритлагдсан ашиг руу шууд хаадаг.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

##### (ё) Үнийн бууралт

Банк нь хөрөнгийн үнийн аливаа бууралт үүссэн эсэхийг балансын өдөр хянаж үздэг. Хэрвээ үнийн бууралт үүссэн бол тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнг тооцоолдог.

###### (i) Олгосон зээл, урьдчилгаа

Зээл, урьдчилгааг зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлын сангаар цэвэршүүлж тайлagnадаг. Алдагдлын сан нь эргэн төлөгдөх магадлал багатай, эрсдэлтэй зээл, урьдчилгаанд хамааралтай. Энэ нь тухайн зээл, урьдчилгааны эргэн төлөгдөх дүн хүртэл түүний бүртгэлийн дүнг бууруулахад шаардлагатай дүн юм.

Алдагдлын сангийн өсөлтийг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Зээл эргэн төлөгдөхгүй нь тодорхой болсон үед тухайн зээлийг данснаас шууд хасдаг.

Хэрэв дараа нь үнийн бууралтын алдагдал нь буурсан бөгөөд энэ бууралт нь хасалт хийсний дараах үйл явдалтай холбогдолтой бол, тухайн хасалт буюу алдагдлын санг орлого, үр дүнгийн тайлангаас буцаана.

###### (ii) Зээл урьдчилгаанаас бусад хөрөнгө

Нөхөн төлөгдөх дүн нь тухайн хөрөнгийн ашиглалтын өртөг болон борлуулалтын цэвэр өртгийн аль өндөр нь байна. Хөрөнгийн бүртгэлийн үнэ нь нөхөн төлөгдөх дүнгээс их бол үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрдөг. Үнийн бууралтын алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хэрэв нөхөн төлөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт гарсан тохиолдолд үнийн бууралтын алдагдлыг буцаадаг. Хөрөнгийн бүртгэлийн үнэ нь элэгдлийг хасаж тооцсон бүртгэлийн үнээс их бөгөөд, хэрэв үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрөгүй бол үнийн бууралтын алдагдлыг буцаадаг. Бүх үнийн бууралтын алдагдлын буцаалтыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

##### (ж) Орлого

###### (i) Хүүгийн орлого ба зардал

Үр ашигт хүүгийн аргачлал болон хөвөгч хүүг ашиглаж хүүгийн орлого ба зардлыг аккруал сууринд үндэслэж орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хүүгийн орлого ба зардал нь хүү авчирдаг санхүүгийн хэрэгслийн анхны бүртгэлийн үнэ болон хугацаа дусгавар болох үеийн мөнгөн дүнгийн зөрүү, урамшуулалт зэргийг агуулсан байна.

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### 4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

#### (ж) Орлого (үргэлжлэл)

##### *(ii) Түрээсийн орлого*

Үндсэн хөрөнгийн түрээсийн орлогыг түрээслүүлж буй хугацаанд шулуун шугамын аргачлалд үндэслэн орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн урамшуулал нь нийт түрээсийн орлогын салшгүй хэсэг болно.

##### *(iii) Хураамж шитгэлийн орлого*

Хураамж шитгэлийн орлогыг уг орлогыг олсон хугацааных нь орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

#### (з) Орлогын татвар

Банк нь Монгол улсын Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу орлогын татвараас чөлөөлөгднө.

#### (и) Ажиллагсдын нөхөн олговор

Ажилтнуудын нөхөн олговорт Улсын Нийгмийн Даатгалын газарт төлдөг нийгмийн даатгалын шимтгэл ордог. Нөхөн олговрыг олгосон тухай бүр орлого, үр дүнгийн тайланд зардаар хүлээн зөвшөөрдөг.

#### (к) Хэрэгжүүлж эхлээгүй байгаа шинэ стандартууд ба тайлбарууд

Шинээр гарсан хэд хэдэн Олон улсын санхүүгийн тайлгагналын стандартууд (ОУСТС), ОУСТС-ын нэмэлт өөрчлөлтийд, холбогдох тайлбарууд нь (Олон улсын санхүүгийн тайлгагналын стандартын хороо ОУСТСХ) 2006 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд ашиглагдаж эхлээгүй бөгөөд энэхүү санхүүгийн тайланг бэлтгэхэд мөн ашилагдаагүй байна.

- ОУСТС 7 Санхүүгийн хэрэгслүүд: Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) 1-д оруулсан нэмэлт өөрчлөлт болон тодруулга, Санхүүгийн тайлангийн танилцуулга: Хөрөнгийн тодруулга нь санхүүгийн позици болон гүйцэтгэлд зохицсон санхүүгийн хэрэгслүүдийн ач холбогдол, эрсдлийн тоон болон чанаарын үзүүлэлт, бодит байдалд ихээхэн тодруулга хийхийг шаарддаг. ОУСТС болон НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Банкны 2007 оны санхүүгийн тайланд Банкны санхүүгийн хэрэгслүүд болон хувь нийлүүлсэн хөрөнгийн талаар илүү тодорхой нэмэлт тодруулгыг заавал оруулах шаардлагатай болсон.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 4. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

##### (к) Хэрэгжүүлж эхлээгүй байгаа шинэ стандартууд ба тайлбарууд (үргэлжлэл)

- ОУСТСХ 7 Өндөр хэмжээний инфляци бүхий эдийн засагтай үеийн санхүүгийн тайлан гаргах тухай НББОУС 29-ийн дагуу хэрвээ эдийн засгийн орчин анх удаа өндөр ифляцитай болсон, ялангуяа хойшлогдсон татварын нягтлан бодох бүртгэлийн тохиолдолд НББОУС 29-ийг ашиглана. Банкны 2007 оны санхүүгийн тайланд заавал тусгагдах ёстой ОУСТСХ 7 нь энэ санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.
- ОУСТСХ 8 Хуваарилалтанд үндэслэсэн төлбөрийн тухай ОУСТС 2-ийн хүрээнд: Хуваарилалтанд үндэслэсэн төлбөрийн гүйлгээ нь зарим, эсвэл бүх бараа таваар, үйлчилгээг нэг бүрчлэн тодорхойлох боломжгүй нөхцөлд хэрэглэгддэг юм. ОУСТСХ 8 нь Банкны 2007 оны санхүүгийн тайланд заавал тусгагдах ёстой стандарт бөгөөд энэ санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.
- ОУСТСХ 9 Шингээгдсэн деривативыг дахин үнэлэх: Энэ нь гол гэрээ хэлэлцээс шингээгдсэн деривативыг тусгаарласан нөхцөлд зөвхөн тухайн гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд дахин үнэлэхийг шаарддаг. ОУСТСХ 9 нь Банкны 2007 оны санхүүгийн тайланд заавал тусгагдах ёстой стандарт бөгөөд энэ санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.
- ОУСТСХ 10 Үрьдчилсан санхүүгийн тайлан ба догоилдол: Гүүдвил, үндсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалт мөн зардлаар гарсан санхүүгийн активын тухайд өнгөрсөн хугацаанд ямар нэгэн хохирол, алдагдал илэрсэн тохиолдолд түүнийг өөрчлөхийг хориглосон заалт юм. Банкны 2007 оны санхүүгийн тайланд ОУСТСХ 10 нь заавал тусгагдах ёстой стандарт бөгөөд НББОУС 36 ба НББОУС 39-ийг тус тус хэрэгжүүлж эхэлсэн өдөр (2004 оны 1 сарын 1)-өөс гүүдвил, хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн активыг зардлаар бэлдсэн үед уг стандартыг баримтлан бүртгэх шаардлагатай. ОУСТСХ 10 нь энэ санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.
- ОУСТСХ 11 Бүлгийн болон төрийн сангийн хувьцааны гүйлгээ нь хувьцаанд тулгуурласан төлбөрийн гүйцэтгэлийг бий болгоход аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгийн хэрэгслүүдийг сонгох, шаарлагатай бол худалдан авах зэргээр аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгийн хэрэгслүүдтэй холбоотой хувьцаанд тулгуурласан төлбөр; Толгой компани өөрийн хөрөнгийн хэрэгслүүдийн эрхийг охин компаниудын ажилчин албан хаагчидад; охин компани нь толгой компанийхаа хөрөнгийн хэрэгслүүдийн эрхийг өөрийн албан хаагчиддаа олгох гэх зэрэг тохиолдлуудад ОУСТС 2 -г хэрэгжүүлэхэд зааварчлагаагаар хангана. 2008 оны Банкны санхүүгийн тайланд зайлшгүй хэрэглэгдэх ёстой ОУСТСХ 11 нь энэ санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.
- ОУСТСХ 12 Үйлчилгээний концессийн зохицуулалт нь санхүүгийн хөрөнгийг хүлээн авдаг болон биет бус хөрөнгийг хүлээн авдаг гэсэн үйлчилгээний концессийн зохицуулалтын хоёр хэлбэрийн хоорондох бүртгэлийн ялгааг тодруулж өгдөг. 2008 оны Банкны санхүүгийн тайланд зайлшгүй хэрэглэгдэх ёстой ОУСТСХ 11 нь энэ санхүүгийн тайланд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 5. Хүүгийн орлого

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	115	643
Буцаан худалдан авах гэрээ	2,522	1,290
Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, хадгаламж	14,876	5,029
Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа	468	548
СЭЗЯ-нд олгосн урьдчилгаа	591	995
Засгийн газрын үнэт цаас	207	-
	18,779	8,505

#### 6. Хүүгийн зардал

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Гаргасан үнэт цаас	4,359	5,957
Гадаад өр төлбөр	217	674
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	2,948	514
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	548	197
	8,072	7,342

#### 7. Ажиллагсдын мэдээлэл

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Цалин, ажиллагсдын нөхөн олговор	970	888
Захирлуудын цалин, нөхөн олговор	43	33
Нийгмийн даатгалын шимтгэл	267	219

#### 8. Үйл ажиллагааны бусад зардал

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Мөнгөн тэмдэгтийн зардал	5,080	3,849
Алт хадгалуулах зардал	15	-
Бусад	104	115
	5,199	3,964

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### 9. Бэлэн мөнгө

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Төгрөг	40	48
Гадаад валют	20,752	12,068
	<hr/> 20,792	<hr/> 12,116

### 10. Алт, үнэт металл

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Мөнгөжсөн алт	156,851	-
Мөнгөжсөн мөнгө	120	-
Мөнгөжөөгүй алт, мөнгө	8,051	7,074
Зоос, түүх соёлын үнэт зүйлс	<hr/> 2,848	<hr/> 2,819
	<hr/> 167,870	<hr/> 9,893

### 11. Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Гадаадын бонд - борлуулахад бэлэн байгаа	23,276	8,616
Засгийн газрын үнэт цаас- борлуулахад бэлэн байгаа	<hr/> 33,696	-
	<hr/> 56,972	<hr/> 28,616

### 12. Буцаан худалдан авах гэрээ

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Буцаан худалдан авах гэрээ	115,967	59,707

Банк нь ирээдүйд тодорхой нэг өдөр тогтсон үнээр буцаан худалдах нөхцөлтэй гэрээний дагуу тодорхой хөрөнгө оруулалтуудыг худалдан авсан.

Эдгээр буцаан худалдан авах гэрээнүүд нь 4 хоногийн хугацаатай (2005: 4 хоног) бөгөөд 5.27%-12% хүйтэй (2005: 3.44%) болно.

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### 13. Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Богино хугацаат хадгаламж	502,227	303,167
Зээлжих тусгай эрх	89,612	92,103
Харилцах данс	20,032	3,390
Дэлхийн банкинд оруулсан хувь, хөрөнгө	985	1,204
Бусад хувь, хөрөнгө	3,732	3,536
	616,588	403,400

#### Богино хугацаат хадгаламж

Богино хугацаат хадгаламж нь ам.доллараар илэрхийлэгдсэн ба 42 хүртэлх хоногийн хугацаатай бөгөөд жилийн 3.42%-5.3% хүйтэй (2005: 0.85%-4.35%)

#### Зээлжих тусгай эрх

Банкны эзэмшиж буй Зээлжих тусгай эрх нь Олон улсын валютын санд нийлүүлсэн хувь хөрөнгө. Энэ дүнгээр холбогдох пассив талд тусгагдсан (Тодотгол 20-ийг үзнэ үү) ба түүнд хүү тооцдоггүй.

#### Харилцах данс

Энэ үлдэгдэл нь гадаадын төв банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах дансыг илэрхийлж байгаа бөгөөд түүнд хүү тооцдоггүй.

#### Дэлхийн банкинд оруулсан хувь, хөрөнгө

Энэ үлдэгдэл нь Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон хувь хөрөнгө бөгөөд Дэлхийн банкны группын гишүүн болох нөхцлийн нэг хэсэг болдог. Энэ дүнгээр холбогдох пассив талд тусгагдсан (Тодотгол 20-ийг үзнэ үү) ба түүнд хүү тооцдоггүй.

#### Бусад хувь, хөрөнгө

Энэ нь СВИФТ болон бусад санхүүгийн байгууллагуудад оруулсан хувь, хөрөнгө юм.

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### 14. Дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл, урьдчилгаа

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Гадаад валютын зээл	10,533	9,726
Төгрөгийн зээл	7,659	7,887
Санхүүгийн байгууллагуудаас авах авлага	3,249	3,070
Дахин санхүүжилтийн зээл	130	130
Нийт зээл, урьдчилгаа	21,571	20,813
Хасах нь: Зээлийн болзошгүй алдагдлын нөөцийн сан	(3,198)	(3,198)
	<b>18,373</b>	<b>17,615</b>

#### Гадаад валютын зээл

Гадаад валютын зээлийг дотоодын арилжааны гурван банкаар дамжуулан Монголын аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Санхүүжилт нь хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд Герман Улсын Засгийн газраас жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зориулан олгосон зээл юм. (Тодруулга 20-ийг үзнэ үү) Хоёр хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй зээл нь жилийн 1.25% (2005: 1.75%)-ийн хүйтэй бөгөөд ямар нэгэн барьцаагаар баталгаажаагүй болно. Хоёр хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй зээл нь тухайн гурван банкны харилцагчдын хэрэгцээний хэрээр янз бүрийн хэмжээтэй олгогдож байна. Тиймээс, олгогдсон зээлүүдийн төлөгдөх хугацаа нь анх олгосон өдрөөс хамааран янз бүр байна.

#### Төгрөгийн зээл

Төгрөгийн зээлийг дотоодын арилжааны банкуудаар дамжуулан Монголын аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Санхүүжилт нь хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкнаас ажлын байр нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд зориулан олгогдсон зээл юм. Нэг дэх хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээл нь жилийн 10% (2005: 10%)-ийн хүйтэй бөгөөд зээлүүдийн эргэн төлөгдөх хугацаа нь анх олгосон өдрөөс хамааран янз бүр байна. Хоёр дахь хөтөлбөрийн хүрээнд олгогдож байгаа зээл нь жилийн 5.5% (2005: 5.5%)-ийн хүйтэй, олгогдсон зээл тус бүр нэг жил хүртэл хугацаатай.

#### Санхүүгийн байгууллагуудаас авах авлага

Эдгээр авлага нь төлбөрийн чадваргүй болсон дотоодын банкуудаас гаргасан хадгаламж ба баталгааны төлбөрийг Банк хариуцан төлсөнтэй холбоотой юм. Тайлант жилд олгогдсон нийт 179.0 сая төгрөгийн төлбөрөөс бусад авлагад болзошгүй алдагдлын санг бүрэн байгуулсан болно.

#### Дахин санхүүжилтийн зээл

Энэ зээл нь 1996 онд банкинд олгосон зээл бөгөөд тухайн банк татан буугдсан байна. Тухайн зээлд бүрэн хэмжээгээр болзошгүй алдагдлын сан байгуулсан болно.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 15. Санхүү Эдийн Засгийн Яаманд олгосон урьдчилгаа (СЭЗЯ)

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Засгийн газарт олгосон урьдчилгаа	-	94,373
Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн зээл	35,822	42,902
	35,822	137,275

#### Засгийн газарт олгосон урьдчилгаа

Энэхүү урьдчилгааг 2005 онд Орос Улсын Засгийн газарт төлөх хөнгөлөлттэй зээлийн төлбөрийг бүрэн барагдуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тогтоолын дагуу Банкнаас Засгийн газарт олгосон байна. Эдгээр урьдчилгааг 37 сая ам.доллар болон 117 тэрбум төгрөгөөр тус тус 2 удаа хэсэгчлэн олгосон. Зээлийн эхний хэсэг нь 2004 онд бүрэн төлөгдсөн байна. 2005 оны 3 дугаар сард үлдэх хэсэг болох 105.4 тэрбум төгрөгийг 86.95 сая ам.долларт шилжүүлсэн. Тус зээл нь жилийн 1 хувийн хүйтэй бөгөөд 9 удаа тэнцүү хэмжээгээр буюу 9.66 сая ам.долларыг жил бүр төлж, сүүлчийн төлбөрийг 2012 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хийх ёстай.

Тайлант жилд дээрх урьдчилгааны 38.89 сая ам.доллар нь бэлэн төлбөр тооцооны байдлаар эргэн төлөгдсөн бөгөөд үлдэгдэл 38.4 сая ам.долларыг нийт 44.93 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын үнэт цаасанд хөрвүүлсэн байна.

#### Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн зээл

Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөр (ЯБӨХХ, хуучин нэрээр Бүтцийн өөрчлөлтийг дэмжих хөтөлбөр)-ийн хүрээнд нийт олгосон зээлээс СЭЗЯ-ны хариуцах хэсгийг оны эцсийн байдлаар Тодотгол 20-д харуулсан болно. Зээл нь 10 жилийн хугацаатай, жилийн 0.5% (2005: 0.5%)-ийн хүйтэй.

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### 16. Аж ахуйн нэгжүүдэд олгосон урьдчилгаа

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Бусад алдагдал	6,191	10,507
Хасах нь: Унийн бууралтын алдагдал	(35)	(35)
	6,156	10,472

Бусад авлага нь олборлогч компаниудаас алт худалдан авахад зориулан урьдчилж төлсөн 3.02 тэрбум төгрөг (2005: 3.16 тэрбум төгрөг) болон Банкнаас олборлогч компаниудтай форвард, опшин хэлцэл хийснээс үүссэн 3.14 тэрбум төгрөгийн (2005: 7.30 тэрбум төгрөг) авлага болно. Энэхүү авлага нь олборлогч компаниуд хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс Банкинд учруулсан алдагдал юм.

Дээрх үйл ажиллагаа нь Төв Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан дараах заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- (a) Засгийн газар болон банкнаас бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэх; ба
- (b) УИХ-аар зөвшөөрөгдсөнөөс бусад хуулийн этгээдүүдийн эдийн засгийн болон арилжааны үйл ажиллагааг дэмжихийн тулд балансын гадуурх гүйлгээ хийх.

### 17. Бусад актив

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Үүсмэл санхүүгийн хэрэгслүүд	11,195	7,304
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	13,102	-
Бусад	216	391
	24,513	7,695
Хасах нь: Унийн бууралтын алдагдал	(10)	(10)
	24,503	7,685

Үүсмэл санхүүгийн хэрэгсэл нь алтны форвард, опшин хэлцэл зэрэг Банкны үүсмэл санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээний хэрэгжээгүй ашгийг илэрхийлнэ.

Бусад нь ажилтнуудад олгосон урьдчилгаа, урьдчилж хийсэн төлбөр, бичиг хэргийн болон аж ахуйн материал юм.

# МОНГОЛБАНК

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (ургэлжлэл)

## 18. Үндсэн хөрөнгө

	Байшин барилга. сая төгрөг	Тавилга тоног төхөөрөмж сая төгрөг	Компьютер сая төгрөг	Тээврийн хэрэсэл сая төгрөг	Нийт сая төгрөг
<b>Өргөтөг/үнэлгээ</b>					
2006 оны 1 дугаар сарын 1-ний өдөр	16,846	1,640	1,007	842	20,335
Нэмэгдсэн	-	22	1,592	-	1,614
Шилжүүлсэн	-	-	-	-	-
Борлогдсон	-	(2)	(24)	(39)	(65)
Хасагдсан	-	(22)	(52)	(27)	(101)
2006 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	16,846	1,638	2,523	776	21,783
Дахин толилуулснаар	6,466	1,638	2,523	776	11,403
Өргөтөөр	10,380	-	-	-	10,380
Үнэлгээгээр	16,846	1,638	2,523	776	21,783
<b>Хүримтлагдсан элэгдэл</b>					
2006 оны 1 дугаар сарын 1-ний өдөр	1,423	446	570	333	2,772
Тухайн жилийн элэгдэл	299	171	286	121	877
Борлогдсон	-	(1)	(18)	(39)	(58)
Хасагдсан	-	(19)	(38)	(27)	(84)
2006 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	1,722	597	800	388	3,507
Бүртгэлийн цэвэр үнэ					
2006 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	15,124	1,041	1,723	388	18,276

### Дахин үнэлгээ

2002 оны 5 дугаар сарын 27-ны өдөр нээлттэй зах зээлийн мэдээлэлд үндэслэн Захирлуудын хийсэн үнэлгээгээр зарим барилгуудыг үнэлсэн.

Хэрвээ дахин үнэлсэн барилыг өргөтөөр нь бүртгэсэн бол 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд барилтын бүртгэлийн цэвэр дунг 494 сая (2005 : 622 сая) төгрөгөөр тусгах байсан болно.

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (ургэлжлэл)**

**18. Үндсэн хөрөнгө (ургэлжлэл)**

Өргөгчүүдэл	Байшин барилга сая төгрөг	Тавилга тоног төхөөрөмж сая төгрөг	Компьютер сая төгрөг	Тээврийн хэрэгслэл сая төгрөг	Дуссаагүй барилга сая төгрөг	Нийт сая төгрөг
2005 оны 1 дугаар сарын 1-ний өдөр	16,525	1,200	980	836	373	19,914
Номэцсэн	11	442	149	10	168	780
Шилжүүлсэн	412	22	-	-	(434)	-
Борлогдсон	(29)	(15)	(75)	-	-	(119)
Хасагдсан	(73)	(9)	(47)	(4)	(107)	(240)
2005 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	16,846	1,640	1,007	842	-	20,335
Дахин голилтуулнаар						
Өргөтөөр	6,466	1,640	1,007	842	-	9,955
Үнэлгэсгээр	10,380	-	-	-	-	10,380
	16,846	1,640	1,007	842	-	20,335
Хуримтлагдан эхийн элдүүлэл						
2005 оны 1 дугаар сарын 1-ний өдөр	1,054	309	513	235	-	2,111
Тухайн жилийн энэдээл	377	157	169	102	-	805
Борлогдсон	-	(12)	(67)	-	-	(79)
Хасагдсан	(8)	(8)	(45)	(4)	-	(65)
2005 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	1,423	446	570	333	-	2,772
Бүртгэлийн цэвэр үнэ						
2005 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	15,423	1,194	437	509	-	17,563

**Дахин үнэлгээл**

2002 оны 5 дугаар сарын 27-ны өдөр нээлттэй зах зээлийн мэдээлэлд үндэслэн Захиралуудын хийсэн үнэлгээгээр зарим барилгуудыг үнэлсэн.  
Хэрвээ дахин үнэлсэн барилыг өртөөр нь бүртгэсэн бол 2005 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланд барилгын бүртгэлийн цэвэр дунг 622 сая (2004 : 5,155 сая) төгрөгөөр тусгах байсан болно.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 18. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Тайлант жилд Банк нь байшин барилгын ашиглалтын хугацааг өөрчилсөн. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын энэхүү өөрчлөлт нь тухайн жилийн элэгдлийн зардлыг 108.77 сая төгрөгөөр бууруулсан бөгөөд мөн дунгээр Банкны энэ жилийн алдагдлыг бууруулах нөлөөллийг үзүүлсэн болно.

#### 19. Гаргасан үнэт цаас

Энэ нь Банкнаас дотоодын санхүүгийн байгууллагуудад гаргасан үнэт цаас болно. Үнэт цаасны хугацаа нь нэг долоо хоногоос гурван сар (2005: гурав хоногоос гурван сар) бөгөөд жилийн хүү нь 4.5% - 12% (2005: 1.89% - 9.13%) байна.

#### 20. Гадаад өр төлбөр

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Олон Улсын Валютын Сан (“ОУВС”)		
- ЯБӨХХ-ийн зээл	35,822	42,902
- Зээлжих тусгай эрхийн хуваарилалт	89,371	91,840
Герман Улсын Засгийн газраас авсан зээл	12,951	12,516
Азиин Хөгжлийн Банкнаас авсан зээл (“АХБ”)	9,005	7,751
Дэлхийн банк ба ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	1,756	2,078
Нэгдсэн үндэсний хөгжлийн хөтөлбөрөөс авсан туслаамж	151	151
Лондонгийн HSBC-ээс авсан зээл	1,577	1,638
	150,633	158,876

#### Олон Улсын Валютын Сан (“ОУВС”)

##### (i) Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрөөр авсан зээл (“ЯБӨХХ”)

Ядуурлыг бууруулах өсөлтийг хангах хөтөлбөрийн (ЯБӨХХ, хуучин нэрээр Бүтцийн өөрчлөлтийг дэмжих хөтөлбөр) хүрээнд ОУВС-аас олгосон зээл нь 10 жилийн хугацаатай, жилийн 0.5% (2005: 0.5%)-ийн хүйтэй. Гүйцэтгэлийн шалгуур болон хөтөлбөрийн гүйцэтгэлийг хянаж үзсэний үндсэн дээр эдгээр зээл нь гурван жилийн хугацаатайгаар олгогдож байна. Зээл болон түүний эргэн төлөлт нь ЗТЭ-ээр хийгдэнэ.

##### (ii) Зээлжих тусгай эрхийн хуваарилалт (“ЗТЭ”)

ОУВС-д оруулсан хөрөнгийнх нь хувь хэмжээгээр ЗТЭ-ийг ОУВС-ийн гишүүн орнуудад хуваарилдаг. Тус хуваарилалт нь ОУВС-ийн хөрөнгийг илэрхийлэх бөгөөд түүнтэй тэнцэх хэмжээгээр ОУВС-аас ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн хөрөнгийг хүлээж авдаг. ОУВС-ийн нийт хөрөнгө нь жилийн эцсээр 50.976 сая ЗТЭ (2005: 50.967 сая ЗТЭ), буюу 89,371 сая төгрөг (2005: MNT 91,840 сая төгрөг) байна.

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### 20. Гадаад өр төлбөр (үргэлжлэл)

#### Герман Улсын Засгийн газраас авсан зээл

Хоёр тусдаа хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй энэхүү зээл нь Германы Засгийн Газраас жижиг, дунд аж ахуйн нэгжийг дэмжих зорилготой. Хоёр хөтөлбөрийн хүрээнд европого олгогдож буй зээл нь 40 жилийн хугацаатай. 1 дэх хөтөлбөрийн зээл нь 1995 онд олгогдож эхэлсэн, жилийн 0.75%-ийн хүйтэй (2005: 0.75%). Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 оноос эхэлсэн. 2 дахь хөтөлбөрийн зээл нь 2002 онд олгогдож эхэлсэн, жилийн 0.75%-ийн хүйтэй (2005: MNT 0.75%). Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2012 оноос эхэлнэ.

#### Азийн Хөгжлийн Банкнаас авсан зээл (“АХБ”)

АХБ-ны зээл нь Монгол Улсад ядуурлыг бууруулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хөгжүүлэх мөн Засгийн Газар, төрийн бус байгууллагууд, дотоодын арилжааны банкуудад сургалтын болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх үндсэн зорилготой. Зээл нь жилийн 1%-1,5%-ийн хүйтэй (2004: 1% - 1.5%), 25-30 жилийн хугацаатай.

#### Дэлхийн банк ба Олон улсын хөгжлийн агентлаг (“ОУХА”)-т оруулсан хувь хөрөнгө

Энэ үлдэгдэл нь Банкнаас Дэлхийн банк ба ОУХА-д оруулсан хувь хөрөнгө юм.

#### Нэгдсэн үндэсний хөгжлийн хөтөлбөрөөс авсан тусlamж

Энэ нь Монгол улсад банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэсний Хөгжлийн Хөтөлбөрийн хүрээнд олгосон тусlamж юм. Энэхүү эх үүсвэрийг жижиг зээлээр дамжуулан орлого багатай хүмүүст олгож байна.

#### Лондонгийн HSBC-ээс авсан зээл

Энэ нь 865,000 фунт стерлингийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор Лондонгийн HSBC банкнаас 10 жилийн хугацаатайгаар авсан зээл юм. Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 оноос эхлэх бөгөөд хүүг HSBC банкны жилийн үндсэн хүүн дээр 1.75%-ийг нэмж тооцно.

### 21. Засгийн газрын байгууллагуудын хадгаламж

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Улсын төсвийн болон засгийн газрын бусад дансд	1,572	271
СЭЗЯ-ны данс	403,557	90,027
	405,129	90,298

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### 21. Засгийн газрын байгууллагуудын хадгаламж (үргэлжлэл)

#### Улсын төсвийн болон засгийн газрын бусад дансд

Эдгээр харилцах дансд нь Банкинд байршуулсан Засгийн газрын байгууллагуудын төгрөгийн харилцах дансд юм. Эдгээр харилцах дансанд хүү тооцдоггүй болно.

#### Санхүү Эдийн Засгийн Яамны дансууд

Эдгээр нь СЭЗЯ-наас Банкинд байршуулсан харилцах дансууд юм. Эдгээр дансуудын хувьд 81,550 сая төгрөгийн хугацаат хадгаламж (жилийн 5.14%-ийн хүйтэй, 79 хүртэлх хоногийн хугацаатай), 68,128 сая төгрөгийн хугацаагүй хадгаламж (0.5%-ийн хүйтэй)-аас бусад нь хүү тооцдоггүй болно.

### 22. Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж

Эдгээр нь дотоодын санхүүгийн байгууллагуудаас Банкинд байршуулсан хадгаламж болон заавал байлгах нөөцөөс бүрдэх бөгөөд банкуудын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тодорхой хувиар тооцож заавал байлгах нөөцийг тогтоодог.

Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламжинд 11,808.81 сая төгрөгийн дүнтэй буцаан худалдан авах гэрээ мөн багтсан байгаа (2005: Тэг).

### 23. Бусад өр төлбөр

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг шинэчилсэн
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	11,272	7,222
Нийгмийн хөгжлийн сан	1,260	905
Бусад өглөг	15,423	2,982
	27,955	11,109

Үүсмэл санхүүгийн хэрэгсэл нь алтны форвард, опшин хэлцэл зэрэг Банкны үүсмэл санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээний хэрэгжээгүй алдагдлыг илэрхийлнэ.

### 24. Дүрмийн сан

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Дүрмийн сан	5,000	5,000

Монголбанк нь 100 хувийн Төрийн өмч болно. Дүрмийн сан нь Банкны өөрийн хөрөнгө юм.

## МОНГОЛБАНК

**2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн  
Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)**

### 25. Бусад сан

Бусад сангүүд нь өрөнхий нөөцийн болон дахин үнэлгээний сангаас бүрдэнэ.

Монгол Улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу Төв банкны жилийн цэвэр ашгийн 40-өөс доошгүй хувийг өрөнхий нөөцийн санд хуваарилж, үлдэх хэсгийг Улсын төсөвт шилжүүлдэг. Тайлант жилд Банк нь алдагдалтай ажилласан учраас Ерөнхий Нөөцийн Сан болон Улсын төсөвт цэвэр ашгийн ямар нэгэн шилжүүлэлт хийгээгүй байна.

Дахин үнэлгээний санд санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжээгүй ашиг, алдагдлыг бүртгэдэг.

### 26. Улсын төсөвт шилжүүлсэн

Төв Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар Монголбанкны цэвэр ашгийг дараах дарааллаар хуваарилна. Үүнд:

- цэвэр орлогын 40-өөс доошгүй хувийг өрөнхий нөөцийн санд;
- дээрх хувийг хасаад цэвэр орлогын үлдэх хэсгийг Улсын Төсөвт.

### 27. Санхүүгийн хүлээх үүрэг болон болзошгүй зүйлс

	2006 сая төгрөг	2005 сая төгрөг
Аkkreditiv	64,132	24,335

### 28. Холбогдох этгээдийн тодруулга

Нэг этгээд нөгөө этгээдийнхээ санхүүгийн буюу үйл ажиллагааны шийдвэрт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвартай бол холбоотой талууд гэж үздэг. Банк нь 100 хувийн төрийн өмч юм.

Банкны Ерөнхийлөгч болон Захирлуудын Зөвлөлийн гишүүдэд олгосон 43,0 сая (2005: 33,0 сая) төгрөгийн цалин, урамшууллаас өөр холбоотой талуудын ажил гүйлгээ тухайн жилд гараагүй байна.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 29. Санхүүгийн эрсдлийн удирдлагын бодлого

##### *Санхүүгийн эрсдлийн удирдлагын зорилго ба бодлого*

Банк нь үйл ажиллагаагаа зөв зохистой явуулахын тулд Захирлуудын Зөвлөлөөс гаргасан журам, заавар, шийдвэрийн дагуу хүүгийн, зээлийн, зах зээлийн болон төлбөрийн чадварын эрсдлийг удирдаж байна.

##### *Гадаад нөөцийн эрсдэл*

Гадаад валютын улсын нөөцийг удирдахад тулгардаг зээлийн, зах зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдлүүдэд тулхүү анхаарч, эдгээр эрсдлийг зохицуулах, хянах, удирдах, бууруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг “Гадаад валютын нөөцийн удирдлагын журам”-д тусгасан байна. Үүнд:

##### **а) Зээлийн эрсдлийг бууруулах зорилгоор:**

- Гадаад нөөцийг АНУ, Япон, ХБНГУ, Англи, Швейцари зэрэг хөгжингүй орнуудын төв банк дахь харилцах данс, ААА болон АА зэрэглэлтэй гадаадын арилжааны банкууд дахь хадгаламж, мөн дээрх орнуудын Засгийн газрын үнэт цаас, олон улсын болон бус нутгийн санхүүгийн байгууллагын үнэт цаас зэрэгт байршуулдаг.
- Нөөцийн зарим хэсгийг уламжлалт харилцаатай арай доогуур зэрэглэлийн улс орон, банкинд байршуулж байна. Ийм нөхцөлд тухайн тохиолдол бүрийг тусгайлан авч үзэж, холбогдох тооцоо судалгаа хийн асуудлыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж шийдвэрлүүлж байна.
- Мөн нөөцийн активыг байршуулах гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт олгох хязгаарыг улирал бүр Захирлуудын Зөвлөл болон Ерөнхийлөгчид танилцуулан батлуулж байна.

##### **б) Зах зээлийн эрсдлийг тодорхой түвшинд байлгаж, хянан зохицуулж байх үүднээс:**

- Нөөцийн активын ерөнхий бүтцийг жилээр,
- Алт болон гадаад валютын нийт нээлттэй позицийн хязгаарыг улирлаар,
- Санхүүгийн хэрэгсэл тус бүрээр нээлттэй позицийн хязгаарыг улирлаар,
- Дилер тус бүрийн стоп-лосс хязгаарыг улирлаар тус тус батлуулан мөрдөж байна.

##### **в) Гадаад нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдлийг удирдах зорилгоор:**

- харилцах дансны үлдэгдэл, касс дахь бэлэн валютын доод хэмжээ,
- тодорхой хугацаагаар байршуулах активын доод, дээд хэмжээг тус тус тогтоодог,
- активын дуусгавар хугацааг төлбөр түргэн гүйцэтгэх чадварт зохицуулан тогтоодог.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууставар болсон жилийн Санхүүтийн тайлангийн тодотгоол (үргэлжлэл)

#### Валютын эрсдэл

Банкны санхүүтийн байдал болон мөнгөн гүйлгээнд гадаад валютын ханшийн өөрчлөлт нөлөөлдөг. Банкны удиурдлага нь гадаад валютын (голчлон ам.доллар) ханшийн эрсдэлд хязгаарлалт тогтоодог. Банкны тадаад валютын ханшийн эрсдэл.

Актив	2006 (сая төгрөг)			
	Төгрөг	Ам.доллар	ЗТЭ	Бусад валют
Бэлэн мөнгө	40	10,285	-	10,467
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулжт	33,696	23,276	-	-
Булаан худалдан авах гарээ	748	115,219	-	-
Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, хадгаламж	90,515	456,463	8	69,602
Дотоодын санхүүгийн байгууллагад олгосон зээл, урьдчилгаа	7,841	1	-	10,531
Санхүү Эдийн Засгийн Яаманд олгосон урьдчилгаа	-	-	35,822	-
Аж ахуйн нэгжид олгосон урьдчилгаа	1,521	4,635	-	-
Бусад актив	24,440	33	-	30
	158,801	609,912	35,820	90,630
				895,173
Пасив				
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(245,099)	-	-	-
Гаргасан үнэт цаас	(70,845)	-	-	-
Гадаад өр төлбөр	(94,547)	(5,737)	(35,822)	(14,527)
Засгийн газрын байгууллагудын хадгаламж	(245,634)	(159,495)	-	-
Дотоодын санхүүгийн байгууллагын хадгаламж	(111,381)	(34,328)	-	(2,833)
Бусад пассив	(27,708)	(134)	-	(113)
	(795,214)	(199,694)	(35,822)	(17,473)
Цэвэр позиции	(636,413)	410,218	8	73,157
				(153,030)

## МОНГОЛБАНК

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн

### 29. Санхүүгийн эрсдлийн удирдлын бодлого (Үргэлжлэл)

#### Валютын эрсдэл (Үргэлжлэл)

	Төгрөг	АМ.доллар	ЗТЭ	2006 (сая төгрөг)	
				Бусад валют	Нийт
<b>Актив</b>					
Бэлэн мөнгө	48	5,319	-	6,749	12,116
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулант	-	-	-	28,616	28,616
Будаан худалдан авах гэрээ	-	59,707	-	-	59,707
Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,128	233,840	92,103	76,329	403,400
Дотоодын санхүүгийн байгууллагад олгосон зээл, урьдчилгаа	7,887	2	-	9,726	17,615
Санхүү Эдийн Засгийн Яаманд олгосон урьдчилгаа	-	94,373	42,902	-	137,275
Аж ахуйн нэгжид олгосон урьдчилгаа	50	10,422	-	-	10,472
Бусад актив	165	7,491	-	29	7,685
	9,278	411,154	135,905	121,449	676,886
<b>Пасив</b>					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(191,686)	-	-	-	(191,686)
Гаргасан үнэт цаас	(125,713)	-	-	-	(125,713)
Гадаад өр төлбөр	(97,213)	(4,607)	(42,902)	(14,154)	(158,876)
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	(48,124)	(38,603)	(1)	(3,570)	(90,298)
Дотоодын санхүүгийн байгууллагын хадгаламж	(58,410)	(25,353)	-	(5,785)	(89,548)
Бусад пассив	(1,414)	(9,589)	-	(106)	(11,109)
	(522,560)	(78,152)	(42,903)	(23,615)	(667,230)
<b>Цэвэр позиции</b>	<b>(513,282)</b>	<b>333,002</b>	<b>92,102</b>	<b>97,834</b>	<b>9,656</b>

Аудиторын тайлан

## 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотоол (ургэлжлэл)

### 29. Санхүүгийн эрсдлийн удирдлын бодлого (Ургэлжлэл)

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн актив, пассивын хугацаагаарх ангилал болон үр ашигт хүйт доорхи хүснэгтэд үзүүлэв.

(сая тооцоогоор)

	3 сараас доош	3 - 6 сар	6 сараас 1 жил	1 - 5 жил	> 5 жил	Хүнд мэдрэмжий	Нийт	Үр ашигт хүй
<b>Актив</b>								
Балэн мөнгө	-	-	-	-	-	20,792	20,792	-
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	23,276	-	-	33,696	-	-	56,972	3.20%
Булаан худалдан авах гэрээ	115,967	-	-	-	-	-	115,967	4.96%
Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, хадгаламж	502,229	-	-	-	-	114,359	616,588	4.72%
Дотоодын санхүүгийн байгууллагад олгосон зээл, урьдчилга	3	4,762	2,897	10,710	1	-	18,373	3.93%
Санхүү Эдийн Засгийн Яаманд олгосон урьдчилгаа	-	-	-	35,822	-	-	35,822	0.50%
Аж ахуйн нэгжид олгосон урьдчилгаа Бусад актив	-	-	-	-	-	6,156 24,503	6,156 24,503	-
	<b>641,475</b>	<b>4,762</b>	<b>2,897</b>	<b>80,228</b>	<b>1</b>	<b>165,810</b>	<b>895,173</b>	
<b>Пассив</b>								
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	-	-	-	-	-	(245,099)	(245,099)	-
Гаргасан үнэт цаас	(70,845)	-	-	-	-	-	(70,845)	5.49%
Гадаад өр төлбөр	(197)	-	-	(985)	(54,831)	(94,620)	(150,633)	1.79%
Засгийн газрын байгууллагудын хадгаламж	(81,550)	-	-	-	(68,128)	(255,451)	(405,129)	2.08%
Дотоодын санхүүгийн байгууллагын хадгаламж	(12,042)	-	-	-	(3,449)	(133,051)	(148,542)	4.67%
Бусад пассив	(113)	-	-	-	-	(27,842)	(27,955)	6.75%
	<b>(164,747)</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>(985)</b>	<b>(126,408)</b>	<b>(756,063)</b>	<b>(1,048,203)</b>	
<b>Цэвэр позиции</b>	<b>476,728</b>	<b>4,762</b>	<b>2,897</b>	<b>79,243</b>	<b>(126,407)</b>	<b>(590,253)</b>	<b>(153,030)</b>	
<b>Хүримтгэлдэн зөрүү</b>	<b>476,728</b>	<b>481,490</b>	<b>484,387</b>	<b>563,630</b>	<b>437,223</b>	<b>(153,030)</b>		

Банкны санхүүгийн актив, пассивын хүлээгдэж буй дууставар болох хугацаа нь гэрээнд зассан хугацаанаас үлээж зөрүүгүй байна. Хүүний мэдрэмжтүй санхүүгийн актив, пассив нь шаардах тохиолдолд төлөгдөх болно.

## 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгоол (Ургэлжлэл)

### 29. Санхүүгийн эрдлийн удирдлын бодлого (Ургэлжлэл)

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн актив, пассивын хугацаагаарх ангилаал болон ур ашигт хүүг доорхи хүснэгтэд Үзүүлэв.

(сая тооцоогдох)

Актив	3 сараас доош	3 - 6 сар	6 сараас 1 жил	1 - 5 жил	> 5 жил	Хүчинд мэдрэмжтэй	Нийт	Үр ашигт хүүг
<b>Актив</b>								
Бэлэн мөнгө	-	-	-	-	28,616	-	12,116	12,116
Гадаадын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	59,707	-	-	-	-	-	28,616	3,52%
Булаан худаадан авах гэрээ	-	-	-	-	-	-	59,707	3,44%
Гадаадын санхүүгийн байгууллагад, байршуулсан хөрөнгө, хадгаламж	289,732	13,435	-	-	-	100,233	403,400	3,69%
Дотоодын санхүүгийн байгууллагад олгосон зээл, урьдчилгаа	2,152	1,355	3,448	10,660	-	-	17,615	4,14%
Санхүү Эдийн Засгийн Яаманд олгосон урьдчилгаа	2,131	725	13,804	84,608	36,007	-	10,472	137,275
Аж ахуйн нэгжид олгосон урьдчилгаа	-	-	-	-	-	-	10,472	-
Бусад актив	-	-	-	-	-	-	7,685	7,685
<b>Пассив</b>	<b>353,722</b>	<b>15,515</b>	<b>17,252</b>	<b>95,268</b>	<b>64,623</b>	<b>130,506</b>	<b>676,886</b>	
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	-	-	-	-	-	(191,686)	(191,686)	-
Гаргасан үнэт цаас	(125,713)	-	-	-	-	-	(125,713)	4,75%
Гадад өр төлбөр	(2,313)	(725)	(2,456)	(30,316)	(28,997)	(94,069)	(158,876)	0,90%
Засгийн газрын байгууллагудын хадгаламж	-	-	-	-	-	(90,298)	(90,298)	-
Дотоодын санхүүгийн байгууллагын хадгаламж	(3,819)	-	-	-	-	(85,729)	(89,548)	4,00%
Бусад пассив	(106)	-	-	-	-	(11,003)	(11,109)	-
	(131,951)	(725)	(2,456)	(30,316)	(28,997)	(472,785)	(667,230)	
<b>Цэвэр позиции</b>	<b>221,771</b>	<b>14,790</b>	<b>14,796</b>	<b>64,952</b>	<b>35,626</b>	<b>(342,279)</b>	<b>9,656</b>	
<b>Хүримтлагдсан зөрүү</b>	<b>221,771</b>	<b>236,561</b>	<b>251,357</b>	<b>316,309</b>	<b>351,935</b>	<b>9,656</b>		

Банкны санхүүгийн актив, пассивын хүлээгдэж буй дуусгавар болох хугацаа нь тэрээнд заасан хугацаанаас үлмэж зөрүүгийн байна. Хүүний мэдрэмжтэй санхүүгийн актив, пассив нь шаардах тохиолдолд төлөгдхөн болно.

## МОНГОЛБАНК

### 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн тайлангийн тодотгол (үргэлжлэл)

#### 30. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэлгээ

Санхүүгийн хэрэгсэл нь санхүүгийн актив, санхүүгийн пассиваас бүрдэнэ. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ гэдэг нь тухайн санхүүгийн хэрэгслийг мэдлэгтэй, холбоотой бус талуудын хооронд солилцох дүн юм.

2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бараг бүх санхүүгийн хэрэгсэл нь богино хугацаатай буюу нэг жилээс доош хугацаатай байна. Эдгээр санхүүгийн актив, пассивын тайлан тэнцлийн өдрөөрх тооцоолсон бодит үнэ нь тэнцэлд тусгагдсан бүртгэлийн дүнтэй ойролцоо байна.

#### 32. Харьцуулсан үзүүлэлтүүд

2004 онд Банк нь 10 жилийн хугацаатай зээлээр санхүүжигдсэн 865,000 фунт стерлингийн үнэтэй үндсэн хөрөнгийг олж авсан. Гэвч эдгээр гүйлгээнүүд нь 2004, 2005 оны санхүүгийн тайлангуудад тусгагдалгүй орхигдсон байна. Имээс энэ алдааг засахын тулд 2005 оны харьцуулалтыг шинэчлэн тайлагнасан болно. Ингэж шинэчлэн тайлагнаасны нөлөөлөл нь дараах байдалтай байна:

	шинэчлэн тайлагнааснаар сая төгрөг	өмнөх тайлагнааснаар сая төгрөг
<b>Орлогын тайлан</b>		
Гадаад валютын алдагдал	3,175	3,351
Захиргааны зардал	4,805	4,774
Үйл ажиллагааны бусад зардал	3,964	3,849
Тухайн жилийн ашиг	8,640	8,610
<b>Тайлан тэнцэл</b>		
Үндсэн хөрөнгө	17,563	16,175
Гадаад өр төлбөр	158,876	157,238
Бусад пассив	11,109	11,003
<b>Өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
2005 оны 1 сарын 1-нээрх хуримтлагдсан алдагдал	5,861	5,475
2005 оны 12 сарын 31-нээрх хуримтлагдсан ашиг (алдагдал)	(350)	6

#### 33. Монгол орчуулгын талаар

Энэхүү санхүүгийн тайлангуудыг мөн монгол хэл дээр бэлтгэн гаргасан болно. Англи болон Монгол хувиудын хооронд утга агуулгын зөрүү гарсан тохиолдолд Англи хувийг баримтлах болно.

## Хавсралт 1. Дэлхийн эдийн засгийн тойм

Дэлхийн эдийн засгийн өсөлт тайлант онд 5.1 хувьд, 2007 онд 4.9 хувьд хүрэх төлөвтэй байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт 1970-аад оны эхэн үеэс хойш анх удаа 4 жил тасралтгүй өсч байна. Энэ нааштай хандлага нь гол гол Төв банкуудын хүү өсч байгаа ч инфляцийн дарамт хязгаарлагдсан, хөгжингүй орнуудын дотоод эрэлт өндөр, хөгжиж буй орнууд тулгарч буй саад бэрхшээлээ хялбар замаар шийдвэрлэж байгаа, дэлхийн санхүүгийн зах зээл улам тогтворжиж байгаа зэрэгтэй холбоотой юм. Эдгээрийг дэлгэрүүлж авч үзье.

- АНУ-ын эдийн засгийн өсөлт тайлант онд 3.4 хувь, 2007 онд 2.9 хувьд хүрэх төлөвтэй байна.
- Евро бүсийн эдийн засаг тайлант онд 2.4 хувиар өсөх төлөвтэй байгаа нь сүүлийн 6 жилийн хамгийн өндөр өсөлт бөгөөд 2007 онд 2 хувь болон буурах хандлагатай байна. Корпорациудын тогтвортой үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөхцөл болж байна.
- Японы эдийн засаг өндөр эрэлтийн улмаас 2.7 хувиар нэмэгдэх хандлагатай байна. Ирэх жил хурд нь бага зэрэг буурч 2.1 хувьд хүрэх төлөвтэй байна.
- Хөгжиж буй улсуудын өсөлт хүчтэй хэвээрээ буюу 7.3 хувиар өсөхөөр байна. Ялангуяа, Хятадын эдийн засаг 10 орчим хувиар өсөхөөр байна. Мөн Энэтхэг, ОХУ-ын эдийн засгийн өсөлт өндөр хэвээр байна. Харин Латин Америкийн орнуудын хөгжил хоцрогдсон хэвээр байгаа боловч энэ бүсийн өсөлтийн хэтийн төлөвт нааштай хандлага бий болж байна.
- Хөгжингүй орнуудын инфляци тайлант онд 2.6 хувьд хүрч байгаа ч газрын тосны үнийн өсөлтөөс бий болж буй нөлөөлөл саарч байгаагаас 2007 оноос эхлэн инфляци буурах хандлагатай байна. Хөгжиж буй улсуудын хувьд ч инфляцийн дарамт багасч байна.
- Япон, Азийн зарим хөгжиж буй орнууд, Ойрхи Дорнод болон бусад газрын тос экспортлогч орнууттай хийсэн гадаад худалдаанаас АНУ-ын урсгал алдагдал өсч 2007 онд ДНБ-ий 6.9 хувьд хүрэхээр байна.
- Хөгжиж буй улсууд руу орох хувийн хөрөнгийн урсгал 2005 оноос багасч байгаа боловч тэдгээрийн нийт урсгал ашиг болон гадаад нөөц нь өсөх төлөвтэй байна.


## Хүснэгт 9.1 Дэлхийн эдийн засгийн тойм

(хувиар)


	2004	2005	2006	2007
	Урьдчилсан тооцоо			
<b>Дэлхийн үйлдвэрлэл</b>	5.3	4.9	5.1	4.9
Хөгжингүй орнууд	3.2	2.6	3.1	2.7
АНУ	3.9	3.2	3.4	2.9
Европын бүс	2.1	1.3	2.4	2.0
Герман	1.2	0.9	2.0	1.3
Франц	2.0	1.2	2.4	2.3
Итали	1.1	-	1.5	1.3
Испани	3.1	3.4	3.4	3.0
Япон	2.3	2.6	2.7	2.1
Их Британи	3.3	1.9	2.7	2.7
Канад	3.3	2.9	3.1	3.0
Бусад хөгжингүй орнууд	4.6	3.7	4.1	3.7
Шинээр аж үйлдвэржсэн Азийн улсууд	5.9	4.5	4.9	4.4
<b>Хөгжих буй орнууд</b>	<b>7.7</b>	<b>7.4</b>	<b>7.3</b>	<b>7.2</b>
Африк	5.5	5.4	5.4	5.9
Төв болон Зүүн Европын орнууд	5.6	5.8	5.2	6.3
Тусгаар Тогтносон Улсуудын Хамтын Нэхөрлөлийн орнууд	8.4	6.5	6.8	6.5
ОХУ	7.2	6.4	6.5	6.5
ОХУ-ыг оруулаагүй	11.0	6.7	7.6	6.4
Хөгжих буй Азийн орнууд	8.8	9.0	8.7	8.6
Хятад	10.1	10.2	10.0	10.0
Энэтхэг	8.0	8.5	8.3	7.3
Зүүн Омнөд Азийн Улсуудын Холбоо	5.8	5.1	5.0	5.6
Ойрхи Дорнод	5.5	5.7	5.8	5.4
Дэлхийн бөмбөрцгийн баруун хэсэг	5.7	4.3	4.8	4.2
Бразил	4.9	2.3	3.6	4.0
Мексик	4.2	3.0	4.0	3.5
<b>Дэлхийн худалдааны хэмжээ бараа, үйлчилгээ</b>				
<b>Импорт</b>				
Хөгжингүй орнууд	9.1	6.0	7.5	6.0
Хөгжих буй орнууд	16.4	11.9	13.0	12.1
<b>Экспорт</b>				
Хөгжингүй орнууд	8.8	5.5	8.0	6.0
Хөгжих буй орнууд	14.6	11.8	10.7	10.6
<b>Гол иэрийн түүхий эдийн үзэ ам. доллараар</b>				
Газрын тос	30.7	41.3	29.7	9.1
Шатахуун төрлийн бус түүхий эд	18.5	10.3	22.1	-4.8
<b>Хэрэглээний барааны үнэ</b>				
Хөгжингүй орнууд	2.0	2.3	2.6	2.3
Хөгжих буй орнууд	5.6	5.3	5.2	5.0
<b>Лондонгийн банк хоорондын захын хүү /6 сараар/</b>				
Ам. долларын хадгаламж	1.8	3.8	5.4	5.5
Еврогийн хадгаламж	2.1	2.2	3.1	3.7
<b>Японы иенний хадгаламж</b>	<b>0.1</b>	<b>0.1</b>	<b>0.5</b>	<b>1.1</b>

Эх үүсвэр: OYBC

Зураг 9.1 Дэлхийн бодит ДНБ-ий өсөлт



Зураг 9.2 Дэлхийн инфляци



## Дэлхийн зах зээлийн ханш, хүү

Ихэнх хөгжингүй орнуудын инфляци газрын тосны өсч буй үнийн улмаас зарим үед Төв банкуудын зорилтот хэмжээнээс давж, улмаар суурь инфляци болон инфляцийн хүлээлт, нэгж хөдөлмөрийн зардал /ялангуяа, АНУ-д/ өсөх шинж тэмдгүүд илэрч байв.

Хөгжих буй, ялангуяа, Аргентин, Энэтхэг, Орос, Өмнөд Африк, Турк, Венесуэль улсуудад эдийн засгийн өсөлт болон их хэмжээний валютын ханшийн сулралаас үүдсэн инфляцийн дарамт нүүрлэж байна.

АНУ-ын Нөөцийн банк зургаадугаар сард Нөөцийн сангийнхаа хүүг өсгөсөн боловч эдийн засгийн өсөлт нь саарч байгаатай уялдуулан инфляцийг тогтвортжуулах зорилгоор наймдугаар сард хүүгээ өсгөхөө зогсоов.

Европын Төв банк бодлогынхоо хүүг өсгөж, Японы Төв банк зөвлөн мөнгөний бодлогоо өөрчилж, бодлогын овернайт хүүгээ 0-0.25 болгожээ. Австрали, Швед, Их британи улсуудын Төв банкууд мөн бодлогоо чангаруулсан байна. Урт хугацаатай Засгийн газрын бондын өгөөж сүүлийн 25 жилийн дунджаас бага зэрэг доогуур түвшинд байгаа боловч нэмэгдсэн байна.

Урт хугацаатай засгийн газрын бондын хүү өсч байгаа ч сүүлийн 25 жилийн дундажтай харьцуулахад харьцангуй бага түвшинд байна.

Өмнөх 12 сарын туршид чангарт байсан америк доллар 2005 оны сүүлчээс евро болон иенийн эсрэг суларч эхэлжээ.

Америк долларын бодит үйлчилж буй ханш 1980 оноос хойшхи дундажтайгаа ойролцоо түвшинд байгаа бол евро урт хугацааны дунджаасаа арай дээгүүр, иен арай доогуур байна.

2006 оны гуравдугаар сараас эхлэн Исланд, Шинэ Зеланд, Унгар зэрэг урсгал алдагдал ихтэй орнуудын мөнгөний ханш нэлээд суларсан байна.

### Хүснэгт 9.2 Хэрэглээний үнэ, жилийн өөрчлөлт

(хувиар)

	2004	2005	2006	2007
	урьдчилсан			
<b>Хөгжингүй орнууд</b>	<b>2.0</b>	<b>2.3</b>	<b>2.6</b>	<b>2.3</b>
АНУ	2.7	3.4	3.6	2.9
Евро бүс	2.1	2.2	2.3	2.4
Герман	1.7	2.0	2.0	2.6
Франц	2.3	1.9	2.0	1.9
Итали	2.3	2.3	2.4	2.1
Испани	3.1	3.4	3.8	3.4
Нederland	1.4	1.5	1.7	1.8
Белги	1.9	2.5	2.4	1.9
Австри	2.0	2.1	1.8	1.7
Финлянд	0.1	0.8	1.5	1.5
Грек	3.0	3.5	3.6	3.5
Португали	2.5	2.1	2.6	2.2
Ирланд	2.3	2.2	2.8	2.5
Люксенбург	2.2	2.5	2.8	2.3


## Хүснэгт 9.2 Хэрэглээний үнэ, жилийн өөрчлөлт (үргэлжлэл)

(xyuuap)

	2004	2005	2006	2007
	урьдчилсан			
Япон	-	-0.6	0.3	0.7
Их британи	1.3	2.0	2.3	2.4
Канад	1.8	2.2	2.2	1.9
Солонгос	3.6	2.7	2.5	2.7
Австрали	2.3	2.7	3.5	2.9
Швед	1.0	0.8	1.6	1.8
Швецарь	0.8	1.2	0.9	1.2
Хонг Конг	-0.4	0.9	2.3	2.5
Сингапур	1.7	0.5	1.8	1.7
<b>Азийн хөгжжик буй орнууд</b>	<b>3.9</b>	<b>3.4</b>	<b>3.6</b>	<b>3.5</b>
Хятад	3.9	1.8	1.5	2.2
<b>Өмнөд Ази</b>	<b>4.2</b>	<b>4.8</b>	<b>6.0</b>	<b>5.6</b>
Энэтхэг	3.9	4.0	5.6	5.3
Пакистан	4.6	9.3	7.9	7.3
Бангладеш	6.1	7.0	6.8	6.1
<b>Азийн 4</b>	<b>4.6</b>	<b>7.5</b>	<b>8.6</b>	<b>4.5</b>
Индонез	6.1	10.5	13.0	5.9
Тайланд	2.8	4.5	4.9	2.6
Филиппин	6.0	7.6	6.7	5.0
Малайз	1.4	3.0	3.8	2.7
